



**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

Улаанбаатар хот
2019 он



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ.....	5
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН 2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА:	6
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ	15
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	16
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 84 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ (2019 оны 2 дугаар улирлын байдлаар)	42
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ (2019 оны 2 дугаар улирлын байдлаар).....	54
ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА	74
I. ИНФЛЯЦИ	74
II. БОДИТ СЕКТОР.....	75
2.1. Нийт нийлүүлэлт	75
2.2. Нийт эрэлт.....	80

III. УЛСЫН ТӨСӨВ.....	81
IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ.....	85
4.1. Төсөөлөлд ашигласан гадаад зах зээлийн таамаглал.....	85
4.2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл.....	90
4.3. Инфляцийн төсөөлөл.....	92
4.4. Төсөөллийн тодорхой бус байдал.....	96
V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	101
5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл.....	101
5.2. Орон сууцны зээлийн хөтөлбөр.....	104
5.3. Мөнгөний зах, хүүний түвшин.....	105
5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш.....	108
VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ.....	112
6.1. Төлбөрийн тэнцэл.....	112
6.2. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц.....	117
6.3. Монгол Улсын нийт гадаад өр.....	118
VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	124
7.1. Санхүүгийн салбар.....	124
7.2. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв.....	125
7.3. Банкны салбарын эрсдэл даах чадвар.....	129
ХАВСРАЛТ.....	133

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай.

- 1/ Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үзүүлэлтийг ахиулах арга хэмжээг авч, олон улсын холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах;
- 2/ Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дунд хугацаанд хадгалах, гадаад өр, төлбөрийг шийдвэрлэх чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах;
- 3/ Төв банкны гадаад өрийн хэмжээг бууруулж, Монгол Улсын гадаад валютын цэвэр нөөцийг тууштай нэмэгдүүлэх;
- 4/ Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, зээл олголтын зарчмыг олон улсын жишигт нийцүүлж, хэрэгжилтийг хангах;
- 5/ Банкны салбарын “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангаж, хууль эрх зүйн шинэ орчинг бий болгох;

Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г. ЗАНДАНШАТАР

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН 2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА:

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай.

1/ Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үзүүлэлтийг ахиулах арга хэмжээг авч, олон улсын холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах;

Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-аас 2017 онд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцооны 2 дахь удаагийн Харилцан үнэлгээг гүйцэтгэсэн. ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг (ОУХАХБ)-ээс Монгол Улс техникийн хэрэгжилтийн нийт 40 зөвлөмжөөс 50 хувьд нь, үр дүнтэй байдлын 11 үзүүлэлт тус бүр дээр хангалтгүй үнэлгээ авсан тул эрчимтэй хяналтанд оруулж, хугацаат үүрэг даалгавруудыг өгсөн. Монгол Улс ФАТФ-ын “саарал жагсаалт”-аас зайлсхийхийн тулд техникийн хэрэгжилтийн болон үр дүнтэй байдлын үнэлгээг сайжруулах шаардлагатай байв.

Монгол Улс хүлээсэн үүргийнхээ дагуу “Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г баталж, 2018 оны 10 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 31-нд ФАТФ-ын техникийн хэрэгжилтийг тайланг АНДББ-д хүргүүлж, 20 зөвлөмжийн үнэлгээг ахиулах хүсэлтийг гаргасан болно.

АНДББ-аас 2019 оны 5 дугаар сарын 22-нд ирүүлсэн албан бичигт Монгол Улсын техникийн хэрэгжилтийн 14 үзүүлэлтийн үнэлгээг ахиулах боломжтойг мэдэгдсэн байна.

ОУХАХБ-ийн эрчимтэй хяналтад байх хугацаа 2019 оны 6 дугаар сард дуусгавар болсноор ФАТФ-ын зөвлөмжийн биелэлт, эрчимтэй хяналтын хугацаанд авсан арга хэмжээ, шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүд дээр гарсан ахиц зэргийг шалгах үе шат эхэлж байна.

Монгол Улс хангалттай ахиц дэвшил гаргаагүй гэж ФАТФ-аас үзсэн тохиолдолд “саарал жагсаалт”-д оруулсныг зарлаж болзошгүй. Харин ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын чуулга уулзалтаар асуудал Монгол Улсын хувьд нааштай шийдвэрлэгдсэн тохиолдолд эрчимтэй хяналтад хэвээр үлдэхээр байна.

Иймд ФАТФ-ын шийдвэр яаж гарахаас үл хамааран 2020 онд Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны 2 дахь удаагийн харилцан үнэлгээний үр дүнг тууштай ахиулах шаардлага хэвээр

байна. Ялангуяа шууд хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг ахиулах нь Монгол Улсын үнэлгээг ахиулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Монгол Улс АНДББ, ФАТФ-тай идэвхтэй хамтран ажиллаж, Монгол Улсын харилцан үнэлгээний тайланд дурдсан сул тал, доголдлыг засч сайжруулах арга хэмжээ, үүний дотор дараах арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байна:

- Шууд хэрэгжилттэй холбоотой үзүүлэлтүүдийн хувьд бодитой үр дүнд хүрэх;
- МУТСТ Үндэсний зөвлөлөөс баталсан “Нэмэлт ажлын төлөвлөгөө”-г бүрэн дүүрэн хэрэгжүүлэх;
- Шууд хэрэгжилтийн тайлан хариуцсан Ажлын хэсгийг 2020-2021 онд үргэлжлүүлэн ажиллуулах;
- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд тусган батлах;
- Корреспондент банкны харилцааг алдахгүй байхад чиглэсэн бүхий л арга хэмжээг авах;
- Эрх бүхий байгууллагуудын зүгээс МУТСТ тухай хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Эрх бүхий байгууллагуудын МУТСТ чиг үүрэг бүхий нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, чадавхжуулах;
- Хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог үйл ажиллагааны болон бодлогын түвшинд хангаж ажиллах.

Монгол Улс МУТСТ тогтолцооны 2 дахь удаагийн харилцан үнэлгээний үр дүнг сайжруулахын тулд ФАТФ, АНДББ, ОУХАХБ, олон улсын бусад байгууллага, засгийн газруудтай цаашид ч идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

ШИГТГЭЭ 1. МОНГОЛ УЛСЫН МУТСТ ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Монголбанк нь МУТСТ хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу банкууд МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.

Санхүүгийн мэдээллийн алба (СМА) нь МУТСТ хуулийн 16 дугаар зүйлийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ)-ээс сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, бусад тайлан мэдээ хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, МУТС-тэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээний талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм. МУТСТ хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу СМА нь банк бус сектор болон үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-той хамтран хяналт тавина.

СЗХ нь МУТСТ хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу ББСБ-ууд, ХЗХ-д, хөрөнгө оруулалтын сангууд, үнэт цаас, даатгал, үл хөдлөх хөрөнгийн компаниуд МУТСТ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.

Цагдаагийн Ерөнхий газар (ЦЕГ) нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ)-ийн дагуу Тагнуулын Ерөнхий газар (ТЕГ), Авлигатай тэмцэх газар (АТГ)-т хамаарахгүй гэмт хэргийг мөрдөн шалгана.

ЭБШХ-ийн дагуу ТЕГ нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах МУТС гэмт хэргийг (ихэвчлэн хил, үндэсний аюулгүй байдалтай холбоотой) мөрдөн шалгана. ТЕГ нь Монгол Улсын тухайлсан санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх Терроризмтэй тэмцэх үйл ажиллагаа зохицуулах зөвлөл (ТТАЗЗ)-д тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

АТГ нь ЭБШХ-ийн дагуу нийтийн албан хаагчдад хамаарах мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгана.

МУТСТ тогтолцооны хувьд Гадаад харилцааны яам (ГХЯ) нь олон улсын байгууллагууд (тухайлбал, НҮБ)-тай харилцах анхдагч байгууллага билээ.

Гаалийн ерөнхий газар (ГЕГ) нь гаалийн деклараци, илрүүлэлтийн системийг хариуцах бөгөөд мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхгүй.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ) нь Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн дагуу хуулийн этгээдийг, үүний дотор ашгийн бус байгууллагыг бүртгэх үүрэгтэй.

2/ Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дунд хугацаанд хадгалах, гадаад өр, төлбөрийг шийдвэрлэх чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах;

Үндэслэл

Монгол Улсын цаашдын хөгжилд дунд болон урт хугацаанд уул уурхайн мөчлөгөөс хамаарал багатайгаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн дотоод шингээлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтцийн

өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, түүнд эрсдэл дагуулах ойрын болон дунд хугацааны сорилтуудыг шийдвэрлэх нь чухал юм. Монгол Улсын хувьд ойрын болон дунд хугацаанд шийдвэрлэх шаардлагатай нэн тэргүүний томоохон сорилт бол гадаад өрийн тогтвортой байдлыг хангах явдал болоод байна.

Монгол Улсын гадаад өрийн хэмжээ 2010 оноос хойш 4 дахин нэмэгдэж, 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 29.5 тэрбум ам.долларт хүрээд байна. Гадаад өрийн үйлчилгээнд 2020-2024 онд төр болон хувийн хэвшил нийт 14.3 тэрбум ам.доллартай тэнцэх эргэн төлөлт хийхээр байгаа нь валютын нөөцөөс даруй 3.5 дахин өндөр дүн юм. Экспортын 90 орчим хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70-аас дээш хувь нь уул уурхайн салбараас хамааралтай манай улсын хувьд дээрх хэмжээний гадаад өрийн эргэн төлөлт түүхий эдийн үнийн уналтын мөчлөгтэй давхацсан тохиолдолд эдийн засгийн хямралд оруулах эрсдэлтэй.

АНУ болон БНХАУ хооронд 2019 он гарсаар даамжирч буй худалдааны дайн, үүсээд буй тодорхой бус байдал нь дэлхийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж эхлээд байна. Энэ нь хөгжингүй болоод хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн өсөлт удаашрах, дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ буурахад хүргэж болзошгүй байна.

Эдийн засгийн гадаад орчинд үүсээд буй дээрх тодорхойгүй нөхцөл байдал, гадаад өр, төлбөрийн асуудлыг эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр шийдвэрлэхэд нэн тэргүүнд бодлогын сахилга батыг хангах, санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалах нь чухал болж байна. Сүүлийн 2 жил гаруйн хугацаанд санхүүгийн салбарын шинэчлэлийг эхлүүлж, мөнгөний бодлогыг олон улсын сайн жишигт нийцүүлэх, санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг хангах, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй байв. Цаашид эдийн засгийн тогтвортой өсөлтийг дунд хугацаанд хадгалахын тулд засаглал институцийг бэхжүүлэх, төрийн бодлого, зохицуулалтын хараат бус байдлыг сайжруулах, боловсрол эрүүл мэнд дэд бүтцийг сайжруулах, валютын орох урсгалыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, экспортыг төрөлжүүлэх шаардлага чухал хэвээр байна. Эдгээр ойрын болон дунд, урт хугацааны сорилтыг шийдвэрлэж, зорилтыг үр дүнтэй биелүүлэхэд дотоод нөөц бололцооноос гадна, олон улсын байгууллагуудтай бодлогын оновчтой сонголт болон олон улсын шилдэг туршлагыг нутагшуулах, санхүүгийн эх үүсвэрийг татах чиглэлээр хамтын ажиллагааг үргэлжлүүлж, өргөжүүлэх нь чухал үүрэгтэй байх болно.

Стратеги

1. Ойрын болон хэтийн эдийн засгийн сорилтууд, тэдгээрийн шийдлийн талаарх нэгдмэл ойлголтод хүрэх
2. Бодлогын арга хэмжээний уялдааг хангаж, олон нийт болон бодлого боловсруулагчдын мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах
3. Судалгаанд тулгуурласан шийдлийг эрэлхийлэх

Арга хэмжээ

1. Эдийн засгийн эмзэг байдлыг бий болгосон асуудлын шалтгаан, шийдлийн талаарх дүгнэлт боловсруулах
2. Дунд хугацааны эдийн засгийн сорилт, болзошгүй үр дагаврын талаарх шинжилгээ хийх
3. Сорилтыг даван туулахад зайлшгүй бодлогын тохиргоо, арга хэмжээнүүд, тэдгээрийн дарааллыг тодорхойлох
4. Олон талт хамтын ажиллагааны санал, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах
5. Бодлого тодорхойлогчид болон олон нийтийг хамарсан нээлттэй хэлэлцүүлгээр дамжуулж асуудал болон шийдлийн талаарх нэгдсэн ойлголтод хүрэх

3/ Төв банкны гадаад өрийн хэмжээг бууруулж, Монгол Улсын гадаад валютын цэвэр нөөцийг тууштай нэмэгдүүлэх;

Монгол Улсын гадаад өр 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 29.5 тэрбум ам.доллар байгаагийн 25 хувийг Засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны гадаад өр эзэлж байна. Зах зээлийн орчин таатай үед гадаад зах зээлээс урт хугацаатай, хямд эх үүсвэр татах нь дэд бүтцийн болон урт хугацааны өгөөжтэй төслүүдэд хөрөнгө оруулах, эдийн засгийн дунд, урт хугацааны өсөлтийг дэмжихэд эергээр нөлөөлж, нөөц хуримтлуулах боломжийг бий болгодог хэдий ч хэт өндөр гадаад өр нь урт хугацаанд тодорхой эрсдэлүүдийг дагуулж байдаг. Ялангуяа макро эдийн засгийн суурь хүчин зүйлсийг бүрэн бэхжүүлээгүй, хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын хувьд өрийн үйлчилгээтэй холбоотой валютын гарах урсгалыг нэмэгдүүлж, төгрөгийн ханш сулрах дарамтыг үүсгэн, төсөв, мөнгөний бодлогын орон зайг хязгаарлаж, эдийн засгийн эмзэг байдлын гол сурвалж болж байна. Харин хувийн хэвшлийн гадаад өр эргэн төлөгдөхдөө дотоодын валютын захад эрэлт үүсгэснээр төгрөгийн ханшийг сулруулах эсвэл Төв банкнаас захад гадаад валют нийлүүлж улмаар гадаад валютын нөөцийг бууруулах дарамтыг үүсгэдэг.

Эдийн засгийн өсөлт тогтворжиж, төлбөрийн тэнцэл сайжирч байгаа үед Засгийн газар болон Төв банкны өрийн хэмжээг эдийн засагт дарамт учруулахгүйгээр оновчтой шийдвэрлэх нь урт хугацаанд эдийн засгийн

тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ зохистой түвшнээс их байгаа тул¹ салбар бүрт гадаад өрийг бууруулах болон өрийн удирдлагаа сайжруулахаар ажиллаж байна. Тухайлбал, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийг 2019 онд баталсан бөгөөд үүнд өрийн хэмжээг эдийн засагт дарамт учруулахгүйгээр бууруулах чиглэл баримтлахаар тусгажээ.

Макро эдийн засаг, дотоодын валютын захад хэлбэлзэл үүсгэхгүйгээр богино хугацаатай өрийн дарамтыг оновчтой шийдвэрлэх нь (1) богино хугацаат өр – гадаад валютын албан нөөцийн харьцаагаар хэмжигдэх нөөцийн хүрэлцээт байдлыг нэмэгдүүлэх, (2) хөрвөх чадварыг сайжруулах, (3) зах зээлд оролцогчдын итгэлийг нэмэгдүүлэх давуу талтай. Өөрөөр хэлбэл, гадаад өрийг оновчтой шийдвэрлэхэд нөөцийн хүрэлцээт байдлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай юм.

Хэдийгээр Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2019 оны эхний хагасын байдлаар 2016 оны эцсээс 4 дахин нэмэгдэж, 4.0 тэрбум ам.долларт хүрээд байгаа хэдий ч гадаад валютын албан нөөцийн хэмжээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хэмжээнээс 27.5 хувь, ОУВС-гийн аргачлалаар тооцсон гадаад валютын нөөцийн хүрэлцээт байдлын үзүүлэлтээс 1.3-2.0 дахин бага байна. Иймд Төв банкны гадаад өрийг бууруулахын зэрэгцээ гадаад валютын цэвэр нөөцийг цаашид үргэлжлүүлэн нэмэгдүүлэх шаардлага чухал хэвээр байна.

Гадаад валютын цэвэр нөөц өссөнөөр эдийн засгийн дархлааг сайжруулах, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарыг бэхжүүлэх, эдийн засаг тогтвортой өсөх суурь болдог бөгөөд Монгол Улсын зээлжих зэрэглэлд нөлөөлөх чухал үзүүлэлтүүдийн нэг болдог. Иймд эрдэс бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр, гадаад эрэлт тогтвортой байгаа үед гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэх нь ойрын ирээдүйд хүлээгдэж буй гадаад өр, төлбөрийг амжилттай шийдвэрлэх, Монгол Улсын эдийн засгийн эрсдэл даах чадварыг сайжруулахад дэмжлэг болно. Үүний тулд гадаад валютын цэвэр нөөцийг зохистой түвшинд хүргэн хуримтлуулах чиглэлээр Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг тууштай үргэлжлүүлнэ.

¹ ОУВС болон Дэлхийн банкны тооцоогоор Монгол Улсын өрийн түвшин өрийн дарамттай хэмжээнд хүрсэн бөгөөд өрийн хэмжээ босго утгаас 1.5-2.0 дахин өндөр байна.

Стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

- ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн гэрээг 2023 он хүртэл дахин 3 жилийн хугацаатайгаар сунгана.
- Төв банкны гадаад өрийг бууруулах зорилгоор ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн хүрээнд үүссэн өр төлбөрийг төлж эхэлнэ.
- Мөнгө, санхүүгийн зах дахь хэрэгслүүдийг боловсронгуй болгох, эрх зүйн орчныг сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулагчдаас эх үүсвэр татах сонирхлыг нэмэгдүүлэх, мөнгө, санхүүгийн зах зээл үр ашигтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- Дотоодын зах зээлээс алт худалдан авах ажиллагааг боловсронгуй болгож, худалдан авах алтны хэмжээг нэмэгдүүлнэ.

4/ Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, зээл олголтын зарчмыг олон улсын жишигт нийцүүлж, хэрэгжилтийг хангах;

Санхүүгийн зах зээлийн оролцогчид санхүүгийн үйлчилгээг авахдаа шаардлагатай мэдлэг, мэдээлэл зэргийг үнэ төлбөргүй авах, зөрчигдсөн эрхээ мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлүүлэх хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Түүнчлэн, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ч тэдгээрийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, түүнд тавих төрийн зохицуулагч байгууллагын хяналт шалгалтыг өндөржүүлэх, боловсронгуй болгоход ч хууль эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай юм.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалж, түүнд санхүүгийн мэдлэг боловсролыг зөв хүртээмжтэй олгосноор цаашдын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй. Иймд Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Тус хуулиар санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага стандартыг тогтоож, санхүүгийн хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, ойлголтыг үнэн бодитоор үнэ төлбөргүй авах эрхийн харилцааг зохицуулна. Мөн хариуцлагатай зээлдэгчийн зарчим, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтыг тусгаж өгсөн болно.

Дээр дурдсан хуулийн төсөл УИХ-аар батлагдах хүртэл санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээнүүдийг тусгасан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг мөрдүүлж ажиллана. Уг журмыг хэрэгжүүлэхдээ банк бус санхүүгийн байгууллагуудыг хамруулснаар банкны бус санхүүгийн зах зээлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ зээлийн хүүний дарамтыг бууруулахад хувь нэмэр оруулах юм.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулж банк, эрх бүхий хуулийн этгээдээс хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ авч байгаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах шаардлага тулгараад байна. Тус хуулийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байгаа Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай нийцүүлж, санхүүгийн салбар, бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэлттэй уялдуулах шаардлагатай байна. Одоо зохицуулалтгүй байгаа санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг болон барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагууд санхүүгийн зохицуулагч байгууллагаас тусгай зөвшөөрөл авч, хяналт шалгалтад хамрагддаг байх эсэхийг судалж, шаардлагатай тохиолдолд хуулийн төсөлд тусгана.

5/ Банкны салбарын “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангаж, хууль эрх зүйн шинэ орчинг бий болгох;

Түүхий эдийн үнийн өсөлт, “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд манай улсын эдийн засагт эерэг өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч банкны салбарын чанаргүй зээл буурахгүй байна. Чанаргүй зээлд нөлөөлж буй нэг хүчин зүйл бол зээлийн маргааныг шуурхай шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй, банкуудын зээлийн эрсдэлийн удирдлага, зээл олгох стандарт хангалтгүй байгаа зэрэгтэй холбоотой юм.

Иймд банкны салбарын чанаргүй зээлийг түргэн хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх чадамжийг сайжруулах, зээлийн эрсдэлийн удирдлагыг олон улсын жишигт хүргэх ажлын хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2018 оны 6 дугаар сард “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-г баталж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч байна. Тус стратегийн хүрээнд шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд үүсч байгаа хүндрэл бэрхшээлийг бууруулах, арилгах, барьцаа хөрөнгийн бүртгэл, татварын зохицуулалтыг боловсронгуй болгож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, чанаргүй зээлийг худалдан борлуулах зах зээлийг хөгжүүлэх зэрэг асуудалд анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ чанаргүй зээлийг шийдвэрлэх үйл ажиллагаа зардал өндөртэй, хугацаа шаардсан өнөөгийн нөхцөлд санхүүгийн зах зээлд чанаргүй зээлийн хоёрдогч захыг хөгжүүлэх, Активын удирдлагын мэргэшсэн институцийг үүсгэн байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд Актив удирдлагын компанийн тухай хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгуулж хууль санаачлагчид уламжлаад байна. Цаашид Актив удирдлагын хуулийг батлуулан Активын удирдлагын компанийн үйл ажиллагааг эхлүүлж, чанаргүй активыг хямдруулан худалдан авч, чанаргүй

активд хуримтлагдаад байгаа эх үүсвэр, барьцаа хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авна.

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 онд Монголбанкнаас зээл, барьцааны гэрээний талуудын хооронд үүссэн маргааныг богино хугацаанд шийдвэрлэх, тэдгээрийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, барьцаа хөрөнгийн эргэлтийг сайжруулах, шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах агуулгаар Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай багц хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулан хууль санаачлагчид уламжилсан.

Цаашлаад зээлдүүлэгч нь зээлдэгчийн талаар бүрэн судалгаа явуулсны үндсэн дээр зээл олгох нь чанаргүй зээл үүсэхгүй байх нэг нөхцөл болдог тул зээл олгох, барьцааг бүртгүүлэх, зээл төлүүлэх ажиллагаанд учирдаг битүүмжлэл, мэдээлэлд хандах, бүртгүүлэх, бүртгэлээс хасах зэрэг саад, бэрхшээлийг арилгах зорилгоор барьцаа хөрөнгийн бүртгэлийг цахимаар шалгах боломжийг бүрдүүлэх, зээлдэгчийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх (credit scoring), зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, бусад бүртгэлийн системтэй холбох боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай юм.

*Монгол Улсын Их Хурлын
2019 оны ... сарын ... –ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт*

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Мөнгөний бодлого нь эдийн засгийн болон банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1. Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

1.2. Банкны системийн эрсдэлийг үнэлэх, санхүүгийн мөчлөгийг тодорхойлох шинжилгээний аргачлалыг үргэлжлүүлэн хөгжүүлж, системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3. Мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах зорилгоор Төв банкны олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлж, мэдээллийн хүртээмжийг сайжруулна.

2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ.

2.2. Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, зохистой засаглалын зарчим, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

2.3. Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг Базелийн стандарттай нийцүүлэн сайжруулах арга хэмжээг авна.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Үндэсний төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох, төлбөрийн систем дэх финтек компаниудын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ.

3.2. Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналыг олон улсын жишигт хүргэн, мэдээллийн технологийн хөгжлийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.3. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг сайжруулна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2020 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн гурван жилд Монголбанк эдийн засгийг тогтворжуулж, сэргээх, гадаад өрийн дефолтоос зайлсхийж, эрсдэлийг бууруулах, банк санхүүгийн салбарыг эрүүлжүүлж, дархлааг сэргээхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Эдийн засгийн сэргэлтийг мөнгөний бодлогоор дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 2017, 2018 онд шат дараатай бууруулснаар банкны салбараас бодит эдийн засаг руу нийлүүлэгдэх санхүүжилт нэмэгдэж, зээлийн хүү буурсан нь эдийн засгийн сэргэлтэд чухал дэмжлэг боллоо. Улмаар хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт болон импортын өсөлт эрчимжиж, эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр сүүлийн хоёр жилд иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэн татварын орлого сайжирсан, ажил эрхлэлт нэмэгдэн ажилгүйдлийн түвшин буурсан, санхүүгийн зуучлал нэмэгдэн банкны зээлийн тэр дундаа бизнесийн зээлийн өсөлт нэмэгдсэн зэрэг нь бодит эдийн засаг дээр ч, санхүүгийн зах зээл дээр ч сэргэлт бий болсны илэрхийлэл юм.

Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг ирэх онд 8 хувийн орчимд тогтворжуулж, дунд хугацаанд 6 хувийн орчимд бууруулж тогтворжуулах зорилтыг хангасан мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Эдийн засгийн гадаад орчин, дотоод идэвхжлийг харгалзан үзэхэд инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих хандлага хэвээр байна. Жилийн инфляци 2019 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 8.1 хувьтай гарлаа. Инфляцийн хэлбэлзэл нь газрын тосны дэлхийн зах зээлийн үнийг дагасан шатахууны үнэ, нийлүүлэлтийн доголдлоос шалтгаалсан мах, хатуу түлшний үнийн огцом өөрчлөлтөөр тайлбарлагдаж байгаа бол эрэлтийн шалтгаантай суурь инфляци харьцангуй тогтвортой байна.

Сүүлийн 2 жил гаруй хугацаанд банк санхүүгийн системийн хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд банк, санхүүгийн салбарын тулгуур суурь болсон эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж, УИХ-аар батлуулаад байна. Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ санхүүгийн зах зээлд олноор нэвтэрч, эрх зүйн орчинг нарийвчлан боловсронгуй болгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага улам бүр нэмэгдэж байна. Энэ хүрээнд санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулах, валютын зохицуулалтыг боловсронгуй болгох, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн шинэтгэлийг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Манай эдийн засаг түүхий эдийн үнэ, гадаад хөрөнгийн урсгал, гадаад эрэлтээс өндөр хамааралтай байгаагаас эдийн засгийн болон санхүүгийн мөчлөг богино, давтамж олон байдаг. Нөгөө талаас Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2010 оноос хойш 4 дахин нэмэгдсэн бөгөөд ирэх таван жилд хийгдэх гадаад өрийн төлбөр одоогийн валютын нөөцөөс даруй 3.5 дахин өндөр байгаа нь эдийн засгийн эмзэг байдлыг ихээхэн нэмэгдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бууруулах эрсдэлтэй юм. Иймд мөчлөгийн уналтын далайцыг бууруулах, болзошгүй эрсдэл, хүндрэлээс сэргийлэхийн тулд эдийн засгийн болон санхүүгийн секторын дархлааг нэмэгдүүлэх, санхүүгийн нөөцийг бүх шатанд хуримтлуулах, санхүүгийн салбарын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь нэн чухал болж байна.

Гадаад өрийн эргэн төлөлтийг шийдвэрлэх, эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд гадаад валютын нөөц (цэврээр)-ийг зохистой түвшинд хүргэж нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилт болж байна. Ялангуяа ирэх онд эдийн засгийн өсөлтийн үе үргэлжлэхээр байгаа тул гадаад, дотоод секторын тэнцвэртэй байдлыг хадгалах, валютын ханшийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх замаар валютын нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдэхээр байна. Үүний зэрэгцээ Засгийн газартай хамтран гадаад өрийн тогтвортой байдал, гадаад өрийн стратегийг боловсруулж, эргэн төлөх болон дахин санхүүжүүлэх өрийн хэмжээг дунд, урт хугацаанд тодорхойлж, түүнийг шийдвэрлэх чиглэлээр олон улсын байгууллага, донор орнуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага өндөр байна.

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, өсөлт сэргэж байгаа боловч эргэн төлөлтийн доголдолтой зээлийн хэмжээ буурахгүй байна. Тухайлбал, банкны салбарын анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх жилийн мөн үеэс 26.0 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 41.2 хувиар тус тус өслөө. Чанаргүй зээл өсөхөд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээлийн чанар үргэлжлэн муудаж байгаа нь голлох нөлөө үзүүлсэн байна. Хэдийгээр банкны системд хуримтлагдаад буй чанаргүй зээл нь санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахааргүй байгаа ч эдийн засгийн хүндрэлийн үед системийн хэмжээнд чанаргүй актив хурдтай нэмэгдэхээс сэргийлэх, нэгэнт үүссэн чанаргүй активыг шийдвэрлэх тогтолцоо, дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажлыг төрийн эрх бүхий бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх нь дараагийн нэг зорилт болж байна. Үүний зэрэгцээ санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг тогтмол хянаж, бодит эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг урьдчилан тооцох, санхүүгийн системийн эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх, түүний мөчлөг дагасан байдлыг сааруулж, дотоод эмзэг байдлыг бууруулах, системийн

тодорхой нэг хэсэгт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой байдлыг хадгалах, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн макро зохистой бодлогыг үргэлжүүлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үзүүлэлтийг ахиулах арга хэмжээг үргэлжлүүлэн авч, холбогдох олон улсын байгууллагуудын шаардлагыг биелүүлэхэд эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдааг сайжруулах, өндөр дүнтэй мөнгө угаах гэмт хэрэгт онцгой анхаарал хандуулах идэвхтэй хамтран ажиллах хэрэгцээ шаардлага хэвээр байна.

Цаашид Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь манай эдийн засгийн хэтийн төлөвт стратегийн чухал ач холбогдолтой. Тэр дундаа, Монгол Улсын гадаад өрийг тогтворжуулах, дарамтыг бууруулахад ОУВС болон бусад доноруудын тусламж дэмжлэг цаашид ч онцгой шаардлагатай байгааг энд онцлох нь зүйтэй.

Монгол Улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, нийт ард иргэд, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгоход Монголбанкны ирэх жилүүдийн бодлого, үйл ажиллагаа чиглэнэ.

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 1.1

Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

Үндэслэл

Үнийн тогтвортой байдал буюу инфляци нам дор түвшинд, савлагаа багатай байх нь нэг талаас макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл бага байгааг илтгэдэг. Нөгөө талаас тодорхой бус байдал буурч, бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, бодит орлого, өрхийн амьжиргааг хамгаалахад Төв банкны зүгээс оруулж буй хувь нэмэр юм. Инфляци хэт буурах эсвэл өсч савлах нь макро эдийн засгийн тогтворгүй байдлаар дамжин санхүүгийн системийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Улс орон бүрийн хувьд хөгжлийн үе шатны ялгаатай байдлаас шалтгаалан эдийн засгийн тогтвортой төлөвийн инфляцийн түвшин харилцан адилгүй байдаг боловч түүний зорилтот түвшинг хэт багаар тогтоон түүнийг хангахад чиглэсэн хэт хатуу мөнгөний бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг хумихгүй байх, эсвэл хэт өндрөөр тогтоож хэт тэлсэн мөнгөний бодлогоор богино хугацааны халалтыг үүсгэхгүй байх зарчмыг баримтлах нь зүйтэй байдаг. Өөрөөр хэлбэл, инфляцийн дарамтгүй, дунд, урт хугацаанд тогтвортой хадгалагдах эдийн засгийн өсөлтийг зорьж

буй хэрэг юм. Манай улсын хувьд тогтвортой төлөвийн инфляцийг тодорхойлсон судалгаа ховор боловч Монголбанкны судлаачдын тооцоолсноор 7 орчим хувь байна.


Төв банкуудын туршлагаас харахад инфляцийн харьцангуй уян зорилт нь эдийн засгийн хэлбэлзлийг бууруулахад чиглэсэн уян хатан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх боломжийг олгодог. Энэхүү үүргээ гүйцэтгэхдээ Төв банк мөнгөний бодлогын шийдвэр гаргахдаа инфляцийн зорилтоо ирээдүйд хангах зарчмыг баримталдаг. Ирээдүйд инфляцийг тогтворжуулах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх дүрэм нь маш энгийн бөгөөд ирээдүйд таамагласан инфляци нь зорилтот түвшнээс их эсвэл бага байгаа нь мөнгөний бодлогын хатууруулах эсвэл сулруулах чиглэлийг тодорхойлдог. Хүндрэлтэй тал нь нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй инфляцийг ялгаж, эдийн засгийн идэвхжилтэй уялдаатай инфляцийг тооцох шаардлагатай болдог.

Эдийн засгийн хэт халалтаас сэргийлэх буюу ужгирсан инфляциас сэргийлэх зорилгоор эдийн засгийн идэвхжилтэй холбоотой инфляцийг зөв таньж, мөнгөний бодлогын хариу арга хэмжээ авах нь мөнгөний

бодлогын шийдвэрийг тайлбарлаж, олон нийтэд хүргэхэд хүндрэл дагуулдаг. Зарим тохиолдолд нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсээр инфляци нэмэгдэхэд мөнгөний бодлогоор хариу үзүүлэхгүй тохиолдлууд үүсэх бөгөөд энэ тохиолдолд олон нийтийн зүгээс Төв банк хариуцлагагүй хандаж байгаа мэтээр ойлгох магадлалтай.

Дунд, урт хугацаанд инфляцийг бууруулахад тууштай, хараат бус мөнгөний бодлогоос гадна инфляцийн хүлээлтийг тогтвортой бага түвшинд бууруулах нь чухал байна. Өмнөх үеийн хэлбэлзэлтэй шууд хамааралтай инфляцийн хүлээлт нь дараа үеийн инфляцид хүчтэй нөлөөтэй байна².

Зураг 1. Инфляцид нөлөөлж буй хүчин зүйлүүдийн задаргаа



Түүнчлэн экспортын орлогын 85 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүн бүрдүүлдэг манай улсын хувьд гадаад шок болон валютын ханшийн хэлбэлзэл инфляцид хүчтэй нөлөөтэй байна. Тухайлбал, хэрэглээний үнийн индексийн хэлбэлзлийн 40-55 орчим

² Л.Даваажаргал. 2015. “Валютын ханшийн инфляцид үзүүлэх нөлөө”, Монголбанкны судалгааны товхимол, хэвлэл 10.

хувь нь Хятадын эдийн засгийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, зэсийн үнийн хэлбэлзэлтэй холбоотой байна³. Түүнээс гадна цаг агаарын нөхцөл, улирлын онцлог зэрэг нь нийт инфляцийн хэлбэлзэлд хүчтэй нөлөөтэй байна. Тухайлбал, 2018 оны 2 дугаар улирлаас хойш мах, хатуу түлш, бензиний үнэ Улаанбаатар хотын нийт инфляцийн 40 орчим хувийг тайлбарлаж байна.

Хэдийгээр инфляцийн түүхэн хэлбэлзэл өндөр, Төв банкны бодлогоос хамааралгүй хүчин зүйлийн нөлөө өндөр боловч Монголбанк макро эдийн засагт халалт, хөрөлт үүсэх буюу нийт эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдах эрсдэлийг урьдчилан илэрхийлж, дохиолдог үнийн түвшний өөрчлөлтийг дунд хугацаанд тогтвортой байлгахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байна. **Инфляци 2017 оны 2 дугаар хагасаас хойш 2 жил гаруй хугацаанд Төв банкны зорилтот түвшний орчимд хадгалагдаж, харьцангуй тогтвортой байна.** Цаашдын инфляцийг аль болох тогтвортой байлгах нь зах зээлд оролцогчдын хүлээлтийг тогтворжуулж, улмаар дунд урт хугацаанд үнийн түвшин, түүний савлагааг тасралтгүй бууруулахад дэмжлэг болно.

³ Д.Ган-Очир, Л.Даваажаргал. 2017. “Монголын эдийн засгийн том хэмжээний BVAR загвар: Гадаад шокын нөлөө”

Зураг 2. Инфляцийн хэлбэлзэл, түүний зорилтот түвшин



Эх үүсвэр: Монголбанк

Стратеги

1. Эрэлтийн гаралтай инфляцийг зохистой түвшинд хадгалахыг зорино. Монголбанк эдийн засгийн идэвхжлийг зохистой түвшинд хадгалах нийт эрэлтийн өөрчлөлтөд нөлөөлөх замаар инфляцийг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. Мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүү нь зээл олголт, хүү, ханш, хөрөнгийн үнэ, хүлээлт зэрэг гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт болон импортод нөлөөлснөөр эдийн засгийн идэвхжлийг эрэлт талаас удирдаж, улмаар бодит болон потенциал үйлдвэрлэлийн зөрүүгээр үнийн түвшний өөрчлөлт тодорхойлогдоно. Харин нийлүүлэлтийн гаралтай, тухайлбал цаг агаарын нөхцөл байдлаас үүдэлтэй хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, татварын өөрчлөлт, олон улсын зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзлээс шалтгаалсан

дотоодын шатахууны үнийн өөрчлөлт, тээврийн саатал гэх мэтээс шалтгаалсан инфляцийн түр зуурын хэлбэлзэлд мөнгөний бодлогоор шууд хариу үйлдэл үзүүлэхгүй бөгөөд, тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өөрчлөлтийн инфляцид үзүүлэх хоёр дахь үеийн буюу дам нөлөөг харгалзаж үзнэ.

2. Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд суурилж хэрэгжүүлнэ. Монголбанк үнийн тогтвортой байдлаар дамжуулж макро эдийн засгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, инфляцийн дарамтгүй тогтвортой өсөлтөөр дамжуулж иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ зах зээлийн зарчимд суурилсан арга хэрэгслийг ашиглаж, хүүгийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ. Төв банкны тухай 2018 оны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Монголбанк зах зээлийн бус зарчмаар төсвийн шинж чанартай үйл ажиллагаа хэрэгжүүлж, эдийн засагт сөрөг үр дагаврууд бий болгох эрсдэлийг хязгаарлах шинэчлэлүүд хийсэн. Хуульд Засгийн газар болон арилжааны банкуудад санхүүжилт олгох нөхцөлүүд нарийвчлан тусгагдсаны зэрэгцээ Төв банкны хараат бус байдлыг дээшлүүлэх, засаглалын тогтолцоо, шийдвэр гаргах процессийг сайжруулахад чиглэсэн нэмэлт өөрчлөлтүүд орж, мөрдөгдөөд явж байна.

3. Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

Эдийн засагт эрэлт болон нийлүүлэлтийн гаралтай, бүтцийн эсвэл түр зуурын шинж чанартай эерэг болон сөрөг шокууд тогтмол бий болж зарим бараа, үйлчилгээний үнийн савлагааг өдөөж, улмаар инфляцид хэлбэлзэл үүсгэж байдаг. Тухайлбал, гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэл, хөрөнгийн урсгалын өөрчлөлт, олон улсын худалдааны гэрээ, тарифын өөрчлөлт, санхүүгийн зах зээл дээрх инноваци, технологи болон дэд бүтцийн сайжралт, ган, зуд гэх мэт байгаль орчны үзэгдлүүд, төсвийн зарлага, бүтээмж, цалин орлогын өсөлт гэх мэт хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляци тодорхой хугацаанд зорилтот түвшнээс хазайх боломжтой. Ийм нөхцөл байдалд шокийн шалтгаан, шинж чанар, цар хүрээ, үргэлжлэх хугацаа, үнийн түвшний өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг харгалзаж дунд хугацаанд инфляцийг Төв банкны зорилтот түвшинд хадгалахад чиглэсэн буюу **ирээдүйн төлөвийг харгалзсан мөнгөний бодлогын шийдвэр гаргана.**

- **Мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах аргагүй инфляцийн хэлбэлзлийг бууруулахад бусад бодлого боловсруулагчид, эдийн засгийн агентууд чухал үүрэгтэй.**

Түүхэн хугацаанд Монгол улсад үнийн хэлбэлзэл нь дан ганц мөнгөний бодлогоор нөлөөлж болохуйц эрэлтийн хүчин зүйлээс гадна нийлүүлэлтийн хүчин зүйлсийн улмаас нэмэгдэх тохиолдол цөөнгүй байсаар ирсэн. Дунд, урт хугацаанд инфляцийг нам дор, тогтвортой түвшинд бууруулахад дараах арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал;

- Эдийн засгийг олон тулгууртай болгож төрөлжүүлэх, үйлдвэрлэлийн чадавхыг сайжруулснаар валютын орох гарах урсгалын зохистой харьцааг тогтвортой хадгалах, ингэснээр хөрөнгийн урсгалын эдийн засгийн идэвхжилд үзүүлэх нөлөөлөл, ханшийн савлагааг тогтворжуулж инфляцид дамжих нөлөөллийг тогтвортой хадгалах;
- Ажлын байр бий болгох, ажиллах хүчний бүтээмж, ур чадварыг нэмэгдүүлснээр цалингийн өсөлтийн инфляцид үзүүлэх нөлөөг бууруулна;
- Санхүүгийн зах зээлийн гүнзгийрэл, хүртээмжийг нэмэгдүүлж, эрсдэлийн удирдлагыг сайжруулснаар эдийн засгийн тогтвортой байдал, дотоодын хуримтлал үүсэх боломжийг дээшлүүлэх;
- Төсвийн сахилга бат, өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, эдийн засгийн хэт халалт, уналтыг үүсгэсэн мөчлөг дагасан бодлогоос зайлсхийх;

- Гадаад худалдааны болон гадаадын шууд хөрөнгө оруулалт татах бодлого, тэдгээрийн хууль эрх зүй, татварын орчны зохицуулалтуудыг сайжруулах замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;
- Зах зээлийн нийлүүлэлтийн дэд бүтцийг сайжруулах нь барааны түр хомстолоос шалтгаалсан үнийн өсөлт бий болохгүй байхад дэмжлэг үзүүлэх;
- Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг, сахилга батыг сайжруулахад чиглэсэн боловсролын үйл ажиллагаагаар дамжуулж хэрэглэх болон хуримтлуулах зан төлөвт эерэг өөрчлөлтийг бий болгох;

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Мөнгөний бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэж, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бусаар сайн засаглалын хамтын зарчимд тулгуурлан гаргана. Мөнгөний бодлогын хороог жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулах бөгөөд Мөнгөний бодлогын хорооны хурлын товыг оны эхэнд зарлана.
- Мөнгөний бодлого боловсруулах процессийг сайжруулж, бодлогын шийдвэрийн үндэслэл болох тооцоо, судалгааны чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ. Үүний хүрээнд:
 - Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн холбоос, харилцан хамаарал, мөнгөний бодлогын шилжих сувгийн талаарх суурь судалгааг өргөжүүлнэ;
 - Эдийн засгийн гүйцэтгэлийн шинжилгээ, ирээдүйн хандлагын төсөөлөл, тулгарч болохуйц эрсдэлүүдийг тодорхойлоход шаардагдах тоон болон чанарын мэдээллийн баазыг өргөжүүлнэ;
 - Төсөөлөл, симуляци хийх шинжилгээний загваруудыг сайжруулж, шинэ загварыг хөгжүүлнэ;
 - Олон улсын байгууллагууд, төв банкууд, судалгааны институциудтай хамтран шинжилгээ, тооцоолол дээр ажилладаг экспертүүдийн ур чадварыг дээшлүүлнэ;
- Мөнгөний бодлогын олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлэх, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллана.

ЗОРИЛТ 1.2

Банкны системийн эрсдэлийг үнэлэх, санхүүгийн мөчлөгийг тодорхойлох шинжилгээний аргачлалыг үргэлжлүүлэн хөгжүүлж, системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Мөнгөний бодлогын үр өгөөжийг нэмэгдүүлэх, макро тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдаж иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой уялдуулан хэрэгжүүлж байна. Санхүүгийн системийн дотоод эмзэг байдал өндөр хэвээр, гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн орчинд гарч буй өөрчлөлтийг шинжлэх, шаардлагатай тохиолдолд макро зохистой бодлогын арга хэмжээг авах, мөн шинжилгээний аргазүйг сайжруулах зорилттой байна.

Дэлхийн санхүүгийн 2008-2009 оны хямрал нь санхүүгийн системд эрсдэл хуримтлагдсан үед хүндрэл үүсвэл богино хугацаанд бодит эдийн засагт хүчтэй нөлөөлж, хямралын далайцыг нэмэгдүүлэх бөгөөд үүнийг зөвхөн мөнгөний бодлогоор тогтворжуулах боломжгүйг нотолсон юм. Иймд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах, түүний эмзэг байдлыг бууруулах, бодит эдийн засагт үзүүлэх мөчлөгийн нөлөөг сааруулах зорилгоор төв банкууд макро зохистой бодлогыг


мөнгөний бодлоготой хослуулан хэрэглэж байна⁴.

Манай улсын эдийн засаг түүхий эдийн үнэ, гадаад хөрөнгийн урсгал, гадаад эрэлтээс өндөр хамааралтай хэвээр байна. Өмнөх жилүүдэд тохиож байсан бодит эдийн засаг болон санхүүгийн мөчлөгийн уналтууд давхцаж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэн, банк, санхүү, бодитэдийнзасгийнхямралдаамжрах эрсдэл арилаагүй байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд нүүрс, зэсийн үнэ харьцангуй өндөр байж, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийгдэж, хөрөнгийн дотогшлох урсгалыг дэмжиж байгаа боловч ирэх онуудад дэлхийн худалдааны дайн, геополитикийн байдлаас шалтгаалж түүхий эдийн үнэ буурах, хөрөнгийн урсгал татрах, нүүрсний экспортын тээвэрлэлт саатах зэрэг эрсдэл хэвээр, түүнийг удирдах тогтолцоо бий болоогүй байна. Нөгөө талаас 2014-2016 онд бий болсон бодит эдийн засгийн хүндрэл нь банкны салбарт чанаргүй зээл хэлбэрээр илэрч байна. Хэдийгээр эдийн засгийн идэвхжил сэргэж байгаа ч зээлийн чанар сайжрахгүй байгаа нь банкны салбарыг гадаад орчны сөрөг цочролд улам эмзэг болгож

⁴ Deutsche Bundesbank, Monthly Report, March 2015

байна. Иймд санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг тогтмол хянаж, бодит эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг урьдчилан тооцох, санхүүгийн системийн эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх, түүний мөчлөг дагасан байдлыг сааруулж, дотоод эмзэг байдлыг бууруулах, системийн тодорхой нэг хэсэгт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой байдлыг хадгалах, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн макро зохистой бодлогыг үргэлжүүлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Зураг 3. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээл, салбаруудаар



Өмнөх жилүүдэд хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж, өрхийн зарлага нь орлогоосоо тогтмол давж байсан нь дотоод эрэлт, инфляцийг нэмэгдүүлж, цаашид орлого буурах тохиолдолд зээлийн чанарыг муутгах, хэрэглээг огцом хумих, түүнийг дагаад ДНБ-д үргэлжлэн сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байсан тул Монголбанк 2019 оноос иргэдийн хэрэглээний зээлийн

хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг тогтоон, мөрдүүлж байна. Макро зохистой бодлогын үр дүнд хэрэглээний зээлийн өсөлт 2019 оны эхнээс саарч байгаа тул санхүүгийн хямрал үүсэх тохиолдолд өрхүүд, нийт эдийн засаг хямралыг хохирол багатайгаар даван туулах нөхцөлийг бүрдүүллээ.

Зураг 4. Зээлийн өсөлт



Стратеги

Монголбанк болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор макро зохистой бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

- Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг шинжилж, шаардлагатай тохиолдолд макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.
- Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлүүд, бодит эдийн засаг болон санхүүгийн салбар хоорондын

харилцан хамаарал, гадаад орчны нөлөөг нарийвчлан тодорхойлно.

- Системийн эрсдэлийн шинжилгээ, стресс тест, бодлогын үр нөлөөг тодорхойлох тоон болон чанарын аргачлал,

шинжилгээний аргазүй болон загварыг олон улсын туршлагад үндэслэн судалж, Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн системийн бүтцэд нийцүүлэн хөгжүүлэх нь бодлогын шийдвэр гаргалтын үндэс болно.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулах, хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг сааруулахад чиглэсэн макро зохистой бодлогын хэрэгслүүдийн олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ.
- Макро зохистой бодлогын тооцоо шинжилгээнд ашиглах тоон мэдээллийг цуглуулж, өгөгдлийн санг өргөжүүлнэ.
- Монгол Улсын санхүүгийн системийн бүтэц, онцлог шинж чанарт тулгуурлан макро зохистой бодлогын үр нөлөөг тооцох загварыг хөгжүүлж эхэлнэ.
- Банкны системийн эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлох индикатор, аргачлалууд, түүнийг Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн системийн онцлогт тохируулан хөгжүүлэх боломжийг судална.

ЗОРИЛТ 1.3

Мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах зорилгоор Төв банкны олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлж, мэдээллийн хүртээмжийг сайжруулна.

Үндэслэл

Төв банкны нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар түүний хариуцлагатай байдал, итгэл даах чадварыг бэхжүүлэх нь мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой. Урт хугацааны үнийн түвшнийг тодорхойлох гол хүчин зүйл болох инфляцийн хүлээлтийг бууруулж, удирдах арга зам нь Төв банкны тууштай, хариуцлагатай бодлогоос гадна бодлогоо олон нийтэд хүргэх харилцаа юм. Олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь эргээд Төв банкны бодлогыг илүү нээлттэй, ил тод болгосноор илүү тууштай бөгөөд хариуцлагатай ажиллах, улмаар бодлогод итгэх итгэлийг дээшлүүлэхэд эерэг нөлөөтэй. Иймд Монголбанк олон нийттэй харилцах сувгуудыг үргэлжлэн хөгжүүлж, мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг дээшлүүлэхийг зорьж байна. Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь

- (i) Төв банкны үндсэн зорилт;
- (ii) Үндсэн зорилтоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх мөнгөний бодлогын стратеги, арга хэлбэр;
- (iii) Эдийн засгийн төлөв, түүнтэй уялдуулан гаргасан бодлогын шийдвэрийн үндэслэл, шилжих механизм;

(iv) Цаашид үүсч болох эрсдэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг олон нийтэд тайлбарлах үйл ажиллагааны цогц болж байна.

Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, зах зээлд оролцогчдын шийдвэрүүд илүү оновчтой байх, зах зээл дээр илүү тогтвортой байдлыг бий болгоход эерэг хувь нэмэр оруулна. Иргэд, аж ахуйн нэгж, санхүүгийн байгууллагуудын шийдвэрүүдээс хамаарч эдийн засаг дахь хэрэглээ ба хадгаламж, зээл ба хөрөнгө оруулалт, ажил эрхлэлт болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ зэрэг үйл хөдлөлүүд тодорхойлогдож улмаар эдийн засгийн идэвхжил, үнэ тогтох процесс өрнөдөг.

Стратеги

Монголбанкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд олон улсын шилдэг туршлагыг дотоодын зах зээлийн онцлогт уялдуулан нэвтрүүлэх ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ.

Мэдээллийн агуулга

- Төв банкны эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оруулах хувь нэмэр, үнийн тогтвортой байдлын ач холбогдлыг олон

нийтэд ойлгомжтой хэлбэрээр таниулна;

- Мөнгөний бодлогын үндсэн зорилт, мөнгөний бодлогын арга хэлбэр, бодлогын шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд тайлбарлана;

Мэдээлэл түгээх суваг

- Мэдээллийг хурдтай бөгөөд хүртээмжтэй түгээх технологийн дэвшилд тулгуурласан сувгуудыг ашиглана;
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд ашиглаж буй хэвлэмэл болон цахим сувгийг олон

нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлнэ.

Мэдээлэл түгээх арга хэлбэр

- Төв банкнаас түгээх мэдээ, мэдээллийг санхүүгийн зах зээлийн оролцогчид, төрийн шийдвэр гаргах байгууллагууд, судалгааны болон хэвлэл мэдээллийн байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрээр түгээнэ.
- Төв банк, зорилтот бүлгүүдийн онцлог (нас, боловсрол мэргэжил, газарзүйн байршил зэрэг)-т тохирсон арга хэлбэрээр мэдээллийг түгээнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Олон нийтэд мэдээлэл түгээх арга хэлбэрийг боловсронгуй болгож, мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэл, үр нөлөөг олон нийтэд хүргэх сувгуудыг хөгжүүлнэ. Үүнд:

- Мөнгөний бодлогын шийдвэрийг олон нийтэд тайлбарлах үндсэн хэрэгсэл болох инфляцийн тайлангийн агуулгыг сайжруулж, хүртээмжийг дээшлүүлнэ;
- Мөнгөний бодлогын мэдэгдлийг олон улсын шилдэг туршлагыг ашиглан тасралтгүй сайжруулна;
- Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг тогтсон хуваарийн дагуу зохион байгуулна;
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд ашиглаж буй сувгуудын үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, оновчтой сувгуудыг тодорхойлно;
- Ярилцлага, нийтлэл хэлбэрээр бодлогын шийдвэрийн ойлгомжтой байдал, хүртээмжийг дээшлүүлнэ;
- Сургалт, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийттэй харилцаагаа гүнзгийрүүлнэ;
- Орон нутагт мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлнэ;

- Мөнгөний бодлого, эдийн засгийн бусад бодлогын уялдааг хангах, хэрэгжилтийг олон нийтэд тайлбарлаж таниулахад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.
- Монголбанкны судалгааны товхимол болон бусад хэвлэмэл бүтээгдэхүүн, цаашлаад статистик мэдээллийг батлагдсан хуваарийн дагуу бэлтгэж тархаана;
- Олон нийтийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, контент хийж үр дүнтэй түгээхэд чиглэсэн технологийн дэвшлүүдийг ашиглана;

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 2.1

Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Монголбанк Улсын Их Хурлаас баталсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл болон бодлогын бусад баримт бичгийн хүрээнд бие даасан арав гаруй хуулийг багтаасан “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг санаачлан амжилттай хэрэгжүүлж байна. 2017 оноос хойш Төв банкны бие даасан, хараат бус байдлыг хангаж, үйл ажиллагаа, шийдвэр гаргах зарчмыг олон улсын сайн жишигт хүргэх, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангаж банкны хяналт шалгалт болон үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, хадгаламжийн даатгал, мөнгө угаах, терроризмтой тэмцэх тогтолцоог сайжруулахтай холбоотой хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хурлаар батлууллаа.

Банкны салбарын дээр дурдсан тулгуур хуулиудаас гадна банк, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр боловсруулсан холбогдох хуулийн төслийг хууль санаачлагчдад уламжлах, Улсын

Их Хуралд өргөн мэдүүлээд хэлэлцүүлж байна. Эдгээрт Валютын зохицуулалтын тухай (шинэчилсэн найруулга), Активын удирдлагын компанийн тухай, Хөрөнгө оруулалтын банкны тухай, Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай, Эрдэнэсийн сангийн тухай (шинэчилсэн найруулга), Иргэний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах багц хуулийн төслүүд Монголбанкны хөтөлбөрт багтсан болно.

2020 онд Монголбанкнаас санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийн хурдацтай уялдуулан шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийг үргэлжүүлнэ. Энэ хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн үүсмэл хэрэгсэл, бусад үнэт цаасны эрх зүйн орчныг төрийн бусад байгууллага, олон улсын байгууллагатай хамтран бүрдүүлнэ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар санхүүгийн хэрэгслийг тодорхойлсон боловч гадаад валют, бараа бүтээгдэхүүний нэгдсэн захын дэд бүтэц, оролцогчдын тоо, мэдлэг

дутмаг байдал болон хууль, эрх зүйн тодорхойгүй байдлаас шалтгаалж, олон улсад түгээмэл хэрэглэгддэг санхүүгийн зах зээлд оролцогчдын эрсдэлийн удирдлагын гол хэрэгсэл болох энэхүү бүтээгдэхүүн, хэлцлийн зах хөгжихгүй байна. Монгол Улсад санхүүгийн үүсмэл хэрэгсэл, үнэт цаас, буцаан худалдан авах нөхцөлтэй санхүүжилтийн бусад хэрэгслийн эрх зүйн орчинг бүрдүүлснээр мөнгө, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, гадаад хөрөнгийн эх үүсвэрийг зардал багатай татах онцгой ач холбогдолтой юм.

Түүнчлэн, Төв банкны үйл ажиллагаа зорилтыг тодорхой болгож, бие даасан хараат бусаар үйл ажиллагаа явуулах баталгааг бүрдүүлэх, ил тод хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх болон банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг төлбөрийн чадвар алдагдсан эсвэл алдагдах гарцаагүй нөхцөл байдал үүсэхэд цуцалдаг байх, банкны хяналт шалгалтыг

хэрэгжүүлэхэд тусгай мэдлэгтэй, мэргэшсэн шинжээч зөвлөх үйлчилгээ, олон улсын санхүүгийн байгууллагыг татан оролцуулдаг байх чиглэлээр банкны хууль тогтоомжийг сайжруулна.

Стратеги

- Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг нийтэд сурталчлан таниулна.
- Өнөөгийн эрх зүйн орчин, хууль тогтоомжийн хэрэгжилт, хуулиар зохицуулагдаагүй тулгамдсан асуудлыг төрийн байгууллага, салбарын оролцогч нартай хамтран тодорхойлж, хуулийн хэрэгцээ шаардлагын талаар нэгдсэн ойлголтыг бүрдүүлнэ.
- Хөтөлбөрт тусгасан хууль тогтоомжийг төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулна.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Векселийн тухай хууль, санхүүгийн үүсмэл хэрэгсэл, санхүүжилтийн хэрэгслийн хуулиудын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийг баримтлан банк, санхүүгийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэлэг зохицуулалттайгаар боловсруулна.
- Төв банкны бие даасан, хараат бус байдлыг хангах, банкны хяналт шалгалт албадлагын зарим шаардлагатай арга хэмжээний үндэслэлийг тусгасан агуулгаар хуулийн төсөл боловсруулна.

ЗОРИЛТ 2.2

Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, зохистой засаглалын зарчим, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Монгол Улсад хэрэгжиж буй Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хийсэн Активын чанарын үнэлгээний үр дүнгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан банкуудад Монголбанк өөрийн хөрөнгийн дутагдлыг арилгах хугацаат үүрэг даалгавар өгч, биелэлтийг хянан ажиллав. Энэ хүрээнд тогтоосон хугацаанд дутагдлаа арилгаагүй, төлбөрийн чадваргүй болсон Капитал банкныг 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Банкны тухай хуулийн дагуу албадан татан буулгаж, Банкны эрх хүлээн авагч томилсон. Түүнчлэн, бусад банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг арилгах үүрэг даалгаврын хэрэгжилтийг хянах арга хэмжээг 2019 онд үргэлжлүүлэн хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүний зэрэгцээ, банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах, төлбөрийн чадварын хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанк банкуудын ирэх гурван жилийн бизнес төлөвлөгөөг үнэлэн болзошгүй эрсдэлийг илрүүлж, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох, хугацаатай

үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай журам, эрх зүйн хэмжээ тогтоосон бусад акт, шийдвэр гаргах арга хэмжээг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд Монголбанкнаас өгсөн хугацаат үүрэг даалгаврыг биелүүлээгүй банканд хуулийн дагуу шат дараатай албадлагын арга хэмжээг авна.

Банкны хяналт шалгалтад түгээмэл мөрддөг Банкны Хяналт шалгалтын Базелийн хорооноос боловсруулан гаргасан “Банкны үр нөлөөтэй хяналт шалгалтын үндсэн зарчмууд”-ыг дэлхийн улс орны Төв банк, хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас санхүүгийн хяналт шалгалтын тогтолцооны чанар, түвшинг үнэлэх жишиг болгон ашигладаг бөгөөд банкны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дээрх олон улсын стандарттай банкны тухай хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн нийцэж байгааг тодорхойлох ажлыг гүйцэтгэнэ.

Хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжсэнээс хойш хүчин төгөлдөр үйлчилж байгаа банкны хууль тогтоомжид банкныг үүсгэн байгуулах хэлбэрийн хувьд аливаа шаардлага, хязгаарлалт тавигдаж байгаагүй бөгөөд Монгол Улсад

одоогоор үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт 13 арилжааны банкны хувь эзэмшлийн төвлөрөл ихтэй, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тоо цөөн зэргээс шалтгаалж банкны зохистой засаглалын зарчим, дотоод хяналт алдагдах, банкны үйл ажиллагаа, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Банкуудын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, шинэ хөрөнгө оруулагчаар дамжуулан банкны өөрийн хөрөнгийн бүтэц, чанарыг сайжруулж эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх нь банкны үйл ажиллагааны олон улсын стандартыг нэвтрүүлэх, банкны хяналт шалгалт, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжил, банкин дахь олон нийтийн оролцоо хяналтыг бий болгох ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”, Засгийн газрын 2017 оны 299 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх бодлого баримталж, хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр заасан.

Ялангуяа, Базелийн шинэ стандартаар энгийн хувьцааны нийт

өөрийн хөрөнгөд эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, өөрийн хөрөнгийн дийлэнх үзүүлэлтийг хангах шаардлага тавигдаж байгаагаас гадна банкны эх үүсвэрийг урт хугацааны тогтвортой санхүүжилтээр бүрдүүлэх шаардлагыг шинээр тогтоосон. Төлбөрийн чадварын хүндрэлд орсон банканд хэрэгжүүлэх бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх гол урьдач нөхцөл нь банкны өөрийн хөрөнгийг богино хугацаанд нэмэгдүүлэх, зохистой засаглалын шаардлагыг хангах, шинэ хөрөнгө оруулагчдыг татах чадвар болж байна.

Зарим улс орон банк үүсгэн байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн хувьцаат компани хэлбэрээр байгуулах банканд олгохоор тогтоон, нэг этгээдийн эзэмшиж болох хувьцааны хэмжээнд тавих хязгаарлалтыг банкны хууль тогтоомжоор нарийвчлан зааж байна. Түүнчлэн банк нь хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулснаар компанийн удирдлага, засаглалын үзүүлэлт сайжрах, эх үүсвэрийн зардал буурах, нээлттэй хувьцаат компанийн мэдээллийн ил тод байдал, олон нийтийн хяналтаар дамжин удирдлага, үйл ажиллагааны эрсдэл буурах давуу талтай. Санхүүгийн зах зээл дэх мөнгө, хөрөнгийн захын тэнцвэрийг хангаж, хөрөнгө оруулалтын хэрэгслийн төрөл, тоог нэмэгдүүлэхэд банкуудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ томоохон дэмжлэг болох юм.

Стратеги

- Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах хүрээнд банкны бизнес төлөвлөгөөг үнэлэх замаар төлбөрийн чадварт учирч болзошгүй эрсдэлийг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
- Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхэд банкандүүссэн, үүсчболзошгүй өөрийн хөрөнгийн дутагдлыг хууль тогтоомжид заасан шаардлага хангасан, чанартай эх үүсвэрээр бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- Монголбанкнаас төлбөрийн чадвар, зөрчил дутагдлыг арилгах хүрээнд тавьсан шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн банканд банкны тухай хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг тухай бүр авна.
- Банкны тухай хууль дахь банкны хувьцаа эзэмших, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид тавих шаардлага, шалгуурыг хангуулах арга хэмжээг авна.
- Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээнд үндэслэн нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх үндэслэлийг тодорхойлно.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банканд тогтоох өөрийн хөрөнгийн шаардлагыг хугацаатай төлөвлөгөөний дагуу банкуудад шат дараатайгаар нэвтрүүлж, мөрдүүлнэ.
- Банкуудаас ирүүлсэн ойрын 3 жилийн бизнес төлөвлөгөөг үнэлж, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- Төлбөрийн чадварын хүндрэлд орж болзошгүй байгаа банкуудад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу албадлагын шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Банкны өөрийн хөрөнгө болон хувь эзэмшлийн бүтэц, хэмжээ, удирдлагын шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үүсч болох эрсдэл, шийдвэрлэх асуудлын агуулгатай уялдуулан банкны тухай хуулийн өөрчлөлтийн зорилгыг тодорхойлно.
- Шаардлагатай хууль тогтоомжийн төслийн санал боловсруулж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

ЗОРИЛТ 2.3

Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг Базелийн стандарттай нийцүүлэн сайжруулах арга хэмжээг авна.

Үндэслэл

Монголбанк нь ОУВС-гийн хөтөлбөр болон банк, санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хяналт шалгалтын олон улсын сайн туршлага, зарчим, зохицуулалтыг манай улсын банкны системийн онцлогт нийцүүлэн, шат дараатайгаар нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих ажлыг үргэлжлүүлж байна.

Олон улсын түвшинд Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, зохистой засаглал, төлбөрийн чадварын үзүүлэлтүүд болон үр нөлөөтэй хяналт шалгалтад баримтлах зарчимд нийтлэг шалгуур тогтоож, харьцуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цуврал стандартыг боловсруулан гишүүн орнуудад мөрдүүлж ирсэн.

Манай улсын хувьд, банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, актив хөрөнгийн үнэлгээ, ангилал, зохистой засаглалын шаардлагыг боловсронгуй болгох, Монголбанкнаас тавих хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд мөрдөх журам, зааврыг шинээр боловсруулах, шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлуудыг 2018-2019 онд хийж гүйцэтгэлээ. Цаашид эдгээр

шинэчилсэн хяналт шалгалтын журам, зохицуулалтыг мөрдүүлэх, шат дараатайгаар хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Монголбанкнаас 2019 оны 5 дугаар сард шинэчлэн тогтоосон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааг үе шаттай нэвтрүүлэх, актив хөрөнгийн ангилал, үнэлгээг оновчтой хийх журам, зохицуулалтыг банкуудад мөрдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ. Эдгээр шинэчилсэн журмыг мөрдүүлснээр тухайн банк болон нийт банкны салбарын эрсдэл даах чадвар сайжрах, урт хугацааны тогтвортой эх үүсвэр нэмэгдэж, эх үүсвэрийн зардал буурах боломж бүрдэх юм.

Стратеги

- Банкны зохистой харьцаа, активын ангилал, төлбөрийн чадварын үзүүлэлт болон хяналт шалгалтын хүрээнд банкуудад тавих шаардлагыг Базелийн цуврал стандарттай нийцүүлэн нэвтрүүлнэ.
- Банкны салбарын эрсдэл даах чадвар болон тогтвортой өсөлтийг хангах зорилгоор банкны хяналт шалгалтын хүрээнд тогтоосон олон улсын стандарт, банкны тухай хууль тогтоомжийг оновчтой хэрэгжүүлэхэд Монголбанкнаас эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллана.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банкны үйл ажиллагаанд шинэчлэн тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг шат дараатайгаар банкуудад нэвтрүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- Базелийн цуврал стандартын холбогдох хэсгүүд, банкны актив хөрөнгөд ангилал тогтоох аргачлалыг нэвтрүүлэх, банкны хяналт шалгалт зохицуулалтын талаарх хэм хэмжээ тогтоосон акт, шийдвэр гаргаж, мөрдүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- Банкны өөрийн хөрөнгийн шаардлагад энгийн хувьцаа болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн жинг нэмэгдүүлж, Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны талаар баримтлах бодлого, чиглэлийн талаар банк, олон нийтэд мэдээлнэ.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.1

Үндэсний төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох, төлбөрийн систем дэх финтек компаниудын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ.

Үндэслэл

Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн тухай хууль батлагдсанаар төлбөрийн үйлчилгээг банкнаас гадна бусад хуулийн этгээд үзүүлэх боломж бүрдсэн. Хэдий тийм боловч шинээр гарч ирж буй төлбөрийн үйлчилгээг зохицуулах зорилгоор дээрх хуулийг дагалдан гарсан журам, зааврыг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, олон улсын байгууллагуудтай хамтран финтекийн нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгож, төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй, үр ашигтай ажиллагааг хангаж, хяналт тавин ажилласнаар төлбөрийн үйлчилгээний эрсдэлийг бууруулж хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөнгө угаах болон гэмт хэргийн шинжтэй төлбөр тооцоог хянах, шинэ дэвшилт технологийг туршиж, үйлчилгээнд нэвтрүүлэх, ингэснээр өртөг зардал буурах, иргэдийн цагийг хэмнэх зэрэг эерэг үр дагаврууд бий болохоор байна.

Стратеги:

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, мөнгөний эргэлтийг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор Монголбанк үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллана.

Үндэсний төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх стратегийн богино хугацааны зорилтод тусгасны дагуу төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бэхжүүлэх, төлбөр тооцооны “Банксүлжээ” системийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, төлбөр тооцооны болон клирингийн системүүдийн харилцан зохицолдоог хангах замаар бэлэн бус төлбөрийн хэрэгслийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын гүйлгээнд цахим төлбөр нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Үндэсний төлбөрийн системд тавих хяналтыг илүү үр дүнтэй болгох зэрэг чиглэлээр ажиллана.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Төлбөрийн системийн хяналтыг сайжруулах, төлбөрийн үйлчилгээ эрхлэгч финтек компаниудын үйл ажиллагааг дэмжих, хянах зорилгоор эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа техник туслалцааны төслийг үргэлжлүүлнэ.
- Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 3.2

Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналыг олон улсын жишигт хүргэн, мэдээллийн технологийн хөгжлийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

Монголбанк нь гадаадын төв банкуудад хэрэгжиж буй Энэтхэг улсын Intellect Design Arena компанийн “Intellect Quantum Central Banking” шийдлийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү цогц системийг нэвтрүүлж, Монголбанкны дотоод үйл ажиллагаанд ашигласнаар суурь бүртгэлийн ерөнхий дэвтэр, банкны үйлчилгээ, төрийн үйлчилгээ, мөнгөний бодлого, зээл болон барьцаа хөрөнгийн удирдлага, валютын ханшийн удирдлага, гадаад худалдаа, нөөцийн удирдлага, төсвийн удирдлага гэх мэт хоорондоо нягт уялдаа бүхий үйл ажиллагаанууд

бүрэн автомат болж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналын нэгдсэн цогц удирдлагатай болсноор төв банкны дотоод үйл ажиллагаа үр дүнтэй, нэгдсэн, хурдан шуурхай болж бусад улсуудын хэрэгжүүлж буй тэргүүн туршлагуудыг нэвтрүүлэх боломжтой болно.

Энэхүү цогц шийдлийг дотоодын тэргүүлэх компанийн боловсруулсан хүний нөөцийн удирдлагын системтэй хослуулан нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 24 сарын хугацаанд буюу 2021 оны 7 дугаар сард бүрэн нэвтрүүлсэн байхаар төлөвлөж байна.

ЗОРИЛТ 3.3

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг сайжруулна.

Үндэслэл

Иргэдийн эдийн засгийн болон санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх нь мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд банкны салбар эрчимтэй хөгжиж санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ олноор нэвтэрч байна. Хэрэглэгчдийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл, ойлголт дутмаг байгаа нь дунд болон урт хугацаанд санхүүгийн хүндрэлд орох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн

суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа болно. Үүнээс гадна Засгийн газраас 2017 онд баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг тусгасан.

Стратеги

“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг дараах 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох;
- Оюутан, залуучуудад санхүүгийн мэдлэг олгох;
- Орон нутаг, суурин газраас алслагдсан иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгоно:
 - БСШУСЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгасан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлнэ;
 - Санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ;
- Их дээд сургуулийн оюутнуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлнэ:
 - “Хувь хүний санхүү” хичээлийг мэргэжил харгалзахгүйгээр их дээд сургуулиудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:
 - Санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг үргэлжлүүлэн бэлтгэж, санхүүгийн зах зээл, хууль эрх зүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, өөрт тохиромжтой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох зэрэг ур чадварыг нэмэгдүүлэхэд сургалтыг чиглүүлнэ;
 - Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлнэ:
 - Олон нийтэд санхүүгийн суурь мэдлэг олгох сургалтыг цахим хуудас болон шинэлэг технологид суурилсан арга хэрэгслээр олгож, хүртээмжийг сайжруулахад анхаарна;
 - Төсөвчин аппликейшний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Цаашид байгаа нөөц бололцоог ашиглан бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 84 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

(2019 оны 2 дугаар улирлын байдлаар)

1. Монгол Улсаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээнд олон улсын байгууллагаас хийсэн үнэлгээг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

Төрийн эрх бүхий байгууллагууд нягт хамтран ажиллаж, 2019 оны 1 дүгээр сарын 31-нд Санхүүгийн арга хэмжээ авах бүлэг (ФАТФ)-ийн 40 зөвлөмжийн техникийн хэрэгжилтийн буюу дахин үнэлгээний тайланг Ази номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-д хүргүүлсэн бөгөөд 20 зөвлөмжийн үнэлгээг ахиулах хүсэлтийг гаргасан билээ.

АНДББ-ын зүгээс 2019 оны 5 дугаар сарын 22-нд ирүүлсэн албан бичигтээ Монгол Улсын 14 зөвлөмжийн үнэлгээ ахих боломжтой, үүний дотор 11 зөвлөмжийн үнэлгээ “дийлэнхийг хангасан”, 3 зөвлөмжийн үнэлгээ “хагас хангасан” түвшинд ахих боломжтойг дурдаад байна.

Хүснэгт 1. Монгол Улсаас гаргасан техникийн хэрэгжилтийн үнэлгээг ахиулах хүсэлт ба АНДББ-аас өгч буй урьдчилсан үнэлгээ

Зөвлөмж	Зөвлөмжийн тайлбар	Харилцан үнэлгээгээр авсан үнэлгээ	Монгол Улсаас гаргасан хүсэлт	АНДББ-аас өгч буй урьдчилсан үнэлгээ
1	Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	Хагас хангасан	Дийлэнхийг хангасан	Хагас хангасан
2	Үндэсний хамтын ажиллагаа, уялдаа холбоо	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
6	Терроризм болон ТС холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
7	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	Хангаагүй	Хангасан	Дийлэнхийг хангасан
8	Ашгийн бус байгууллага	Хагас хангасан	Хангасан	Хагас хангасан
14	Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	Хагас хангасан	Дийлэнхийг хангасан	Хагас хангасан

Зөвлөмж	Зөвлөмжийн тайлбар	Харилцан үнэлгээгээр авсан үнэлгээ	Монгол Улсаас гаргасан хүсэлт	АНДББ-аас өгч буй урьдчилсан үнэлгээ
17	Гуравдагч этгээдэд тулгуурлах	Хангаагүй	Хангасан	Дийлэнхийг хангасан
19	Өндөр эрсдэлтэй улс орнууд	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан/Бүрэн хангасан
21	Мэдээллийг задруулах болон нууцлал	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
22	СББМҮҮ Харилцагчийг таньж мэдэх	Хангаагүй	Хангасан	Хагас хангасан
23	СББМҮҮ бусад арга хэмжээ	Хангаагүй	Хангасан	Хагас хангасан
24	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
25	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
26	Санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалт, зохицуулалт	Хагас хангасан	Хангасан	Хагас хангасан
28	СББМҮҮ-ийн хяналт шалгалт, зохицуулалт	Хангаагүй	Дийлэнхийг хангасан	Хагас хангасан
29	СМА	Хагас хангасан	Дийлэнхийг хангасан	Дийлэнхийг хангасан
32	Бэлэн мөнгө тээвэрлэгчид	Хагас хангасан	Хангасан	Хагас хангасан
33	Статистик	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
34	Зааварчилгаа, эргэх холбоо	Хагас хангасан	Хангасан	Дийлэнхийг хангасан
35	Шийтгэлийн арга хэмжээ	Хагас хангасан	Хангасан	Хагас хангасан

Эдгээрээс гадна зөвлөмж 5 болон 18-г дахин үнэлсэн бөгөөд өмнө нь авсан “дийлэнхийг хангасан” үнэлгээг хэвээр үлдээх шийдвэр гаргасан байна. Ингэснээр Монгол Улсын ФАТФ-ын 40 зөвлөмжийн биелэлт дараах байдалтай болж байна. Үүнд:

Хүснэгт 2. Монгол Улсын ФАТФ-ын 40 зөвлөмж дээр авч буй үнэлгээ

№	Зөвлөмжийн үнэлгээ	Давтамж
1	Хангаагүй	-
2	Хагас хангасан	9
3	Дийлэнхийг хангасан	26
4	Бүрэн хангасан	5
Бүгд		40

Монгол Улсын зүгээс авч хэрэгжүүлсэн дээрх арга хэмжээнд үндэслэн АНДББ-аас дараах саналыг гаргаж гишүүн орнуудаараа хэлэлцүүлэхээр болсон байна. Үүнд:

1. Монгол Улсыг эрчимтэй хяналтын “enhanced follow-up (expedited)” ангиллаас гаргаж “enhanced follow-up” ангилалд шилжүүлэх;
2. 2020 оны 1 дүгээр сарын 31-ний дотор 3 дахь шатны дахин үнэлгээний тайланг гаргаж АНДББ-д хүргүүлэх үүрэг даалгаврыг Монгол Улсад өгөх;
3. Монгол Улсын Засгийн газрын холбогдох сайд нарт Монгол Улсын МУТСТ тогтолцооны доголдол, сул талыг дурдсан албан захидал хүргүүлэх.

Монгол Улсын техник хэрэгжилтийн үнэлгээ ийнхүү ахихад дараах арга хэмжээ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэв. Үүнд:

- МУТСТ тухай болон дагалдах хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулав;
- МУТСТ Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах зөвлөл байгуулагдав;
- Дээрх хууль тогтоомжид нийцүүлэн “МУТСТ урьдчилан сэргийлэх журам”, “Банкны зайнаас болон газар дээрх хяналт шалгалтын журам”-ыг шинэчлэн батлав;
- Монгол Улсын Засгийн газраас “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”-ыг 2019 оны 1 дүгээр сарын 31-ний 54 дүгээр тоот тогтоолоор батлав;
- Эрх бүхий байгууллагууд салбарынхаа МУТС эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв;
- Банкнаас бусад салбарын хяналт шалгалтыг хийх зөвлөмжийг ОУВС-ийн тусламжтайгаар боловсруулж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр арга хэмжээ авав;
- СМА-наас стратегийн шинжилгээг хийж гүйцэтгэх ажлыг эхлүүлэв;
- МУТСТ-тэй холбоотой статистик мэдээлэл гаргах маягтыг ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн гаргав;

- МУТСТ-тэй тэмцэх гарын авлага, зааврыг хэд хэдэн чиглэлээр боловсруулж гаргав (Улс төрд нөлөө бүхий этгээдийн гарын авлага, Эцсийн өмчлөгчийг тогтоохтой холбоотой гарын авлага, Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх гарын авлага зэрэг болно).

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 24-ний хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-наас “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2 дахь удаагийн харилцан үнэлгээний тайлан” болон “Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан дутуу гүйцэтгэлтэй зөвлөмж, арга хэмжээний жагсаалтад үндэслэн 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлөөс 2019 оны 10 дугаар сар хүртэл авч хэрэгжүүлэх нэмэлт ажлын төлөвлөгөөг батлаад байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 28-ны хамтарсан А/92, А-144 тушаалаар байгуулагдсан Монгол Улсын үр дүнтэй байдлыг тайлагнах Ажлын хэсэг Хяналтын хугацааны дараах шууд хэрэгжилтийн тайланг боловсруулж 2019 оны 7 дугаар сарын 22-нд АНДББ-д хүргүүлээд байна. Монгол Улс техникийн хэрэгжилтийн 20 зөвлөмжийн үнэлгээг ахиулах хүсэлт гаргаснаас хойш АНДББ-ийн үнэлгээний багаас нэмэлт мэдээлэл авах хэд хэдэн асуулгыг ирүүлсэн бөгөөд Монгол Улсын холбогдох төлөөллүүд тухай бүр хариу өгөх байдлаар ажиллав. Улмаар 2019 оны 5 дугаар сарын 23-нд Монгол Улсын дахин үнэлгээний тайлангийн төслийг эцэслэж гишүүн орнуудад хүргүүлсэн байна. ФАТФ, Индонез улсаас өгсөн санал, шүүмж болон Монгол Улсаас гаргасан хүсэлтийг үндэслэж хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлаад байна. 2019 оны 8 дугаар сарын 15-23-нд Австралийн нийслэл Канберра хотноо болох АНДББ-ын жилийн уулзалтаар Монгол Улсын дахин үнэлгээний тайланг хэлэлцэнэ. Ингэснээр Монгол Улсын Харилцан үнэлгээний тайлан өөрчлөгдөж, Дахин үнэлгээний тайлан хэвлэгдэх юм.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны талаарх эцсийн шийдвэрийг ФАТФ-ын зүгээс 2019 оны 10 дугаар сард гаргахаар хүлээгдэж байна.

2. Гадаад валютын нөөцийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан түвшинд дунд хугацаанд хүргэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх, алт барьцаалан

урьдчилсан санхүүжилт татах боломжийг судлах зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. Тодруулбал, иргэн, аж ахуйн нэгжийн олборлосон алтыг Монголбанканд болон арилжааны банкуудад худалдахыг идэвхжүүлэх замаар алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулах зорилго бүхий 6 сарын хугацаатай “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр эхлүүлж, нээлтийг 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Монголбанк Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран зохион байгуулав.

Монголбанк “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр аяны нээлтийг Монголбанкны хурлын зааланд зохион байгуулав.
2. 2019 оны 5 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай аймагт алт олборлож байгаа уурхай, бичил уурхайчдын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, тулгарч байгаа асуудлыг судлан, сурвалжлага, нэвтрүүлэг бэлтгэв. Мөн төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах, алтны олборлолт, худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор бичил уурхайчид, төрийн албан хаагчид болон иргэдэд сургалт зохион байгууллаа.
3. Банкууд, 17 аймаг дахь Монголбанкны хэлтэс, салбарууд тухайн орон нутаг дахь бичил уурхайчид, хувиараа алт олборлогч, алтны компаниудад Монголбанк, банкуудын алт худалдан авалтыг сурталчлах, Монголбанк, банкандаа олборлосон алтаа худалдахыг уриалж, сургалт зохион байгуулж, мэдээлэл сурталчилгаа хийлээ.

Монголбанк 2019 оны эхнээс 7 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд 7.5 тонн үнэт металл худалдан авч ГВУН 259 сая ам.доллараар өссөн боловч энэ нь өмнөх оны мөн үед 9.2 тонн үнэт металл худалдан авснаас 1.6 тонноор бага буюу 18%-иар буурсан үзүүлэлттэй байна. Харин алтны урьдчилсан санхүүжилтийн хүрээнд боломжит олон улсын банкуудтай холбогдож, ирүүлсэн санхүүжилтийн саналыг судлан ажиллаж байна. Мөн Монгол улсын аж ахуйн нэгж болон арилжааны банкууд олон улсын зах зээл дээр бонд гаргах, гадаад валютаар эх үүсвэр татахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн 03/3/А-5 тоот хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс Монголбанк гадаад валют шууд худалдан авч ажиллав. 2019 оны эхний хагас жилд аж ахуйн нэгж байгууллага, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн Банк зэрэг байгууллагаас нийт 1182.0 сая ам.долларыг худалдан авлаа. Гадаад валютын

улсын нөөцийг нэмэгдүүлэхээс гадна гадаад валютын дотоодын захын үр ашгийг нэмэгдүүлэх, дотоодын нөөц бололцоогоо дайчлах зорилгоор “Банк хоорондын валют арилжааны цахим талбар”-ыг хөгжүүлэх, түүний хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Тодруулбал, Монголбанкны дотоодын нөөцөд тулгуурлан хөгжүүлж, сайжруулсан банк хоорондын валют арилжааны цахим талбарын шинэ хувилбарыг ашиглаж эхлээд байна. Валют арилжааны захыг идэвхжүүлж үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор оролцогч арилжааны банкуудын тоог нэмж, холбогдох гэрээ болон журамд сайжруулалт шинэчлэлттэй холбоотой өөрчлөлтийг оруулсан болно.

3. Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах;

Зээлийн хүү өнгөрсөн оны түвшнээс буурсан, одоо харьцангуй тогтворжиж байна. Инфляцийн хүлээлт болон банкуудын зээлийн төлөвийн түүвэр судалгааны тайлангууд, банкуудын макро эдийн засгийн талаарх төсөөллийн нэгтгэлийг боловсруулж тайланг Монголбанкны хэвлэлийн бага хурал, Монголбанкны цахим хуудсанд байршуулах хэлбэрээр нийтэд мэдээллэж байна.

Үндэсний Статистикийн хорооноос эрхлэн явуулдаг өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны мэдээллийг ашиглан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтийн ажилгүйдэл болон бусад хүчин зүйлст үзүүлэх нөлөөг судлах ажил хийгдээд байна.

Өрхийн хэрэглээний бүтэц, бодлогын шийдвэр гаргалтын хэрэглээнд үзүүлэх нөлөөллийг судлах ажлын хүрээнд нэмүү өртгийн албан татварын И баримтын мэдээллийн санг ашиглах боломжийн талаар Татварын Ерөнхий газраас тодруулан боломжит тоон өгөгдлүүдийг судалж байна.

Гадаад өрийн албан ёсны үзүүлэлтүүдийн бүртгэл тооцооллыг сайжруулах ажлын хүрээнд Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийцүүлж “Гадаад зээлийн бүртгэлийн журам”-ыг “Хуулийн этгээд, иргэний гадаад хөрөнгө оруулалт, өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” нэртэйгээр шинэчлэн боловсруулж Монголбанкны Хууль, эрх зүйн газар болон холбогдох бусад газраас саналыг авч тусган Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулсан. Мөн шинэчилсэн журмын талаар аж ахуйн нэгжүүдийн Төлбөрийн тэнцлийн тайлангийн сургалтын үеэр танилцуулан, саналыг авч тусгав.

Монгол Улсын нийт гадаад өрийн тоон мэдээллийг Олон улсын валютын сангийн мэдээлэл түгээх тусгай стандартын дагуу бэлтгэн, ОУВС-гийн мэргэжилтнүүдээр хянуулж, Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд улирал тутам ОУВС болон Монголбанкны цахим хуудсаар мэдээлж байна.

Зээлийн хүүг бууруулах стратегийн зээлийн эрсдэлийг бууруулах зорилтын хүрээнд Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журамд зээлийн эрсдэл хамгийн өндөр байдаг холбогдох этгээдтэй хийх хэлцлийн нөхцөл шаардлагыг тодорхой тусган Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019.02.12-ны өдрийн А-37 дугаар тушаалаар баталлаа. Энэ журмын зорилго нь харилцан хамаарал бүхий этгээдийг тодорхойлох, банкнаас холбогдох этгээдтэй харилцахад баримтлах зарчим, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлээр тодорхойлсон хязгаарлалтын биелэлт тооцох, тайлагнах, хянах, мөн хуулийн 33.4 дэх хэсэгт заасан томоохон харилцагчийн нэгдсэн тогтолцоог бий болгохтой холбогдох харилцааг зохицуулахад чиглэгдсэн бөгөөд Банкны үйл ажиллагааны хязгаарлалт нь том харилцагчийн активт голлон хамаарч байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн Ажлын алба нь “Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөр тасалбар болгон холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн Монголбанкны 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А-1/623 тоот албан бичгээр Ерөнхий сайд, УИХ-ын дарга, УИХ-ын нэр бүхий гишүүд, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, УИХ дахь Монгол Ардын Намын бүлэг, СЗХ, Сангийн яам, ХДК-д тус тус хүргүүлэв. Холбогдох арга хэмжээний төлөвлөгөөнд тухайлсан нэг байгууллага эсвэл холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэх нийт 205 арга хэмжээ туссанаас тайлант хугацаанд 76 нь бүрэн биелсэн, 106 нь хэрэгжих шатандаа гэсэн төлөвтэй байгаа бол хэрэгжүүлж эхлээгүй 20 арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа болоогүй 3 арга хэмжээ байв. Тус стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн ерөнхий дүн 67 хувьтай гарсан болно.

Түүнчлэн СТБЗ-ийн 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар “Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл” батлагдсанаар Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг үр дагаврын талаар авч хэлэлцсэн бөгөөд СТБЗ-өөс уг асуудалтай холбогдуулан зөвлөмж гаргаж, Монгол Улсын Их Хурлын дарга, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөл, Монголын банкны холбоонд тус тус хүргүүлэв.

4. Чанаргүй активыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах;

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Банк, санхүүгийн салбарын чанаргүй активыг бууруулах чиглэлээр Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Монголбанк, Сангийн яам, Монголын банкны холбоо болон хуульч, өмгөөлөгчдийн төлөөллийг оролцуулсан Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-323, А-324 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж хуулийн төслийн саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

Ажлын хэсгээс хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг зээлдүүлэгчийн мөнгөн төлбөрийн шаардах эрхийг баталгаажуулах, шүүхэд хандсанаас үл хамааран зээлийн хүүг хуримтлуулан тооцдог байх, хуулийн этгээдийг татан буулгахад шаардлагын дараалалд хууль ёсны барьцаагаар хангагдсан шаардлага хамаарахгүй байх, иргэний хэрэг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийн шат бий болгох, шийдвэр гүйцэтгэлийн явцад хөрөнгийг үнэлэхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу үнэлгээчнээр үнэлүүлдэг байх болон шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд зөвхөн хуульд тусгайлан заасан нөхцөл, шаардлага, журмыг зөрчсөн бол гомдол гаргадаг байх агуулгаар боловсрууллаа.

Түүнчлэн ажлын хэсгээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн тандан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоо, дагалдан гарах хуулийн төслийг хийж гүйцэтгэсэн бөгөөд хуулийн төслийн саналыг хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлж батлуулахад хамтран ажиллана.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг стандарт, жишгийг Монгол Улсад нэвтрүүлэх, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хүргэх, үнэлгээчний хариуцлага, тайлан, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор боловсруулсан “Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг боловсруулахад хамтран ажиллаж байна. Нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, ялангуяа банкны хөрөнгийн үнэлгээнд тавигдах шаардлага, үнэлгээ хийх журам, стандартыг санхүүгийн хянан зохицуулагч байгууллага хамтран батлах саналыг хүргүүлээд байна. Банкнаас олгох зээлийн барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээг олон улсын жишигт нийцүүлэн бодитоор тодорхойлдог байх үүднээс “Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ыг батлан, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авна.

Уг стратегийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-32 дугаар тушаалаар баталлаа. Энэхүү журамд банкууд чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөг жил бүр боловсруулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам банкны ТУЗ, Монголбанк болон олон нийтэд тайлагнах зохицуулалтыг тусгаснаараа онцлог юм. Стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор банкуудад уг журмыг

хүргүүлэхийн хамт чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөг журмын дагуу боловсруулж Монголбанканд 2019 оны 4 дүгээр сарын 30-ны дотор ирүүлэхийг үүрэг болгоод байна.

“Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, УИХ дахь Монгол Ардын Намын бүлэг, УИХ дахь Ардчилсан Намын Зөвлөл, Сангийн яам, СЗХ, ХДК-д тус тус хүргүүлэв. Холбогдох арга хэмжээний төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд тухайлсан нэг байгууллага эсвэл холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэх нийт 32 арга хэмжээ туссанаас тайлант хугацааны эцэст арга хэмжээнүүдийн биелэлт дунджаар 71.3 хувьтай гарсан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 7 арга хэмжээ бүрэн биелсэн, 14 арга хэмжээ хэрэгжих шатандаа байгаа бол хэрэгжүүлж эхлээгүй болон биелэлт ирүүлээгүй 11 арга хэмжээ байв.

5. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжилтийг хангах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

“Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг Дэлхийн банкнаас 2012 оны 10 дугаар сард гаргасан “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношлогоо дүгнэлт”, Монголбанкнаас Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран 2017 онд хэрэгжүүлсэн “Санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих” төслийн бүрэлдэхүүн хэсэг болох “Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь” төслийн хүрээнд гаргасан тайлан болон АХБ-аас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-д өгсөн зөвлөмжийн дагуу боловсруулан тодорхойлж, судалгааны дүгнэлт зөвлөмжийн дагуу хуулийн төслийг боловсруулав.

Төрийн болон төрийн бус байгууллагууд, судлаач, олон нийтийн дунд хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулан хэлэлцүүлж, хууль санаачлагчид уламжлаад байгаа уг төсөлд санхүүгийн үйлчилгээ, түүний хэрэглэгчийн тодорхойлолт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн баримтлах зарчим, хүлээх үүрэг, санхүүгийн үйлчилгээний нөхцөл шаардлага, хэрэглэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, маргаан урьдчилан шийдвэрлэх шүүхийн бус механизм, мэдээллийн ил тод байдал ба санхүүгийн боловсролтой холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлохоор тусгасан болно.

6. Санхүүгийн салбарыг дэмжиж, тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах;

Банкны системийн эрсдэлийг бууруулах чиглэлд макро зохистой бодлогын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, системийн эрсдэлийг эрт үед илрүүлэх, эрсдэлийг бууруулах хүрээнд зохицуулагч байгууллага хоорондын мэдээлэл солилцох, шийдвэрийг түргэн шуурхай гаргуулахаар

Хяналт шалгалтын газрын зүгээс ОУВС-д хүсэлт тавьсны дагуу 2018 оны 6 дугаар сард Банкны системийн мониторингийн тайланг хэрхэн гаргах, тоон мэдээллийг хэрхэн боловсруулах талаар техник туслалцаа авсан. Тус арга хэмжээний үр дүнд Банкны системийн мониторингийн тайланг олон улсын жишигт нийцүүлэн илүү боловсронгуй болгон холбогдох загварын дагуу бэлтгээд байна.

Хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегид тусгасан ажлууд нь ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хийх ажлуудтай агуулгын хувьд давхцаж байгаа бөгөөд энэ хүрээнд хийгдэж буй ажлуудыг гүйцэтгэж төлөвлөгөөг хангаж байна. Тухайлбал, “Зээл олгох, зээлийн эрсдэлийг үнэлэх журам”-ын төсөл болон “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д оруулах нэмэлт өөрчлөлтийг боловсруулж, англи хэл дээр орчуулж ОУВС-ийн зөвлөхөд санал авахаар хүргүүлээд байна. Мөн хүчин төгөлдөр мөрдөж буй Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-155/134 дүгээр хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинэчлэн баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

Түүнчлэн хүндрэлд орсон банкуудыг татан буулгах, албадлагын арга хэмжээг авахад мөрдөж байгаа зарим зохицуулалтыг илүү уян хатан болгож өөрчлөх, банкуудад хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зохицуулалтыг бий болгов. Тухайлбал, Банкны тухай хуульд 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө албадлагын арга хэмжээ нь Онцгой дэглэм тогтоох, Банкны эрх хүлээн авагч томилох гэсэн хоёр хэлбэртэй байсан нь уг хуульд орсон өөрчлөлтөөр банкны тогтворжуулалт, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, банкны нөхцөлт удирдлага, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ, банкиг татан буулгах гэсэн 5 дэд хэсэгт хуваагдсан. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор холбогдох журмуудыг Олон Улсын валютын сангийн зөвлөмж, Монголбанкнаас өмнө авсан албадлагын арга хэмжээний туршлага зэргийг үндэслэн боловсруулж тайлант онд “Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх, бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам”, “Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх журам”, “Банкыг албадан татан буулгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх журам”-ыг баталлаа.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн дугаар А-107/290/88/14 хамтарсан тушаалаар санхүүгийн салбарын тэнцвэртэй хөгжил, тогтвортой байдлыг

хангахад чухал ач холбогдолтой “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж, холбогдох байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

7. Монгол Улсын гадаад валютын урсгалын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улирал тутам тайлагнаж байх;

Монголбанк нь банкны системээр дамжин хийгдэж буй гадаад валютын урсгалын мэдээллийг өдөр, сарын давтамжтайгаар арилжааны банкуудаас тогтмол хүлээн авч байна.

8. Ипотекийн зээлийг эдийн засгийн төлөв, санхүүгийн чадавхтай уялдуулж урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх;

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 35 дугаар тогтоолоор банканд олгодог ипотекийн зээлийн эх үүсвэрийн хүүг 1 хувь хүртэл бууруулж, банкуудын өөрийн эх үүсвэрийг хөтөлбөрийн санхүүжилтэд татан оролцуулах чиглэлийг Монголбанк, Засгийн газарт өгсөн. Үүний дагуу Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 369 дүгээр тогтоолоор “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн журам” батлагдан, Засгийн газрын эх үүсвэрийг Монголбанк дамжуулан зээлдүүлэх “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-г 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр байгууллаа. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/А-334 дүгээр тушаалаар Монголбанкийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр”-өөс гаргах төлөвлөгөө батлагдсанаар Монголбанк 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр болов.

Дээрх эрх зүйн актууд батлагдсантай холбоотойгоор хөтөлбөрийн эх үүсвэр болон үнэт цаасжуулалтын бүтцэд өөрчлөлт оруулан, санхүүжилтийн схемийг бүрэн шинэчлэн талууд хоорондын харилцааг зохицуулах “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр байгуулан орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийг банкуудад олгоод байна.

Монголбанк ипотекийн зээлийн хөтөлбөрийг өөрийн өмчлөлийн ипотекийн зээлээр баталгаажсан бондын зөвхөн үндсэн төлбөрийн орлогоос сар бүр 16 тэрбум төгрөг, Засгийн газрын эх үүсвэрээс улсын төсөвт тусгасан 115 тэрбум төгрөгийг сар бүр банкуудад хуваарилж байна.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны эхний 6 сарын байдлаар нийт 210 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2,937 иргэнд олгоод байна. Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 95 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,294 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 55 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 882 иргэнд, банкууд өөрийн эх үүсвэрээс 60 тэрбум төгрөгийн санхүүжилтийг

761 иргэнд олголоо. Олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг амлалтын дагуу хөтөлбөрийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Засгийн газарт бүрэн шилжүүлэх юм.

9. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;

Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулж, судалгаа хийх, холбогдох ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг Монголбанк, Эрдэнэс Алт Ресурс ХХК хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын явцын талаар Эдийн засгийн байнгын хороонд Монголбанкнаас 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр А-1/277 тоот албан бичиг хүргүүлэв.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-34 дүгээр тушаалаар Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулж, судалгаа хийх, холбогдох ажлыг эхлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
- Монголбанкны алт цэвэршүүлэх чиглэлээр хамтран ажилладаг Швейцарийн Argor-Heraeus SA цэвэршүүлэх үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулахад хамтран ажиллах талаар холбогдох уулзалтыг зохион байгуулав.
- Алт цэвэршүүлэх үйлдвэрийн барилга байгууламж, технологийн шийдэл, хөрөнгө санхүүгийн хэрэгцээ, үйл ажиллагааны менежмент зэргийг тодорхой болгоход шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Эрдэнэс Алт Ресурс ХХК-ийн Үнэлгээний хороонд хамтран ажиллаж байна.
- “London Bullion Market Association”-ны “Сайн цэвэршүүлэгч” алт цэвэршүүлэх үйлдвэрүүдийн бизнесийн үйл ажиллагааг судлан холбогдох танилцуулгыг боловсруулж 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А-1/277 албан тоотоор УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэв.
- Эрдэнэс Алт Ресурс ХХК Казакстан улсын Даниель М ХХК-тай Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үйлчилгээ худалдан авах гэрээг 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр байгууллаа. Эрдэнэс Алт Ресурс ХХК алт цэвэршүүлэх үйлдвэр барихаар Сонгино Хайрхан дүүргийн 32 дугаар дүүрэгт 4 га газар авсан бөгөөд байгаль орчны багц үнэлгээний судалгаа хийлгэх ажлыг эхлүүлээд байна.
- Монголбанк, Эрдэнэс Алт Ресурс ХХК, Стандарт хэмжил, зүйн газар, Бринкс Монгол ХХК-ийн хамтарсан Ажлын хэсэг 2019 оны 6 дугаар сарын 12-16-нд Швейцарийн Холбооны Улсад байрлах Argor-Heraeus SA алт цэвэршүүлэх үйлдвэр, Brinks Switzerland компанийн үйл ажиллагаатай танилцсан.
- Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдвэрлэх талаар Эрдэнэс Алт Ресурс ХХК судалж байна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

(2019 оны 2 дугаар улирлын байдлаар)

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:


1.1 Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2019-2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна;

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжигдэх инфляци 2019 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 8.1 хувь буюу Төв банкны 8% зорилтот түвшний орчимд байв. Эдийн засгийн идэвхжлийг даган нийт эрэлтийн өсөлттэй холбоотой инфляци алгуур нэмэгдсэн ч харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдаж байгаа бол нийлүүлэлтийн гаралтай цөөн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт инфляцийн хэлбэлзлийг голлон тайлбарлаж байна.

Зураг 5. Улсын болон УБ хотын инфляци



Зураг 6. УБ хотын жилийн инфляци (бүрэлдэхүүнээр)



Эх сурвалж: УСХ

Улаанбаатар хотын жилийн инфляци 6 дугаар сард 9.6%-д хүрэхэд хүнсний бүтээгдэхүүн (3.3 нэгж хувь), импортын бараа (2.1 нэгж хувь), болон дотоодын бараа (1.9 нэгж хувь)-ны үнийн өөрчлөлт голлох нөлөө үзүүлжээ (Зураг 6). Үүнд:

- Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон банкны зээл олголт харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж, төсвийн тэлэлт, цалин орлогын өсөлттэй уялдаад эрэлтийн гаралтай инфляци сүүлийн 2 жил гаруй хугацаанд алгуур нэмэгдэж буй ч, тогтвортой түвшинд хадгалагдаж байна.
- Махны үнэ 5 дугаар сард нийлүүлэлтийн хомсдлоос үүдэн огцом өсч, 6 дугаар сард улирлын хандлагын дагуу буураагүй нь сүүлийн 2 сард инфляци эрчимжихэд голлон нөлөөллөө (Жилийн инфляцийн

2.96 нэгж хувь). БНХАУ-д гахайн мялзан өвчний тархалт үргэлжилж, орлуулах бүтээгдэхүүний эрэлт өндөр байхаар хүлээгдэж байгаа тул махны экспортын хэмжээ энэ онд 2018 оны адил өндөр байхаар байна. Иймд Засгийн газраас дотоодын махны нийлүүлэлт, үнэд огцом савлагаа үүсгэхгүй байх зохицуулалтыг хэрхэн хийхээс оны 2 дугаар хагасын инфляцийн хэлбэлзэл хамаарахаар байна.

- Өрхийн бодит орлого нэмэгдэж, өрхийн хэрэглээ сэргэхийн зэрэгцээ импортын бараа, тэр дундаа хувцасны бүлгийн үнэ өссөн нь инфляцийн 2.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хатуу түлшний үнэ 2 дугаар улиралд өөрчлөлтгүй байснаар жилийн инфляцид үзүүлэх нөлөө нь 0.9 нэгж хувийг бүрдүүлж байна. 2019 оны 5 дугаар сараас түүхий нүүрсийг сайжруулсан түлшээр орлуулж, Засгийн газраас нийлүүлэлт болон үнэд хийж буй зохицуулалтын үр дүнгээс түүний инфляцид үзүүлэх нөлөө нь хамаарна.
- Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарч эрчим хүчний эрэлт буурч буй ч, нийлүүлэлтийн шалтгаанаас үүдэн газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнэ савлаж байна. Шатахууны хилийн үнэ газрын тосны үнийн өөрчлөлтийг даган хэлбэлзэж байгаа бөгөөд дотоодын шатахууны үнэ 5 дугаар сард 100-170 төгрөгөөр өсч, 6 дугаар сард эргэн 30-40 төгрөгөөр буураад байна (Жилийн инфляцийн 0.65 нэгж хувь).
- Эдийн засгийн идэвхжил нэмэгдэхтэй зэрэгцээд дотоодын жуулчлал нэмэгдсэнээр аялал жуулчлалын идэвхтэй улирал эхэлдэг 6 дугаар сард үнэ өсөх хандлагатай болж, сарын 57 хувиар огцом өслөө (Жилийн инфляцийн 0.6 нэгж хувь).

Мөнгөний бодлогын шийдвэр

- Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах, Банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 60 хувиар шинэчлэн тогтоов. Мөнгөний бодлогын хороо инфляцид нөлөөлж буй эрэлт, нийлүүлэлтийн болон гадаад хүчин зүйлс, тэдгээрийн цаашдын төлөв, бизнесийн идэвхжлийг харгалзан бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалахаар шийдвэрлэсэн болно. МБХ-ны 6 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хурлаар макро эдийн засгийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, гадаад дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзэж Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалахаар шийдвэрлэв.
- Мөнгөний бодлого эдийн засгийн идэвхжилд эрэлт талаас нь

тодорхой хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлдөг тул тогтмол шинж чанар багатай, түр зуурын нийлүүлэлтийн шинж чанартай бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хариу үйлдэл үзүүлэхгүй байх зарчмыг 2019 оны Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл (ТМБҮЧ)-д тусгасан. Монголын эдийн засагт гадаад болон дотоод орчноос хамаарсан эрэлт, нийлүүлэлтийн гаралтай шокууд тогтмол бий болж, зарим саруудад үнийг савлуулах нөлөө үзүүлдэг боловч мөнгөний бодлого дунд хугацаанд инфляцийн хэлбэлзлийг тогтворжуулж, зорилтот түвшинд нь байлгахыг зорьж байна.

- Тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг бууруулж, 60 хувиар тогтоох шийдвэр нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсч, өндөр түвшинд хүрсэн хэрэглээний зээл, иргэдийн өрийн дарамтыг цалингийн өсөлттэй уялдуулан аажмаар бууруулах зорилготой байв.
- Мөнгөний бодлогын хорооны хурлын шийдвэрүүдийг тухай бүр хэвлэлийн бага хурлаар танилцуулж, мөнгөний бодлогын мэдэгдлийг Монголбанкны цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ хурлын хураангуй тэмдэглэлийг хурлаас хоёр долоо хоногийн дараа мөн цахим хуудсанд байршуулан Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллалаа.

1.2. Эдийн засгийн дархлааг дэмжих, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, алтны урьдчилсан санхүүжилт татах талаар судлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Тухайлбал, (1) иргэн, аж ахуйн нэгжийн олборлосон алтыг Монголбанканд болон арилжааны банкуудад худалдах явцыг идэвхжүүлэх замаар алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулах зорилго бүхий 6 сарын хугацаатай “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр эхлүүлж, нээлтийг 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран зохион байгуулав, (2) алтны урьдчилсан санхүүжилтийн хүрээнд боломжит олон улсын банкуудтай холбогдож, ирүүлсэн санхүүжилтийн саналыг судлан ажиллаж байна. Мөн Монгол улсын аж ахуйн нэгж болон арилжааны банкууд олон улсын зах зээл дээр бонд гаргах, гадаад валютаар эх үүсвэр татахад дэмжлэг үзүүлэн ажиллав, (3) Сангийн яам болон бусад ААНБ-аас 696.1 сая ам.долларыг худалдан авав. Тухайлбал, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн 03/3/А-5 тоот хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон

төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс Монголбанк гадаад валют шууд худалдан авч ажилласан бөгөөд тайлант хугацаанд ААНБ болон Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас нийт 1182.0 сая ам.долларыг худалдан авлаа. Түүнчлэн, тайлант улиралд Монголбанк 49 удаагийн гадаад валютын дуудлага худалдаа /ГВДХ/-г зохион байгуулж, гадаад валютын дуудлага худалдаа (ГВДХ) болон Банк хоорондын валют арилжааны цахим талбар (БХВАЦТ)-аар дамжуулан 1193.3 сая ам.долларыг захад нийлүүллээ.

Монголбанк банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамт, дотоодын зах зээл дэх долларжилтыг бууруулах зорилгоор банкуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос тус тус байгуулж эхэлсэн юм.

Монголбанкнаас тайлант улиралд богино хугацаат своп хэлцэл байгуулаагүй боловч нийт 520.3 сая ам.долларын бодит бус урт хугацаат своп хэлцэл байгууллаа. Нийт байгуулсан хэлцлийн дүнг 2018 оны мөн үетэй харьцуулбал 725.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант улиралд нийт 119.0 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн хугацаа дуусч төлбөр тооцоог гүйцэтгэсэн бөгөөд урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 1981.5 сая ам.доллар байна.

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхээс гадна гадаад валютын дотоодын захын үр ашгийг нэмэгдүүлэх, дотоодын нөөц бололцоогоо зөв зүйтэй ашиглах зорилгоор Монгол Улсын экспортын голлох түүхий эд болох зэс, коксжих нүүрс, төмрийн хүдэр, мөнгөжсөн алт, газрын тосны экспорт, гадаад болон дотоод зах зээл, цаашдын төлөв байдлын талаарх дэлгэрэнгүй тайланг боловсруулах, “Банк хоорондын валют арилжааны цахим талбар”-ыг хөгжүүлэх, түүний хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна. Тодруулбал, Монголбанкны дотоодын нөөц бололцоонд тулгуурлан хөгжүүлж, сайжруулсан Банк хоорондын валют арилжааны цахим талбарын шинэ хувилбарыг ашиглаж эхэлсэн бөгөөд хөгжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна. Банк хоорондын валют арилжааны цахим талбарын дэд бүтцийг сайжруулснаар оролцогч арилжааны банкуудын тоо нэмэгдсэн бөгөөд энэ нь валют арилжааны захыг идэвхжүүлж үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

1.3. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ;

Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшин хүртэл сааруулж, өрхийн өрийн дарамтыг хязгаарлах, улмаар банкны системд

эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилготой макро зохистой бодлогын арга хэмжээ 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Улмаар 2019 оны эхэнд хэрэглээний зээлийн өсөлт саарч байсан боловч 4 дүгээр сард төрийн албан хаагчдын цалин нэмэгдэх, түүнийг дагаад хувийн секторын цалин мөн нэмэгдэж улмаар иргэд хэрэглээний зээлээ нэмэгдүүлэн өрийн дарамтаа нэмэгдүүлэх эрсдэлтэй байв. Монголбанк 2019 оны 1 дүгээр улиралд хэрэглээний зээлтэй иргэдийн өр, орлогын харьцааны статистикийн төлөв байдал, цалин нэмэгдсэнээр шинээр үүсч болзошгүй хэрэглээний зээлийн эрэлт, цалингийн өсөлттэй уялдуулан иргэдийн өрийн дарамтыг бууруулах боломж зэргийг судалж, өр, орлогын харьцааны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох макро зохистой бодлогын шинжилгээг гүйцэтгэв. Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хурлаас тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 60 хувиар шинэчлэн тогтоож, 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр шийдвэрлэв. Макро зохистой бодлогын арга хэрэгслийг ашигласнаар мөнгөний бодлогыг чангаруулахгүйгээр хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах, улмаар бизнесийн зээлийн өсөлтийг дэмжих боломж бүрдэв. Ийнхүү 2018 оны эцэст 55 хувьд хүрээд байсан хэрэглээний зээлийн өсөлт 2019 оны 6 дугаар сарын байдлаар 25 хувь болж саарсан. Түүнчлэн хэрэглээний зээлийн хувьд тооцох өр, орлогын харьцааны статистик нь 2018 оны эцэст дунджаар 62 хувь байсан бол 2019 оны 6 дугаар сард 58.9 хувьд хүрч буурлаа.

Макро зохистой бодлогын шинжилгээнд ашиглах, хяналт тавих зорилгоор Монголбанк иргэдийн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааг тооцох аргачлалыг боловсруулж, улмаар тус статистикийг 2018 оны 9 дүгээр сараас эхлэн банкуудаас гаргуулан авч, мэдээллийн санг үүсгэж байна. Шинээр тооцож буй өр, орлогын харьцааны статистикийг боловсруулахад учирч буй хүндрэл, асуудлууд, сайжруулах боломжит саналуудыг банкуудаас хүлээн авч өр, орлогын харьцааг тооцох аргачлалыг шинэчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А-52 дугаар тушаалаар батлав. Шинэчлэгдсэн аргачлалын дагуу тооцсон өр, орлогын харьцааны статистикийг 2019 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн банкуудаас авч байна.

Монголбанк нь хэрэглээний зээлийн хувьд авч хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 4 дүгээр сард нэг банканд тусгайлсан газар дээрх хяналт шалгалтыг хийж, шалгалтын үеэр илэрсэн дутагдлыг 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор арилгав. Газар дээрх хяналт шалгалтын үр дүнд тулгуурлан зөвлөмж боловсруулж бүх банканд хүргүүлээд байна.

1.4. Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, бодлогын үр нөлөөг дээшлүүлнэ;

Монголбанк бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлан таниулж, Төв банкны нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангах зарчмын дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

Мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлж, тайлбарлах ажлын хүрээнд:

Мөнгөний бодлогын хороо хуралдах, инфляцийн тайлан гарах, бусад статистик мэдээлэл тархаах хуваарийг гаргаж, вэб хуудсаар мэдээллээ. Төв банкны олон нийттэй харилцах гол арга хэрэгслүүдийн нэг болсон инфляцийн тайланг тайлбарлан түгээх ажлын хүрээнд 2019 оны 1, 4, 7-р сард банк, санхүүгийн салбарын мэргэжилтнүүд болон судлаачид, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагч нарт танилцуулга хийлээ. Мөн Инфляцийн тайлангийн “Хураангуй” хувилбарыг олон нийтэд ойлгомжтой, инфографик хэлбэрээр товчлон боловсруулж албан ёсны сошиал хаягуудаар түгээв.

Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 1, 2 дугаар улирлын хурлын шийдвэрийн мэдэгдлийг Монголбанкны цахим хуудсанд байршуулж, хэвлэлийн бага хурлаар танилцуулж, бодлогын хүүний болон макро зохистой бодлогын шийдвэрүүдийн үндэслэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд мэдээлэв. Мөн Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүд болон Мөнгөний бодлогын газрын захирлыг хэвлэлийн ярилцлагуудад оролцууллаа. Мөнгөний бодлогын шийдвэр, шийдвэрийн үндэслэлийг эдийн засагт оролцогч талууд буюу судлаач, шинжээчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд тайлбарлахын тулд веб хуудас, сошиал хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл хүргэж байна.

Түүнчлэн инфляцийн өөрчлөлт, цаашлаад Улаанбаатар хотын инфляци өссөн шалтгааныг харуулсан инфографикийг бэлтгэн Монголбанкны сошиал хаягуудаар тайлбарлан түгээв. Макро зохистой бодлогын хүрээнд хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаар оны эхнээс хэрэгжиж эхэлсэн тул тус бодлогын зорилго, үр нөлөөг статистик дээр үндэслэж өргөн хүрээнд тайлбарлан таниулах ажлуудыг хийлээ.

Олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд нийт 8 удаа хэвлэлийн бага хурлыг зохион байгуулснаас цаг үеийн мэдээлэл өгөх, банк санхүүгийн сектор, төлбөрийн тэнцлийн статистик танилцуулах хэвлэлийн хурлыг 6 удаа, мөнгөний бодлогын шийдвэр танилцуулах хурлыг 2 удаа зарлан хуралдуулав. Үүнээс гадна Монголбанкнаас 83 ярилцлага, тодруулга, 48 нийтлэл, 119 мэдээг бэлтгэн

хүргэж, “Төв банк ба төгрөг” ТВ нэвтрүүлгийн 21 удаагийн дугаар цацагджээ. Түүнчлэн, эдийн засгийн сэтгүүлчдийг мэргэшүүлэх “Төв банкны мэргэшсэн сэтгүүлчид клуб”-ыг байгуулж, тэднээр дамжуулан, олон нийтийн эдийн засгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор сар тутамд уулзалт хийж хэвшээд байна.

“Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт 8 дугаар эрхлэн гаргаж, 6000 хувийг хэвлүүлэн, дугаар бүрийг МУЕТГ, УИХ, ЗГ, арилжааны банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын ЗДТГ, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа.

Монголбанкны 2019 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлын товчооныг бэлтгэж, Төв банкны бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг танилцуулав. Энэ онд Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ой тохиож байгаа бөгөөд тус тэмдэглэлт ойн хүрээнд “Банкны хөгжил -95 жил” аяныг зургаан сарын хугацаанд хэрэгжүүллээ. Аяны хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал, эдийн засгийн бодлогын чуулган, мөнгөн тэмдэгт-төлбөрийн хэрэгсэл-үнэт цаасны үзэсгэлэн, банкны ажилтны өдрийн нээлттэй өдөрлөг гэх мэт мэргэжлийнхэн болоод олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, түүхэн ном товхимлуудыг бэлтгэн хэвлүүллээ.

Оюутнуудад Монголбанкны бодлого, үйл ажиллагааг таниулж, мэдээлэл үржүүлэгч нарыг бэлтгэх ажлын хүрээнд “Сургагч оюутан багш”-ын сургалтыг 6 удаа зохион байгуулж, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх”, “Банкны салбарын 95 жилийн ой ба мөнгөн тэмдэгт”, “Эдийн засгийн судалгаа хийх арга зүй”, “Мөнгөний бодлого”, “Банкны хүү бодох аргачлал, ил тод байдал” сэдвээр мэдээлэл өгөн, давхардсан тоогоор 1000 орчим оюутныг хамрууллаа. Цаашлаад их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан “Монголбанкны цаг” арга хэмжээг мөн 15 их, дээд сургуулийн 900 орчим оюутныг оролцуулан зохион байгуулав.

Монголбанкнаас “Хууль эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа ба банкны салбарын хэд хэдэн хуулинд нэмэлт өөрчлөлт орсноор холбогдох журмуудад өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан билээ. Шинээр боловсруулж, УИХ-д өргөн барьж буй хуулийн төслүүд болон хуульд нийцүүлэн өөрчлөн боловсруулсан журмын төслийг олон нийтэд танилцуулах, мэдээлэл өгөх хэлэлцүүлгүүдийг тухай бүр хийв. Мөн Төв банкны бодлого, үйл ажиллагааг тайлбарлаж, орон нутгийн салбаруудтай хамтран орон нутгийн банкны ажилтнууд, төрийн албан хаагчид, ард иргэдэд мэдээлэл өгөх сургалт уулзалтыг Төв, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Архангай аймагт зохион байгуулав.

Тайлант оны эхнээс Монголбанкны бодлого болон үйл ажиллагааг тайлбарласан “Эдийн засаг энгийнээр” буланг ажиллуулж, нийтлэл бичин,

видео шторкуудыг хүргэдэг болоод байна. Тухайлбал “Монголбанкны онцлох үйл явдлын товчоон”, “Тэтгэврийн зээлийн дүнг хэрхэн тооцох вэ”, “Өр, орлогын харьцаа”, “Шинэ 5000 төгрөгийн дэвсгэртийн нууцлал”, “Ханш хэрхэн тогтдог вэ?”, “Банкны хөгжил 95 жил”, “Эх орны алтыг эрдэнэсийн санд” гэх мэт сэдвээр 12 видео шторк бэлтгэхээс гадна 19 нийтлэл, 16 инфографикийг бэлтгэн хүргэлээ. Төв банкны алт худалдан авалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг 6 сарын хугацаатай зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд олон нийтийн мэдээллийн сувгуудыг ашиглан (i) Төв банканд алт хэрхэн тушаах, (ii) Төв банканд тушаасан алт Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийг хэрхэн нэмэгдүүлдэг, (iii) алт тушаалт нь эдийн засагт хэрхэн эергээр нөлөөлдөг, ямар ач холбогдолтой талаар олон нийтэд нэгдсэн ойлголт өгөхөөр зорьж байна.

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

2.1. Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ;

УИХ-аас гаргасан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл” болон холбогдох бусад төрийн эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийн дагуу Монголбанкнаас “Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд уг хөтөлбөрийн хүрээнд Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиудын төслийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулав. Түүнчлэн банк, санхүүгийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, харилцагч хадгаламж эзэмшигчийн эрхийг хамгаалах чиглэлээр дараах хуулийн төслүүдийн саналыг боловсруулж ажиллалаа.

УИХ-ын нэр бүхий гишүүдэд уламжилсан саналын дагуу 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байгаа Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт Монголбанкны төлөөлөл ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл”-ийг бэлтгэхэд хамтран ажиллаж, банк, санхүүгийн зах зээлд оролцогчдын хооронд олон улсын стандарт, ерөнхий гэрээний дагуу эрсдэл бууруулах зорилгоор байгуулдаг санхүүгийн үүсмэл хэрэгсэл, буцаан худалдах, худалдан авах нөхцөлтэй санхүүжилтийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг сайжруулахтай

холбоотой саналыг хүргүүлээд байна. Үүнд (1) хуулийн төсөлд биржийн бус санхүүгийн үүсмэл хэрэгслийн болон буцаан худалдан авах нөхцөлтэй санхүүжилтийн гэрээг байгуулсан тохиолдолд шаардлага харилцан тооцох буюу хаалтын нэттинг хийх эрхийг хангах тухай үүрэг гүйцэтгүүлэгчийн эрхийг тусгайлан заасан, мөн энэ нь хуваарилагдах хөрөнгөд хамаарахгүй байх зохицуулалтыг тусган зохицуулах болон (2) гэрээний дагуу төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээс өмнө үүрэг дуусгавар болгож төлбөр тооцоо гүйцэтгэх талаар хуулийн төслийн гуравдугаар бүлэгт заасан “Хүчин төгөлдөр бус хэлцэл”-д хамаарахгүй байх хууль зүйн хамгаалалтыг тусгаж өгөв. Европын сэргээн босголт хөгжлийн банкттай хамтран Монгол Улс дахь санхүүгийн үүсмэл хэрэгсэл, санхүүжилтийн репо хэлцлийн хууль эрх зүй, зохицуулалтын хэрэгцээ шаардлагын талаар судалж, одоогийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох техник туслалцааны төслийг эхлүүлэхээр ажиллаж байна.

Активын удирдлагын тухай хуулийн төсөл

Банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, тус салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх зорилго бүхий Актив удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулж хууль санаачлагчид уламжлаад байна. Хуулийн төсөл нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулах, Актив удирдлагын компанийн шилжүүлэн авсан чанаргүй зээлтэй холбоотой нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийн онцгой ажиллагааг тогтоох зорилготой.

Хуулийн төслийг боловсруулахтай холбоотойгоор Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, үр нөлөө, зардлын тооцооны талаарх судалгааг хийж гүйцэтгэн төслийн үзэл баримтлалын төслийг боловсрууллаа. Мөн хуулийн төслийг цахим хуудсанд байршуулж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, мэргэжлийн байгууллага, судлаачдын төлөөллийн оролцоотойгоор хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан бөгөөд УИХ-ын гишүүн Б.Баттөмөр нарын гишүүд 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд хуулийн төслийг өргөн мэдүүлээд байна. Хуулийн төсөл нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулах бөгөөд бүтцийн хувьд нийт 9 бүлэг, 43 зүйлтэй юм.

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Өр, төлбөрийг шүүхийн журмаар албадан барагдуулах ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгох, чанаргүй активыг үр ашигтай шийдвэрлэх, барьцаа хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох ажлын хүрээнд хууль, эрх зүйн болон шүүхийн процесст шаардлагатай өөрчлөлт оруулж, сайжруулах зорилгоор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах судалгааг хийж гүйцэтгэх, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Монголбанк, Сангийн яам, Монголын банкны холбоо болон хуульч, өмгөөлөгчдийн төлөөллийг оролцуулсан Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-323, А-324 дүгээр тушаалаар байгуулав. Ажлын хэсгээс Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгааны үр дүнд үндэслэн хуулийн төслийг боловсруулж, саналыг Хууль зүйн дотоод хэргийн яаманд уламжлав.

Иргэний хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр хуульд өөрөөр заагаагүй бол нэг этгээд оролцсон нь дуудлага худалдаа, уралдаан явагдаагүй гэж үзэх үндэслэл болохгүй байх, барьцаагаар хангагдсан үүргийн гүйцэтгэлийн шаардлагыг татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагын дарааллын 2 дугаарт хангах, цахим хэлбэрээр гэрээ хийх бол талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлснийг харилцан хүлээн зөвшөөрснөөр гэрээ байгуулсанд тооцдог байх зэрэг зохицуулалтыг тусгав.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийн шат бий болгох зохицуулалтыг тусгаж байгаа бөгөөд улмаар янз бүрийн шалтгаанаар хурал хойшлуулдаг хүсэлтийг шүүх нэг дор хүлээн авч шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаанаас бусдаар хойшлуулахгүй байх оролцогчийн үүргийг нэмэх, хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийг удаа дараа солих тохиолдлыг хязгаарлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хугацаанд нь, хэвийн явуулахад удаа дараа, санаатай саад учруулсан зохигчоос шүүх хугацаа алдсаны нөхөн олговрыг

нөгөө талд гаргуулах зохицуулалтыг хуулийн төсөлд оруулахаар тусгаад байна.

Банк, эрх бүхийн хуулий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн төсөл

1995 онд батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтыг бусад хуулиудтай уялдуулах, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүний хөгжил, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх, эдгээр үйлчилгээний хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор хуулийн төслийг боловсруулаад байна. Санхүүгийн үйлчилгээний ерөнхий нөхцөл, журмын үндсэн зарчим, цахим хэлцэл, талуудын эрх үүрэг, гэрээнд тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тусгалаа.

Итгэлийн зээлийн хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 48 дугаар захирамжаар “Итгэлийн зээл олгох тухай хууль”-ийн төсөл боловсруулах ажлын хэсэг болон дэд ажлын хэсэг байгуулагдсан билээ. Монголбанк дэд ажлын хэсэгт орж ажиллан хуулийн төслийн эхний хувилбарт холбогдох судалгааг боловсруулав. Тус хуулийн төслөөр өрхийн аж ахуй болон бичил бизнес эрхлэгчдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий итгэлийн зээлийн бүтээгдэхүүнийг зорилтод бүлэгт олгох эрх зүйн үндэс болон тус зээлийг олгохтой холбоотой бусад үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахаар тусгав.

Векселийн тухай хуулийн төсөл

Векселийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх, хуулийн хэрэгжилтэд гарч буй хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор Векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 4 бүлэг, 18 зүйлтэй байхаар боловсруулан ажиллаж байгаа бөгөөд хуулийн төслийн зорилго нь нэг талаар иргэн, хуулийн этгээд, Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллагын хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхэд үүсэх харилцааг зохицуулах, нөгөө талаар одоогийн Векселийн тухай хуулийн зохицуулалтыг санхүүгийн зах зээлийн хөгжил, өөрчлөлттэй нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтын дутмаг байдлаас үүсч болзошгүй бодлогын болон санхүүгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр боловсронгуй болгох юм.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн төсөл

Эрдэнэсийн сангийн талаарх эрх зүйн зохицуулалтыг Соёлын өвийг хамгаалах тухай хуультай нийцүүлж боловсронгуй болгох, Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны талаарх түүх, соёлын өвтэй холбоотой төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагын бүрэн эрхийг нэг мөр болгох, Эрдэнэсийн санд шилжүүлэх түүх, соёлын өвд тавигдах шаардлагыг тодорхой

болгох, соёлын өвийг хамгаалахтай холбоотой Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанкны үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох судалгааны хамт эцэслэн боловсруулж, тус хуулийн төслийг хууль санаачлагчид уламжлав.

Төв банкны тухай хууль, Банкны тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан 2019 оны 1 дүгээр улиралд банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам, Дахин хөрөнгөжүүлсэн банкнаас гаргах хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийн журам, Банкны чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журмыг батлан, мөрдүүлж байна.

2.2. Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ;

Монгол Улсын Засгийн газар, ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хийсэн активын чанарын үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан системийн нөлөө бүхий банкуудыг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, эдгээр зарчмыг зохицуулсан хууль, эрх зүйн баримт бичгийг боловсруулахаар тохиролцоод байна.

Энэ хүрээнд Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан бөгөөд хуультай холбогдон гарсан “Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, банкныг шинэчлэх төлөвлөгөө боловсруулах журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А-258 дугаар тушаалаар, “Төрөөс дахин хөрөнгөжүүлэх банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, хянах, төсөвт буцаан төвлөрүүлэх журам”-ыг Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 280 дугаар тушаалаар, “Дахин хөрөнгөжүүлсэн банкнаас гаргах хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийн журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А-53/30 дугаар хамтарсан тушаалаар тус тус батлав.

Үүний зэрэгцээ Активын чанарын үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан банкуудад дутагдлаа хангах шаардлагыг шат дараалалтайгаар хүргүүлсний үр дүнд тайлант оны I улирлын эцсийн байдлаар нийт 10 банкнаас 535.4 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгийг

нэмэгдүүлээд байна. Цаашид нэр бүхий банкуудаас өөрийн хөрөнгийг хууль тогтоомж, олон улсын стандарттай нийцүүлэн нэмэгдүүлсэн эсэхийг тогтоох дараагийн шатны хараат бус үнэлгээ хийлгэх талаар ОУВС-аас ирүүлсэн санал, ажлын даалгаврыг боловсруулж бэлэн болгоод байна. Өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн нэр бүхий банкуудын шинээр оруулж ирсэн хөрөнгийн гарал, эх үүсвэр нь Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журамд нийцтэй эсэхэд магадлан баталгаажуулах шалгалтыг эхлүүлээд байна. Тус аудитын хүрээнд Монголбанк олон улсын нэр хүнд бүхий Duff and Phelps Singapore PTE Ltd аудитын компаниас зөвлөх үйлчилгээг авч байна. Магадлан баталгаажуулах шалгалтын үр дүн урьдчилсан байдлаар 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр гарах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

2.3. Олон улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ;

Банкны зохистой харьцааны журмыг олон улсад мөрдөж буй хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслээр баяжуулан, ОУВС болон банкуудаас санал авч тусган, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны А-138 дугаар тушаалаар шинэчлэн найруулж, ХЗДХЯ-д бүртгүүлэн, мөрдүүлж эхэллээ. Энэхүү журамд Базел III хүрээний нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн тодорхойлолт, хөшүүргийн харьцаа, банкны эрсдэл даах чадварыг хамгаалах нөөц интервал (capital conservation buffer), эрсдэлийн жингийн оновчтой зохицуулалт зэргийг оруулснаараа давуу талтай юм.

Үүний зэрэгцээ олон улсад мөрдөж буй СТОУС 9-ийг банкуудад нэвтрүүлэх ажлын хүрээнд холбогдох бэлтгэл ажил хийгдэж байгаа боловч ОУВС-аас СТОУС 9-ийг Монголын банкны салбарт нэвтрүүлэхийг дэмжээгүйгээс шалтгаалан Дэлхийн банкны төслийн хүрээнд санхүүжилт олгох асуудал хойшлогдоод байна. Гэсэн хэдий ч СТОУС 9-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэх үүднээс Дэлхийн банкнаас техник туслалцаа, зөвлөх авч Нягтлан бодох бүртгэлийн багц материалд оруулах шаардлагатай зарим нэмэлт өөрчлөлтүүдийг тодорхойлоод байна.

Төв банк болон Банкны тухай хуулийн хүрээнд Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлалд шилжүүлэх боломж бүрдэж байгаа бөгөөд албадлагын арга хэмжээний үе шат, Монголбанкнаас эрсдэлтэй банканд авч хэрэгжүүлэх шалгалтын арга хэрэгслийг уян хатан байдлаар тогтоов. Ялангуяа, Монголбанкнаас эрсдэлтэй гэж дүгнэвэл банкуудад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, учирч болзошгүй алдагдлын хэмжээг бууруулах боломжтой болов. Түүнчлэн, төлбөрийн чадвар муудсан банканд авах албадлагын арга хэмжээг санхүүгийн салбарт үүсэх алдагдлыг хамгийн

бага түвшинд байлгахуйц байдлаар шийдвэрлэх арга хэрэгслийг ашиглах сонголтыг Монголбанканд олгож байгаагаараа онцлог юм. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд Базел стандартын Тулгуур (Pillar) 2-ийг банкны хяналт шалгалтад нэвтрүүлэх хүрээнд олон улсын туршлага судалж, өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцох дотоод аргачлалын журам, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалын удирдамжийн төслийг урьдчилсан байдлаар боловсруулаад байна.

2.4. Банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тогтолцоог сайжруулна;

2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нэмэгдсэн “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” чиг үүргийн дагуу Монголбанкнаас хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн бусад байгууллагатай хамтран “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийн саналыг боловсруулан хууль санаачлагчид уламжиллаа. Тус хууль батлагдсанаар Монголбанкнаас банкны салбар дахь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг санхүүгийн үйлчилгээ авч байгаа микро түвшинд хамгаалах нөгөө талаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийг үүрэгжүүлэх, санхүүгийн хэрэглэгчид санхүүгийн мэдлэг, боловсролыг олгох, энэ чиглэлээр үйл ажиллагааг зохицуулсан журам, зааврыг боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.1. Үндэсний төлбөрийн системийн найдвартай ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох ажлыг үргэлжлүүлнэ;

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд карт, хөдөлгөөнт банкны журмын төсөл зэрэг төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээтэй холбогдох журам, бусад эрх зүйн хэм хэмжээний актыг батлан мөрдүүлж байна.

Төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор хөдөлгөөнт банкны журам, бага дүнтэй төлбөрийн систем, цахим мөнгөний журмыг шинэчлэн баталснаас гадна төлбөрийн системд тавих хяналтыг сайжруулах, хяналтын заавар, журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Дэлхийн банкны техник туслалцааг авч, тус байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна.

Түүнчлэн, “Банксүлжээ” систем, ҮЦГТ, ХХБ-ны картын свичийн үйл ажиллагааны тайланд хяналт тавьж байна. Энэ ажлын хүрээнд “Банксүлжээ” системийн оролцогч банкуудын тайланг сар бүрээр нэгтгэн шаардлага хангаагүй банкуудад тухай бүр холбогдох арга хэмжээг авч байна.

Олон улсад нийтлэг мөрдөж байгаа Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ын хэрэгжилт нь “Банксүлжээ” системд хэрхэн хангагдаж байгааг үнэлж, хэрэгжилтийн түвшинг ахиулахад шаардлагатай холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусгасан үнэлгээний тайланг 2019 оны 4 дүгээр улиралд нэгтгэн гаргах ажлыг эхлүүлээд байна.

3.2. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ;

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, БСШУЯ (хуучин нэрээр) хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлэв.

Тайлант хугацаант тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийв.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Банк Санхүүгийн Академитай хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд асрамжийн газрын 15-18 насны хүүхдүүдэд хувийн санхүүгээ удирдах, санхүүгийн суурь боловсрол олгоход зориулсан аян санаачлан эхлүүлсэн. 5 удаагийн ОНСБ-ын сургалт, 5 банканд аялсны эцэст нэгдсэн арга хэмжээ, хэлэлцүүлгийг Монголбанк болон Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран хийж, өнчин хүүхдүүдэд хуримтлал хадгаламж үүсгэх, орлого зардлаа бүртгэж хөтлөх, мөнгийг менежменттэй зарцуулах тухай ойлголтыг өгч эдийн засгийн зөв хүмүүжилтэй болгоход чиглэгдсэн, санхүүгийн боловсролын эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор нийтдээ 100 хүүхдийг Монголбанкны Эрдэнэсийн санг үзүүлэн сургалт зохион байгуулав.
- ХААН банк Монголбанктай хамтран санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд “UnreadGrowthProgram”-ын оролцогчдын дунд

“ЕБС-ийн төгсөх ангийн хүүхдүүдэд санхүүгийн цогц мэдлэг олгох уралдаан” зарлаж, шилдэг багуудыг шалгарууллаа. Уралдаанд оролцсон 8 баг гурван 7 хоногийн хугацаанд 1,600 гаруй хүүхдэд санхүүгийн боловсролын тухай мэдлэг ойлголт өгч, мэргэжил сонголтгоо хэрхэн хийх, ХААН банкны “Rise” шинэ оюутны хөгжлийн хөтөлбөрийн тухай мэдээлэл хүргэсэн байна.

Залууст санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Монголбанкнаас Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр болон “Банкны хөгжил – 95 жил” аяны хүрээнд “Хувь хүний санхүү” хичээлийг сонгон судалж буй 1-р курсийн оюутнуудын дунд “Хэн сайн санхүүч болох вэ?” сэдэвт АХА тэмцээнийг зохион байгууллаа. Уламжлал болон дөрөв дэх жилдээ зохион байгуулагдаж энэ удаагийн тэмцээнд Монгол Улсын их сургууль, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, Эдийн засгийн үндэсний дээд сургуулийн 70 гаруй оюутан оролцож, оюун ухаан, мэдлэг чадвараа сорилоо. Энэхүү тэмцээн нь санхүүгийн онолын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Тэмцээний эхний гурван байранд МУИС-ийн оюутан Б.Пүрэв, ХҮИС-ийн оюутан М.Баасандолгор, МУИС-ийн оюутан Ж.Отгонбаатар нар шалгарч, Улаанбаатар Эрдэм их сургуулийн оюутан Д.Барсбаатар, МУИС-ийн оюутан Б.Оюунбилэг тусгай байрыг эзэллээ.
- Шпаркассе банкны сантай хамтран Дархан-Уул аймагт 12 арилжааны банкны нийт 25 оролцогчтой 2 группт “Эдийн засгийн нөхцөл байдал”, “Хадгаламж”, “Харилцагчийн зөвлөх” модуль сургалтыг амжилттай зохион байгуулав. Мөн төслийн хүрээнд банкны дунд болон дээд шатны удирдлагуудад “Харилцаанд суурилсан удирдлагын арга барил” сэдвээр 6 сарын 22-ны өдөр лекц, уулзалт зохион байгуулав
- “Банкны Хөгжил-95 жил” аяны хүрээнд “БАНКНЫ ӨДӨРЛӨГ”-ийг Сүхбаатарын талбайд 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 12:00-16:00 цагийн хооронд Монголбанк, Монголын банкны холбоо, арилжааны 13 банк, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгт банкны салбар бүтээгдэхүүн танилцуулах, санхүүгийн мэдлэг олгох чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан болно.
- ЦЕГ-ын 100 албан хаагчдад санхүүгийн мэдлэг олгох сургалтыг 6 сарын 27-ны өдөр зохион байгуулав. НТБҮТ-ийн 25 мэргэжилтэнд 6 сарын 5-ны өдөр зохион байгуулав.

Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Дорноговь, Говь-Сүмбэр, Өвөрхангай, Архангай аймгийн НТБ-ын багш нар “Санхүүгийн сургагч багш”-аар бэлтгэгдлээ. БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран орон нутгийн санхүүгийн сургагч багш бэлтгэх сургалтаа 17 дахь аймагтаа зохион байгуулж, одоогийн байдлаар нийтдээ 519 сургагч багш бэлтгээд байна. Мөн 2019 оны эхний хагас жилд үндэсний хэмжээнд 628 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 21404 хүүхэд болон насанд хүрэгчдэд санхүүгийн боловсрол түгээгээд байна.
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 7500 ширхэг гарын авлагыг “Мөнгөө хэрхэн удирдах вэ?”, “Зээл”, “Өрхийн төсөв”, “Хуримтлал ба хадгаламж”, “Үнийн түвшин”, “Валютын ханш”-ийг орон нутгийн сургалтын үеэр түгээж ажиллав.
- Дэлхийн банкнаас орон нутгийн төрийн албан хаагчид болон малчдад зориулсан 4 модуль бүхий багшийн ном, аудио хичээл болон суралцагсдын гарын авлагын төслийг боловсруулав.

Цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuuginbolovsrol.mn цахим хуудсыг тогтмол баяжуулан ажиллалаа.
- “Монголбанкны мэдээлэл”, “Монголын эмэгтэйчүүд” сар бүрийн товхимол, ЦЕГ-ын “Амрыг эрье” улирал тутмын товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллуулж байна.
- “Санхүүгийн боловсрол” фейсбүүк пэйжийг тогтмол мэдээ, мэдээллээр ханган ажиллалаа.
- МҮОНР-гийн “Санхүүгийн мод” нэвтрүүлгээр нийт 26 дугаарыг шууд эфирээр болон фейсбүүкээр олон нийтэд түгээв.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хуралдаанаар олон нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх иргэдийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам нэгтгэн боловсруулж, олон нийтэд хүргэхээр шийдвэрлэсэн байдаг. СТБЗ-ийн Ажлын алба нь 2019 оны 6-7 сард тус тайлангийн 13 дахь дугаарыг Сангийн яам, СЗХ, ХДК, Монголбанкны холбогдох газар, албадаас ирүүлсэн материалд үндэслэн нэгтгэн боловсруулж, хэвлэж, олон нийтийн хүртээл болгоод байна.

3.3. Олон улсад мөрдөж байгаа тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ;

БНХАУ-ын Цинхуа их сургуулийн багшнарыгурин, ногоон таксономи буюу ногоон санхүүжилтийг шалгуур үзүүлэлтийг боловсруулах хэлэлцүүлгийг ТОС-ын холбоотой хамтран зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Байгаль орчин, аялал жуучлалын яам, Эрчим хүчний яам, арилжааны банкуудын төлөөлөл оролцсон бөгөөд Монголбанкнаас Дэд Ерөнхийлөгч болон холбогдох ажилтнууд оролцлоо. Уг хэлэлцүүлгээр уур амьсгалын ногоон сан /Green Climate Fund/-гаас гаргасан 8 зарчим, Европын төв банкнаас боловсруулсан 6 зарчим болон Европын сэргээн босголтын хөгжлийн банкнаас гаргасан зөвлөмжүүдийг хэлэлцэв. БНХАУ-ын Цинхуа их сургуулийн Ногоон санхүүжилтийн хорооноос гаргасан зөвлөмжүүдэд тулгуурлаж, ногоон зээл, хөрөнгө оруулах төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхийн тулд ногоон таксономи буюу хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, ногоон зээлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон төсөлд Монголбанкнаас санал хүргүүлж ажиллав. Ногоон таксономийн стандартыг боловсруулж, 2020 он гэхэд батлуулахаар ажиллаж байна.

Мөн арилжааны банкуудад газар дээрх иж бүрэн хяналт, шалгалт хийх удирдамжинд банкны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг шалгах заалтыг оруулж, банкуудад шалгалт хийх явцад хэрэгжилтийг шалгаж, зөвлөмж өгч ажиллаж байна. Үүнд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн талаарх бодлого, журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт, Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн зарчмуудын хэрэгжилт, зээлээр санхүүжих төсөлд хийсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ, уг эрсдэлийг удирдах, бууруулах, үйл ажиллагаа, ногоон зээлийн үйл ажиллагаа, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага хариуцсан бүтэц зохион байгуулалт, болон тогтвортой санхүүжилтийн талаарх дотоод сургалт, мэдээллийг хэрхэн зохион байгуулж буй талаар үнэлж, зөвлөмж өгч ажиллаж байна. Үүний зэрэгцээ ТОС холбооны ажилтнуудтай ногоон зээлийн шалгуур үзүүлэлт, ангиллын талаар санал солилцож, хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулж байна.

Мөн ТОС холбоо болон арилжааны банкуудтай хамтарч, мэргэжлийн зөвлөлийн уулзалтыг сар бүр зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Монголбанкнаас ногоон оффис ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Тогтвортой санхүүжилт, ногоон зээлийн мэдээллийг арилжааны банкуудад бий болгохын тулд улсын хэмжээний нэгдсэн тодорхойлолтыг бий болгох шаардлагатай байна. Улмаар, Тогтвортой санхүүжилтийн холбоо, БНХАУ-ын Цинхуа их сургууль, арилжааны банкуудтай хамтран “ногоон зээлийн ангилал” хэмээх тодорхойлолтыг боловсруулж байна. Энэ ажлын хүрээнд

Тогтвортой санхүүжилтийн ажлын хэсгийн хуралд ТОС холбоо, арилжааны банкны ажилтнуудтай хамт сар тутам хурал хийж, хамтран ажиллаж байна.

3.4. Банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, шинэ ололтыг нэвтрүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно;

Тоон гарын үсгийн системийн үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгжид хүргэхэд хамтран ажиллах “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” эзэмшигч компанийг сонгон шалгаруулж, Монголбанкны зүгээс тавих техник болон бизнесийн ерөнхий шалгуурыг тусгасан хамтран ажиллах саналыг боловсруулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд руу хүргүүлээд байна.

Санхүүгийн байгууллагад хэрэглэгдэх тоон гарын үсгийн систем (PKI систем) нь цахим орчинд дамжигдаж буй баримт бичгийн бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг баталгаажуулдаг, хуулиар баталгаажсан дижитал технологи юм. Тус системийн тоног төхөөрөмжүүдийн суурилуулалт, тэдгээрийн программ хангамжуудын тохиргоог хийж дууссан бөгөөд Монголбанкны дотоод системүүд, төлбөр тооцооны бүх систем, зээлийн мэдээллийн сан, Төв банкны үнэт цаас болон валютын арилжааг гүйцэтгэх банк хоорондын цахим арилжааны системүүдэд нэвтрүүлэх ажлыг эхлүүлээ. Түүнчлэн, PKI системийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс Монголбанкнаас тухайн системийн гэрчилгээг банк, санхүүгийн байгууллагуудад олгож, тоон гарын үсгийн хэрэглээг дэмжихэд анхаарал тавин ажиллаж байна.

Төлбөрийн системд банкнаас бусад хуулийн этгээд оролцох боломжийг нээх зорилгоор төлбөрийн картын журам, хөдөлгөөнт банкны журам, бага дүнтэй төлбөрийн системийн журам, цахим мөнгөний журмыг боловсронгуй болгон шинэчлэх ажлыг тус тус хийж гүйцэтгээд байна. Ингэснээр банк бус санхүүгийн байгууллага төлбөрийн карт гаргах боломжтой болсноос гадна төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарт техник, хүний нөөц, технологийн дэмжлэг үзүүлэн ажилладаг санхүүгийн бус байгууллагуудыг Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байхаар зохицуулж өгөв.

Мөн үндэсний төлбөрийн ₮ картыг нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан орчин үеийн технологид нийцүүлэн шинэчлэх ажлын хүрээнд VISA олон улсын картын байгууллагатай хамтарсан сургалт, уулзалтыг удаа дараа зохион байгуулж, хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулаад байна. Түүнчлэн, Үндэсний брэнд ₮ картын холограмын хэвлэлтийг Монголбанк өөрийн хяналтад авч, эрхийг эзэмших ажлын хүрээнд холограм, ₮ картын лого болон Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-ийн логоны загварыг шинэчлэн баталж, барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийн гэрчилгээ авахаар ажиллаж байна.

Банк хоорондын валют арилжааны цахим талбарыг сайжруулах, хөгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд валют арилжааны цахим талбарт банкуудаас ирсэн саналын дагуу өөрчлөлт оруулж валютын дуудлага худалдааны программыг шинэ технологид шилжүүлэн арилжааны банкуудтай хамтарч тест хийж байгаа ба уг талбарт үүсмэл хэрэгслийн арилжааг нэмэх ажлыг эхлүүлээд байна.

Монголбанк нь төлбөрийн системийн дэд бүтцийг сайжруулах, төлбөр тооцооны найдвартай ажиллагааг хангахад өөрийн систем, сүлжээний дэд бүтцийг бэхжүүлэн, техникийн шинэчлэлийг тогтмол хийж байна. Энэ ажлын хүрээнд ҮЦГТ-ийн үндсэн төвийг олон улсын дата төвийн стандартад нийцсэн зай талбай, өрөөний зохион байгуулалттай, орчин үеийн хөргөлт, сүлжээний сувагчлал, цахилгааны найдвартай эх үүсвэр, галын дохиоллын систем, аюулгүй байдлын тоног төхөөрөмж бүхий Дата төв болгон шинэчлэхээр ажиллаж байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын стандартыг хэрэгжүүлэх хүрээнд ҮЦГТ-ийн ажиллуулж буй одоогийн бага дүнтэй гүйлгээний системийг шинэчилж, олон улсын стандартын Автомат Клиринг Хаус буюу АСН+ систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. АСН+ систем нь банк хоорондын бодит цагийн энгийн гүйлгээнээс гадна багцын болон шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэлээр хийх гүйлгээ зэргийг дамжуулах чадавхтайгаараа онцлог юм. Тус системийг нэвтрүүлснээр Монгол улсын бүх банкууд IBAN олон улсын стандартыг хэрэгжүүлэх, корпораци буюу томоохон аж, ахуйн нэгж байгууллагуудад зориулсан гарцыг бий болгосноор төлбөр тооцоогоо шуурхай гүйцэтгэх, хөрөнгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлснээр үр дүнгийн тооцоолол хийхэд гардаг үлдэгдэл хүрэлцэхгүй байх эрсдэл үгүй болох зэрэг давуу талуудтай юм. Системийн нийлүүлэгч АНУ-ын Монтран компанитай байгуулсан гэрээний хүрээнд АСН+ системийг 2019 оны 8 дугаар сард бүрэн нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ба Монголбанкны зүгээс системийг нэвтрүүлэх хугацааг наашлуулахаар ажиллаж байна. Одоогийн байдлаар системийн бүх оролцогчидтой туршилтын ажил хийгдэж байна.

Монголбанк нь төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, төрийн үйлчилгээний зардал чирэгдлийг бууруулах, хүртээмжийг сайжруулахад анхааран ажиллаж байна. Уг ажлын хүрээнд хууль, эрх зүйн орчны зохицуулалтыг бий болгож, өөрийн системд программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээний төлбөр тооцоог дамжуулах дэд бүтцийг бий болгосон. Одоогийн байдлаар Нийслэлийн засаг даргын тамгын газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагын гүйлгээг ҮЦГТ-ийн системээр дамжуулан гүйцэтгэж байна.

ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА

1. ИНФЛЯЦИ

Эдийн засгийн идэвхжлийг дагаад үнийн өсөлт 2017 оны 2 дахь хагасаас эхлэн нэмэгдэж, сүүлийн 2 жил гаруй хугацаанд Төв банкны зорилтот түвшний орчимд хэлбэлзэж байв. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляци 2019 оны 7 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 7.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 9.0 хувь байна (Зураг 7). Өрхийн бодит орлого, банкны зээл өсч эрэлтийн гаралтай инфляци нэмэгдсэн ч тогтвортой түвшинд байгаа бол нийлүүлэлтийн инфляци үнийн савлагаа үүсгэж байна.

Инфляцид 2019 оны 7 дугаар сарын байдлаар дараах хүчин зүйлс голлох нөлөөг үзүүллээ. Үүнд:

Дотоодын захад нийлүүлэлт саатснаас махны үнэ 5 дугаар сард огцом өсөв. Махны үнэ 6 дугаар сарын дундаас эхлэн хямдардаг улирлын онцлогоосоо зөрж, 7 дугаар сарын байдлаар жилийн инфляцийн 31 хувийг дангаар бүрдүүлж байна (Зураг 8).

Импортын барааны үнийн инфляцид үзүүлэх нөлөө өнгөрсөн оны сүүл үетэй харьцуулахад 1.2 нэгж хувиар өсч жилийн инфляцийн 2.2 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд, эдийн засгийн идэвхжил дагасан импортын барааны эрэлт нэмэгдэх, импортын үнэ, ханшийн өөрчлөлтийн дамжих нөлөө зэрэг нөлөөлөв.

Хатуу түлшний үнэ 2018 онд эрчимтэй өсч 65 хувиар нэмэгдэн инфляцийг өдөөж байсан бол энэ оны 2 дугаар улирлаас түүхий нүүрсийг сайжруулсан түлшээр орлуулж, үнэ болон нийлүүлэлтийг зохицуулах арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлэх төлөвтэй байна. Хэдийгээр хатуу түлшний үнэ 2 дугаар улиралд тогтвортой байсан ч өнгөрсөн хугацааны өндөр өсөлтийн нөлөөгөөр жилийн инфляцид 0.9 нэгж хувийг бүрдүүлсээр байна.

Дээрх бараа бүтээгдэхүүнүүд (мах, шатахуун, хатуу түлш) хэрэглээний сагсны 19% хувийг бүрдүүлдэг хэдий ч нийт инфляцийн хэлбэлзлийн 40 гаруй хувийг тайлбарлаж байгаа нь зах зээлийн нийлүүлэлт, хангамж түүний дэд бүтцийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Аялал жуулчлалын идэвхтэй улирал эхэлсэнтэй холбоотой дотоодын аялал, жуулчлалын үнэ 6 дугаар сард 57 хувиар огцом өсч, жилийн инфляцийн 0.6 нэгж хувийг бүрдүүлэв. Гэхдээ энэ нэг удаагийн нөлөө 7 дугаар сараас саарч эхлээд байна.

Зураг 7. Улсын болон Улаанбаатар хотын инфляци



Зураг 8. Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа



Эх сурвалж: YCX

Хүснэгт 3. Жилийн инфляцид голлон нөлөө үзүүлсэн бараа, бүтээгдэхүүнүүд 7 дугаар сарын байдлаар


Нэр төрөл	Жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцид эзлэх хувь
Мах	0.10	29.7%	2.8%
Бүх төрлийн хувцас	0.09	15.6%	1.2%
Хатуу түлш	0.03	21.3%	0.9%
Дотоодын аялал жуулчлал	0.007	69.3%	0.6%

II. БОДИТ СЕКТОР


2.1. Нийт нийлүүлэлт

Эдийн засаг 2019 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өслөө. Зах зээлд оролцогчдын итгэл нэмэгдсэн, бизнесийн зээл, хөрөнгө оруулалт өссөн, уул уурхайн салбарын томоохон бүтээн байгуулалт үргэлжилсэн, экспортын бүтээгдхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсан зэргээс шалтгаалж эдийн засгийн бүх салбарт үйлдвэрлэл эрчимжлээ.

Зураг 9. ДНБ-ий жилийн өсөлт





Зураг 10. ДНБ-ий жилийн өсөлтийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: ҮСХ

Уул уурхайн салбар 13 хувиар өсч, нийт өсөлтийн 2.6 нэгж хувийг бүрдүүлсэн. Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэн нь үүний гол шалтгаан байв. Харин алтны олборлолт 20.4 хувиар буурчээ. Үйлчилгээний салбар 1.5 нэгж хувь, худалдаа 1.2 нэгж хувь, хөдөө аж ахуй 0.7 нэгж хувь, мэдээлэл холбоо 0.3 нэгж хувь, эрчим хүч 0.1 нэгж хувь, барилга 0.1 нэгж хувийн эерэг нөлөөг өсөлтөд үзүүлсэн бол боловсруулах болон тээврийн салбарын үйлдвэрлэл өсөлтөд төдийлөн нөлөөлөөгүй байна. Салбаруудын өсөлт нэмэгдэж, татварын суурь тэлж, эдийн засгийн идэвхжлийг дагаад гадаад худалдаа тэлснээр бүтээгдэхүүний цэвэр татвар 5.2 хувиар өсчээ.

Зураг 11. Аж үйлдвэрийн салбаруудын өсөлт **Зураг 12. Үйлчилгээний салбаруудын өсөлт**



Эх сурвалж: ҮСХ

ШИГТГЭЭ 2. ЭДИЙН ЗАСГИЙН СЕКТОР ХООРОНДЫН ХӨРӨНГИЙН УРСГАЛЫН ШИНЖИЛГЭЭ

ОУВС-гаас боловсруулсан хөрөнгийн урсгалын матриц шинжилгээг ашиглан эдийн засгийн үндсэн 4 сектор буюу Засгийн газар, хувийн сектор, гадаад сектор болон санхүүгийн салбар хооронд нэг жилийн хугацаанд шилжиж буй хөрөнгийн урсгалыг макро эдийн засгийн үндсэн тэнцэтгэлүүдтэй нийцтэй байдлаар тайлагнаж болдог. Матриц шинжилгээний үр дүнд эдийн засгийн сектор бүрт үүссэн хөрөнгийн илүүдэл болон хомсдлыг тодорхойлж, хомсдолтой салбарууд нь алдагдлаа хөрөнгийн илүүдэлтэй бусад салбарын хөрөнгөөр хэрхэн санхүүжүүлж байгааг тайлбарлах боломжтой. Дараах хэсэгт энэхүү аргачлалыг ашиглан Монгол Улсын сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээг 2018 оны байдлаар гүйцэтгэв.

А. Санхүүгийн бус тэнцлийг тооцохдоо эдийн засгийн үндсэн адилтгал буюу хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүүгээр⁵ тодорхойлдог. Тэгшитгэлийн гол агуулга нь дотоод эдийн засгийн секторуудын хуримтлал нийт хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй нөхцөлд гадаад секторын хөрөнгөөр зөрүү хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх бөгөөд урсгал тэнцлийн алдагдал тус дүнгээр нэмэгдэхийг харуулна.

Эдийн засгийн харьяатууд 2018 онд нийт 28.3 их наяд төгрөгийн цэвэр орлоготой ажилласнаас 23.1 их наяд төгрөгийг хувийн сектор, 5.2 их наяд төгрөгийг Засгийн газар татварын цэвэр орлого⁶ хэлбэрээр бүрдүүлжээ. Төсвийн зардал батлагдсан дүнгээс дутуу гүйцэтгэлтэй гарсны зэрэгцээ төсвийн орлого нэмэгдэж төсвийн тэнцэл 11.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. Харин хувийн сектор 16.4 их наяд төгрөгийг хэрэглээнд, 12.5 их наяд төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулснаар 5.8 их наяд төгрөгийн алдагдалтай байв. Түүнчлэн Төв банк 2.0 орчим их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын эх үүсвэрийг алтны арилжаатай холбоотойгоор гадаад сектороос татсанаас 356 тэрбум төгрөгийн алтыг экспортын орлогоос, 1.6 их наяд төгрөгийн алтыг мөнгөжсөн алтнаас бүрдүүлжээ⁷. Ийнхүү дотоод эдийн засаг дахь санхүүгийн бус салбаруудын хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүү 2018 онд цэвэр дүнгээр -4.2 их наяд төгрөгт хүрч, тус хэмжээний хөрөнгийг гадаад сектороос санхүүжүүлсэн байна. Үүний дийлэнхийг импортын төлбөр болон үйлчилгээнд зарцуулжээ.

⁵ $[GNDI=C+I+(X-M)+Y_f+Y_r] \Rightarrow [GNDI-C-I=CAB] \Rightarrow [S-I=CAB] \Rightarrow [(S_g-I_g)+(S_p-I_p)=CAB]$.

Энд Y – Үндэсний цэвэр орлого, X – Нийт экспорт, M – Нийт импорт, Y_f – Төлбөрийн тэнцлийн анхдагч орлого, Y_r – Төлбөрийн тэнцлийн хоёрдогч орлого, $GNDI$ – Үндэсний нийт цэвэр орлого, C – Эцсийн хэрэглээ, I – Нийт хөрөнгө оруулалт, CAB – Урсгал тэнцэл, S – Дотоодын нийт хуримтлал, S_g – Засгийн газрын хуримтлал, I_g – Засгийн газрын хөрөнгө оруулалт, S_p – Хувийн секторын хуримтлал, I_p – Хувийн секторын хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

⁶ Төсвийн цэвэр орлого нь нийт тэнцвэржүүлсэн орлогоос зээлийн үйлчилгээний төлбөр, татаас болон бусад урсгал шилжүүлгийг хасч тооцдог.

⁷ Төв банк дотоодоос худалдаж авсан алтыг цэвэржүүлж, гадаадын харьяатад экспортлох эсвэл мөнгөжсөн алт хэлбэрээр гадаадын банканд байршуулдаг. Төв банк гадаадын банканд мөнгөжсөн алт хэлбэрээр хөрөнгөө нэмэгдүүлж, гадаад валютын эх үүсвэр татаж байгаа тул хөрөнгийн урсгалын шинжилгээнд нийт экспортод мөнгөжсөн алтны дүнг нэмж тооцоолов.

Хүснэгт 4. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээний матриц, тэрбум төгрөгөөр

Гүйцэтгэл/Салбарууд	Дотоод эдийн засаг	Дотоод эдийн засгийн салбарууд						Гадаад сектор	ХӨНДӨН ШАЛГАЛТ	
		Засгийн газар	Хөгжлийн банк	Хувийн сектор	Санхүүгийн сектор	Үүнгээс				
						Төв банк	АБанк			БСБ (МНК+ Бусад)
ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО	28,286	5,203		23,083					0.0	
Эцсийн хэрэглээ	20,185	-3,782		-16,402					0.0	
Нийт хөрөнгө оруулалт	13,922	-1,409		-12,513					0.0	
Экспорт	21,828				1,604	1,604		-21,828	0.0	
Импорт	-23,660							23,660	0.0	
Хуучин зүйлсийн орлого	-3,237							3,237	0.0	
Шилжүүлэг (тэвэр)	853							-853	0.0	
А. САНХҮҮГИЙН БУС ТЭНЦЭЛ	-4,216	12		-5,832	1,604	1,604		4,216	0.0	
Г. ГАДААД САНХҮҮЖИЛТ	6,030	203	-494	5,287	47	273	-154	-73	-6,030	0.0
Хөрөнгө оруулалт	6,072	-1,082	1,319	5,897	-62		48	-110	-6,072	0.0
ГШХО	5,635			5,635					-5,635	0.0
Санхүүгийн ХО	194	-1,082	1,319	20	-62		48	-110	-194	0.0
Хөрөнгийн данс	242			242					-242	0.0
Гадаад тэвэр тээл	-12	1,285	-686	-695	84	273	-227	37	12	0.0
Бэлэн валют, харилцах	-29		-139	85	25	0	25		29	0.0
Г. ДОТООД САНХҮҮЖИЛТ	0.0	-237	-502	533	206	45	-70	231	0.0	
Дотоод тээл		-878	57	4,166	-3,345	-941	-2,150	-254	0.0	
Засгийн газрын тэвэр тээл		-878		200	678	-932	1,611	0	0.0	
Хөгжлийн банкны тэвэр тээл			210		-210	-20	-190		0.0	
Хувийн секторын тээл			-152	3,966	-3814	11	-3,571	-254	0.0	
Нийт мөнгө				-4,086	4,086	59	4,027	0	0.0	
Санхүүгийн байгууллага хоорондын хөрөнгийн урсгал			-559		559	2,738	-2,434	254	0.0	
Бусад тэвэр зүйлс		641		453	-1,094	-1,811	486	231	0.0	
Д. ПАССИВЫН ӨӨРЧЛӨЛТ (-)	1,482				1,482	1,607	-124	0	-1,482	0.0
Гадаад өснө (+)	2,444				2,444	2,062	382	0	-2,444	0.0
Гадаад пассив (ОУВС-гийн тээл өрсөн) (-)	962				962	456	506		-962	0.0
Б. САНХҮҮГИЙН ТЭНЦЭЛ	4,548	-34	-8	5,820	-1,230	-1,289	-99	158	-4,548	0.0
В. АЦДАА БА ҮЭЛТРҮҮЛГЭ БОСОО ШАЛГАЛТ	-352	22	8	12	-374	-315	99	-158	352	0.0
	-20	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	20	0.0

1. Гадаад санхүүжилт нь дотоод эдийн засаг дахь санхүүжилтийн дутагдлын гол эх үүсвэр юм. Дотоод эдийн засгийн салбарууд гадаад сектороос нийт 6.0 орчим их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгийн урсгалыг хүлээн авснаас дийлэнхийг буюу 5.3 орчим их наяд төгрөгийг хувийн сектор бүрдүүлэв. Засгийн газар болон Хөгжлийн банк цэвэр дүнгээр харгалзан 203 тэрбум, 494 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гадаад зах зээлээс татсан. Харин санхүүгийн сектор 47 тэрбум төгрөгийн хөрөнгийг гадаад сектороос бүрдүүлжээ. Нийт гадаад санхүүжилтийн дүн дотоодын санхүүгийн бус тэнцлээс өндөр байгаа нь төлбөрийн тэнцлийн алдаа, орхигдуулга болон валютын ханшийн зөрүүтэй холбоотой.

Хувийн сектор гадаад санхүүжилтээр нийт 5.3 орчим их наяд төгрөгийн эх үүсвэрийг татсаны дийлэнх нь ГШХО хэлбэртэй байна. Үүнийг голчлон Оюу толгой

төслийн далд уурхайн бүтээн байгуулалтай холбоотой хөрөнгө оруулалт болон бусад уул уурхайн компаниудын шууд хөрөнгө оруулалт бүрдүүлэв. Түүнчлэн хувийн сектор гадаад зээлийн төлбөрт цэвэр дүнгээр 695 тэрбум төгрөгийг зарцуулсан. Ийнхүү хувийн сектор дотоодын хуримтлалаас давсан хөрөнгө оруулалтын эрэлтийг ГШХО-ын санхүүжилтээр санхүүжүүлжээ.

Засгийн газар ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд доноруудаас болон гадаадын бусад байгууллагаас нийт 1.3 их наяд төгрөгийн хөрөнгийг хүлээн авчээ. Энэхүү хөрөнгийн эх үүсвэрийг төслийн санхүүжилт, дотоод бондын үндсэн төлбөрт болон “Чингис” бонд, “Дим Сам” бондын 1.1 их наяд төгрөгийн үндсэн төлбөрт зарцуулав. Харин **Хөгжлийн банк** олон улсын зах зээлээс татсан 1.3 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад бондын хөрөнгөөс 686 тэрбум төгрөгийг гадаад зээлийн үндсэн төлбөрт шилжүүлж, 139 тэрбум төгрөгийг ностро дансанд байршуулсан.

Санхүүгийн сектороос гадаад зах зээлд цэвэр дүнгээр нийт 47 тэрбум төгрөгийг хүлээн авсан бөгөөд гадагшлах урсгалын дийлэнх нь арилжааны банкуудын гадаад зээлийн төлбөр байна. Тодруулбал, арилжааны банк 227 тэрбум төгрөгийг гадаад зээлийн үндсэн төлбөрт зарцуулжээ. Харин Төв банк ӨСХ-ийн хүрээнд ОУВС-гийн 273 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр авсан нь гадаад зээлийн урсгалыг нэмэгдүүлэх нөлөөтэй байв. Санхүүгийн сектор нь багцын хөрөнгө оруулалт хэлбэрээр дотоод эдийн засгаас 62 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн нь голчлон дотоодын үнэт цаасны компаниудын гадаад зах зээлээс худалдан авсан үнэт цаасны төлбөр буюу 110 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй холбоотой.

2. Дотоод санхүүжилтийн хэсэгт сектор хоорондын санхүүгийн хөрөнгийн урсгалыг харуулдаг. Засгийн газар болон Хөгжлийн банкнаас санхүүгийн болон хувийн сектор руу хөрөнгө шилжсэн байна. **Засгийн газар** цэвэр дүнгээр 878 тэрбум төгрөгийн хөрөнгийг бусад секторт шилжүүлсэн. Засгийн газар Төв банкинд харилцахаас 932 тэрбум төгрөгийг татаж дотоод бондын төлбөрт зарцуулсан. Арилжааны банкууд ЗГҮЦ-ны төлбөрт 1.1 их наяд төгрөгийн хөрөнгийг хүлээн авчээ. Түүнчлэн 2018 онд нийгмийн даатгалын хувь хэмжээ 2 нэгж хувиар нэмэгдэж, төрийн албан хаагчдын цалин өссөнтэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн орлого өсч, арилжааны банкууд дахь нийгмийн даатгалын хөрөнгө 400 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Харин **Хөгжлийн банк** гадаад сектороос татсан гадаад бондын хөрөнгөөс 559 тэрбум төгрөгөөр ТБҮЦ худалдан авч, 152 тэрбум төгрөгийн зээл олгосон. **Арилжааны банкууд** ЗГҮЦ-ны төлбөр болон нийгмийн даатгалын эх үүсвэрийн 1.6 их наяд төгрөгөөр хөрөнгөө нэмэгдүүлж, хувийн сектороос 4 орчим их наяд төгрөгийн эх үүсвэрийг татжээ. Хүлээн авсан 5.6 орчим их наяд төгрөгийн хөрөнгөөс 2.4 их наяд төгрөгийг ТБҮЦ-д, 3.5 их наяд төгрөгийг хувийн секторт зээл олгох хэлбэрээр зарцуулсан.

3. Санхүүгийн секторын гадаад цэвэр активын өөрчлөлт 1.5 их наяд төгрөг байгаа нь Төв банк болон арилжааны банкуудын гадаад цэвэр актив тус дүнгээр нэмэгдсэнийг илэрхийлнэ. Тухайлбал, арилжааны банкны хувьд гадаад пассив 506 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч гадаад актив 382 тэрбум төгрөгөөр өссөн тул зөрүү буюу 124 тэрбум төгрөгөөр гадаадад байршуулсан хөрөнгийн дүн буурсныг харуулж байна. Харин Төв банкны хувьд мөнгөжсөн алт хэлбэрээр 1.6 их наяд төгрөгийн хөрөнгийг гадаадын банканд байршуулснаар гадаад цэвэр актив тус дүнгээр нэмэгджээ.


Дүгнэлт

Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээнээс дараах гол дүгнэлтүүд гарч байна. Дотоод эдийн засаг 2018 онд нийт 4.2 орчим их наяд төгрөгийн хөрөнгийн дутагдалтай байсны дийлэнх нь хувийн сектортой холбоотой байна. Энэ алдагдлыг хувийн секторт орж ирсэн ГШХО, Засгийн газрын гадаад зээл болон Хөгжлийн банкны гадаад бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн. Гадаад хөрөнгийн цэвэр урсгал эерэг байж, төсвийн дотоод санхүүжилтийн шаардлага бага байсан нь бусад сектороос санхүүгийн сектор руу шилжих хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлж, улмаар хувийн секторт олгох зээлийн дүн нийт 4 орчим их наяд төгрөгөөр өсчээ.


2.2. Нийт эрэлт

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эрэлт талаас авч үзвэл 2019 оны эхний хагас жилийн байдлаар 7.2 хувиар өслөө. Үүнд эрэлт талаас хөрөнгийн хуримтлал, хэрэглээ эдийн засгийн идэвхжлийг дэмжсэн ч цэвэр экспорт өсөлтийг сааруулах нөлөө үзүүлсэн байна.

Зураг 13. ДНБ-ний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Зураг 14. ДНБ-ний жилийн өсөлтөд эзлэх хувь



Эх сурвалж: УСХ

Засгийн газрын хөрөнгө оруулалтын зардал, бизнесийн зориулалттай зээл өссөнөөр хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 24.9 хувиар тэлж, өсөлтийг 9.8 нэгж хувиар тэтгэв. Түүнчлэн нүүрс, зэсийн агуулахын үлдэгдэл нэмэгдэн материаллаг хөрөнгийн өөрчлөлт 9.9 хувиар өслөө.

Өрхийн орлого, хэрэглээний зээл, зах зээлийн итгэл нэмэгдэж, энэ нь өрхийн хэрэглээнд эергээр нөлөөлж, өрхийн хэрэглээ 4.7 хувиар тэлж, өсөлтийг 2.9 нэгж хувиар дэмжлээ.

Цэвэр экспорт нийт эрэлтийг 7.1 нэгж хувиар сааруулаа. Эрдэс бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр байснаар зэсийн хүдэр, баяжмал, алт, төмрийн хүдэр зэргийн экспорт нэмэгдэж, нийт экспорт 22.2 хувиар нэмэгдсэн. Нөгөөтэйгүүр эдийн засгийн идэвхжил, хөрөнгө оруулалт өндөр байснаар импорт тайлант улиралд 25.7 хувиар нэмэгджээ.

III. УЛСЫН ТӨСӨВ

Батлагдсан төсвөөр Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 331 тэрбум төгрөг, төсвийн зардал 2271 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн алдагдал энэ онд өмнөх жилээс 5.5 нэгж хувиар сулрах төлөвтэй байна.

Зураг 15. Нэгдсэн төсвийн орлого, зардал, тэнцэл



Зураг 16. Нэгдсэн төсвийн орлого, зардлын жилийн өөрчлөлт (%)



Эх сурвалж: Сангийн яам

2019 оны эхний хагаст төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 762 тэрбум төгрөг буюу 18.4 хувиар өссөн бөгөөд тэнцвэржүүлсэн орлогын 90.7 хувийг татварын орлого бүрдүүллээ. Төсвийн орлогод импорттой холбоотой татварын орлого (362 тэрбум төгрөг), орлогын албан татвар (1142 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого⁸ (924 тэрбум төгрөг), дотоодын бараа, үйлчилгээний татвар (1050 тэрбум төгрөг)-ын орлого том нөлөө үзүүлэв.

Төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан зардал өмнөх оноос 1.5 орчим их наяд төгрөг буюу 2 дахин, цалин хөлсний зардал 336 тэрбум төгрөгөөр нэмэгдэх юм. Эхний хагас жилд төсвийн зардал 81.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа ч энэ нь өмнөх онуудтай харьцуулахад өндөр дүн юм⁹. Зээлийн үйлчилгээний төлбөр болон эргэж төлөгдөх цэвэр зээлээс бусад зардлын томоохон бүрэлдэхүүн хэсгүүд өмнөх оны мөн үеэс 10-аас дээш хувиар тэлжээ. Тэр дундаа төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 61 хувиар нэмэгдсэн нь хамгийн өндөр дүн. Харин сүүлийн 2 жилд 1 их наяд даваад байсан хүүний төлбөр 2019 оны эхний хагаст өмнөх оноос 19.7 хувиар бага байгаа бол 2019 онд нийтдээ 900 орчим тэрбум төгрөгт хүрч буурах төлөвтэй.

⁸ Нийгмийн даатгалын шимтгэл 2019 оны 1-р сарын 1-нээс 1 нэгж хувиар нэмэгдэв.

⁹ Өмнөх 3 жилийн дунджаар оны эхний хагаст төсвийн гүйцэтгэл 77 хувьтай тэнцүү байна.

Хүснэгт 5. Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

тэрбум төгрөг	2018	2019	2019.06	
	Гүй.	Бат.	Гүй.	%
Нийт орлого	10063	11066	5549	105.3
Ирээдүйн өв сан	621	1069	617	116.3
Тогтворжуулалтын сан	207	322	32	34.0
Тэнцвэржүүлсэн орлого	9235	9676	4900	105.5
Татварын орлого	8207	8566	4446	107.3
Татварын бус орлого	1028	1110	454	90.6
Нийт зардал	9223	11590	4708	81.9
Анхдагч зардал	8176	10724	4271	81.0
Урсгал зардал /-хүүний зардал/	6301	7365	3525	85.4
Хөрөнгийн зардал	1608	3215	636	57.2
Цэвэр зээл	267	144	110	321.8
Хүүний зардал	1047	866	437	92.0
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	12	-1914	192	
ДНБ-д эзлэх хувь	0.0%	-5.1%	0.5%	
Анхдагч тэнцэл	1059	-1049	629	
ДНБ-д эзлэх хувь	3.2%	-2.8%	1.7%	

Хүснэгт 6. Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

тэрбум төгрөг	2019 он	
	Жилийн төлөвлөгөө	2019.06 Гүйцэтгэл
1 Шаардлагатай санхүүжилтийн дүн	3740	73
1.1 Үнэт цаас эргэн төлөхөд	716	79
Дотоод	716	79
Гадаад	0	0
1.2 Зээл эргэн төлөхөд	852	186
Дотоод	0	0
Гадаад	852	186
1.3 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд	2172	-192
2 Эх үүсвэр бүрдэл	3740	73
2.1 Шинээр гаргасан үнэт цаас	968	0
Дотоод	968	0
Гадаад	0	0
2.2 Шинээр авсан зээл	1675	433
Дотоод	0	0
Гадаад	1675	433
Төслийн зээл	1096	433
Хөтөлбөрийн зээл	579	0
2.3 Сангийн орлогоос	837	0
Ирээдүйн өв сан	515	0
Тогтворжуулалтын сан	322	0
2.4 Харилцах хадгаламжийн цэвэр өөрчлөлт болон бусад	260	-360

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн тэнцэл 192 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Нийт 265 тэрбум төгрөгийн зээл болон үнэт цаасыг эргүүлэн төлж, төслийн зориулалтаар 433 тэрбум төгрөгийн зээл шинээр авснаар Монголбанканд байрших харилцах дансны үлдэгдэл 360 тэрбум төгрөгөөр зузаарлаа.

ШИГТГЭЭЗ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ЗАРДАЛ, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн шинжилгээ нь өрийн удирдлагатай холбоотой бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог тодотгон харуулах чухал ач холбогдолтой байдаг. Зардал эрсдэлийн үзүүлэлтүүдийн 2018 оны жилийн эцсийн байдлаарх үр дүнг Хүснэгт 7-д харууллаа.

Хүснэгт 7. Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд

Эрсдэлийн үзүүлэлт		Гадаад зээл	Дотоод зээл	Нийт зээл
Өрийн багцын зардал	Хүүгийн төлбөрийн ДНБ-д эзлэх хувь	2.3	0.6	2.9
	Жигнэсэн дундаж хүү /хувиар/	3.6	12.2	4.3
Дахин санхүүжилтийн зардал	Эргэн төлөгдөх дундаж хугацаа (Average time to maturity), жилээр	8.4	5.0	8.2
	Богино хугацаанд төлөгдөх өр /нийт өрд эзлэх хувь/	2.2	10.6	2.7
	Богино хугацаанд төлөгдөх өр /ДНБ-д эзлэх хувь/	1.7	0.5	2.2
Хүүгийн түвшний эрсдэл	Хүү шинэчлэгдэх дундаж хугацаа (Average time to re-fixing), жилээр	7.7	5.0	7.6
	1 жилд тогтмолжуулах өр /нийт өрд эзлэх хувь/	13.0	10.6	12.8
	Тогтмол хүүтэй зээл ба бонд /нийт өрд эзлэх хувь/	88.3	100.0	89.0
Ханшийн эрсдэл	Гадаад валютаарх өр /нийт өрд эзлэх хувь/			92.7
	Богино хугацаат өр төлбөр /Валютын нөөцөд эзлэх хувь/			5.9

Эх сурвалж: Сангийн яам

Өрийн багцын зардал

Өрийн багцын зардал 2018 оны жилийн эцсийн байдлаар ДНБ-ий 2.9 хувьтай тэнцэж байна. Үүнийг задалбал, Засгийн газрын гадаад өрийн зардал ДНБ-ий 2.3 хувь, харин дотоод өрийн зардал 0.6 хувь байна. Жинлэсэн дундаж хүүгийн хувь хэмжээ 2018 оны жилийн эцсийн байдлаар 4.3 хувьтай байна. Үүнээс гадаад өрийн жигнэсэн дундаж хүү 3.6 хувь, дотоод өрийн жигнэсэн дундаж хүү 12.2 хувь байна.

Өрийн багцын эрсдэл-Дахин санхүүжилтийн эрсдэл

Дахин санхүүжүүлэх эрсдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар харьцангуй бага түвшинд буюу нийт багцын эргэн төлөлт хүртэлх дундаж хугацаа 8.2 жил байна. 2021-2024 онд томоохон бондуудын эргэн төлөгдөх хугацаа дуусч дахин санхүүжилтийн эрсдэл нэмэгдэхээр байна. 2021 онд Мазаалай 500 сая ам.доллар, 2022 онд Чингис 1,000 сая ам.долларын үнэт цаасыг эргэн төлөх бол 2023-2024 онд Гэрэгэ, Хуралдай төслүүдийн хүрээнд арилжаалсан 1,400 сая ам.долларыг хөрөнгө оруулагчдад эргэн төлнө.

Өрийн багцын эрсдэл-Хүүгийн түвшний эрсдэл


Өрийн багц дахь хүү тогтмолжуулах дундаж хугацаа 7.6 жил байна. Үүнээс гадаад өрийн хүү тогтмолжуулах дундаж хугацаа 7.7 жил байгаа бол дотоод өрийн хувьд 5 жил байна. Засгийн газраас 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулж, арилжааны нөхцөлтэй дотоод үнэт цаасны хэмжээг бууруулах ажлын хүрээнд дотоод үнэт цаасны арилжааг тодорхойгүй хугацаагаар зогсоож, 2018-2020 онд төлөгдөх нөхцөлтэй байсан өндөр хүүтэй нийт 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 2017 оны 11-12 дугаар сард хугацаанаас нь өмнө буцаан худалдан авснаар

өрийн багцад эзлэх богино хугацаат дотоод үнэт цаасны эзлэх хувь эрс багассан нь нийт өрийн багцын хэмжээнд хүү тогтмолжуулах дундаж хугацаа нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Зураг 17. Засгийн газрын нийт төлбөр, сая ам.доллар



Зураг 18. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөр, сая ам.доллар



Эх сурвалж: Сангийн яам.

Өрийн багцын эрсдэл-Валютын ханшийн эрсдэл

Засгийн газрын зүгээс дотоод үнэт цаасны арилжааг зогсоосон, зарим дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах замаар дотоод үнэт цаасны хэмжээг бууруулснаар гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн нийт өрд эзлэх хувь хэмжээ 2018 онд 92.7 хувьд хүрч 2016 оноос 15.9 нэгж хувиар өссөн. Өрийн багцыг валютын бүтцээр харвал Засгийн газрын өрийн 63 хувь нь ам.доллар, 17 хувь нь Зээлжих тусгай эрх, 15 хувь нь иен, 2 хувь нь бусад валютаас тус тус бүрдэж байна.

IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

4.1. Төсөөлөлд ашигласан гадаад зах зээлийн таамаглал

Гадаад эрэлт

ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2019 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас нэмэгдсэн бол БНХАУ, АНУ болон Евро бүсийн эдийн засгийн өсөлт саарч, манай гадаад эрэлт саарав. Цаашид, (i) Хятад дотоод эрэлтэд суурилсан эдийн засгийн өсөлтийн загварт шилжихийн зэрэгцээ худалдааны зөрчилдөөний нөлөөгөөр эдийн засгийн өсөлт нь удаашрах хандлагатай (ii) АНУ-ын худалдааны маргаан даамжирч, хөрөнгө оруулалтын итгэл сул байх, төсвийн зарцуулалтын өсөлт удаашрах нөлөөгөөр эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй; (iii) Евро бүсээс ОХУ-д тавьсан хориггоо чангаруулснаас гадна, АНУ-аас нэмэлт хориг тавьж болзошгүй, газрын тосны үнэ төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул ОХУ-ын эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй; (iv) Евро бүсийн мөнгөний зөөлөн бодлого өсөлтийг дэмжих ч бизнесийн орчны итгэл сул, аж үйлдвэрлэл, экспорт саарах төлөвтэй тул бүсийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэхээргүй байна. Улмаар Монгол Улсын гадаад эрэлтийн төлөв богино, дунд хугацаанд төдийлөн сайжрахааргүй байна.

Зураг 19. Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: Рубини, EIU, Блүмберг, ОУВС

АНУ-ын эдийн засаг 2019 оны 2 дугаар улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 2.1 хувиар өсөв. ДНБ-ий өсөлтийн гуравны хоёрыг бүрдүүлдэг хувийн хэрэглээ 2 дугаар улиралд сэргэж өмнөх улирлаас 4.3 хувиар нэмэгдэж, оны эхний 7 сард дунджаар 164,000 ажлын байр шинээр бий болсон нөлөөгөөр ажилгүйдэл буурч 3.7 хувьд хүрлээ. Ажил эрхлэлт, өрхийн орлого нэмэгдэж байгаа ч эхний улиралд 4.4 хувьд хүрч өссөн бизнесийн хөрөнгө оруулалт саарч 2 дугаар улиралд 0.6 хувиар өсөв. Энэ оны сүүлийн хагаст хөрөнгө оруулалтын тодорхой бус байдал үргэлжлэн, бизнесийн хөрөнгө оруулалт сул байх, төсвийн зарцуулалтын өсөлт удаашрах нөлөөгөөр эдийн засгийн өсөлт оны эхний хагасаас саарах, 2020 онд 1.8 хувийн өсөлттэй байх төлөвтэй байна.

БНХАУ-ын дэд бүтцийн салбарт оруулсан төсвийн хөрөнгө оруулалт, татварын хөнгөлөлтийн нөлөөгөөр Хятадын эдийн засаг 2019 оны 2 дугаар улиралд 6.2 хувиар өслөө. Эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор Хятадын Ардын банкнаас зээл олголт болон зээлийн нөхцөлийг зөөлрүүлж байгаа, 2018 оны эхнээс банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг шат дараатай нийт таван удаа бууруулсан, цаашид дахин бууруулах төлөвтэй, мөн Засгийн газраас өсөлтийг дэмжих хүрээнд авч хэрэгжүүлж буй төсвийн тэлэх арга хэмжээнүүдийн үр дүнд эдийн засгийн өсөлт 2019-20 онд 6.2-6.0 хувиас доош буухгүй гэж Блүүмберг, Рубини, EIU судалгааны агентлагийн шинжээчид үзэж байна. Харин хурдацтай өсч буй хувийн секторын өрийн хэмжээ анхаарал татсан хэвээр, АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан гүнзгийрсэн нь Хятадын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

ОХУ-ын төсвийн хэрэглээ 0.8 хувиар, нийт хөрөнгө оруулалт 1.1 хувиар, экспорт 2.8 хувиар, аж үйлдвэрлэл 2.3 хувиар тус тус өссөнөөр эдийн засаг 2019 оны 2-р улиралд 0.9 хувиар өслөө. АНУ-аас ОХУ-д тавьсан хориггоо чангаруулах хүлээлт, Минскийн хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотойгоор Евро бүсийн зүгээс ОХУ-д тавьсан хориггоо дахин 6 сараар сунгаад байгаа нь тус эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлөхөөр байна. Гэвч цаашид хувийн хэрэглээ өсөх хандлагатай, ОПЕК-ийн орнууд үйлдвэрлэлээ 1.2 сая баррельд хадгалах тохиролцоогоо дахин 9 сараар сунгасан, ОХУ-ын Засгийн газар татварын шинэчлэлтийн хүрээнд 2019-23 онд улсын төсөв дунджаар ДНБ-ий 1.4 хувьтай тэнцэх ашигтай гарахаар хүлээгдэж байгаа¹⁰ тул ОХУ-ын эдийн засаг 2019 онд 1.2 хувиар өснө гэж шинжээчид үзэж байна. Харин ажилгүйдэл, инфляци харьцангуй өндөр, газрын тосны үнэ төдийлөн нэмэгдэхээргүй байгаа, 2019-21 онд баримтлах төсвийн хатуу бодлого, барууны орнуудын худалдааны хориг зөөлрөх нөхцөл хараахан бүрдээгүй байгаа ч Төв банкнаас баримтлах мөнгөний бодлогын зөөлөн төлөв болон хувийн хэрэглээний өсөлт нь эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болж 2020 онд өсөлт 1.7 хувь байх төлөвтэй гэж Блүүмберг, “EIU” байгууллагын шинжээчид үзэж байна.


Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2019-2020 онд 1.1-1.3 орчим хувьд байх төлөвтэй байна. Европын төв банк мөнгөний бодлогоо зөөлрүүлэх хүлээлт болон төсвийн харьцангуй зөөлөн бодлого нь дотоод эрэлт, хэрэглээг дэмжинэ. Харин Евро бүсийн аж үйлдвэрлэлийн сааралт, түнш орнуудын эдийн засаг удааширнаас бүсийн экспорт саарах төлөв, худалдааны маргаан, Брекситийн хэлэлцээрийн тодорхой бус байдлын нөлөөгөөр буурч буй бизнес, хөрөнгө оруулалтын итгэл зэрэг нь өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэхээр байна. Эдгээр хүчин зүйлсийг харгалзан Евро бүсийн өсөлт 2019 онд 1.1 хувь, 2020 онд 1.3 хувь байх хүлээлттэй байна.

¹⁰ Оросын Засгийн газар төсвийн алдагдлаа хэрхэн санхүүжүүлэх, олон улсын байгууллагаас зээл авах эсэх зэрэг төсвийн тодорхой бус байдал шинжээчдийн дунд байсаар байв.

Гадаад хүү

АНУ-ын бизнесийн идэвхжил сул, инфляци буурах төлөвтэй, дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, худалдааны бодлого тодорхой бус байгаа нөхцөлд ажил эрхлэлт, эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор Холбооны нөөцийн банк 2019 оны 7-р сарын 31-ний хурлаар бодлогын хүүг 0.25 нэгж хувиар бууруулж, 2.25 хувьд хүргээд байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч байгаагаас шалтгаалан Холбооны нөөцийн банк бодлогын төлвийг цаашид сулруулах хүлээлттэй байна.

Зураг 20. Холбооны нөөцийн банкны хүү, хувиар



Эх сурвалж: Блумберг (*-төсөөлөл)

Түүхий эдийн үнийн төлөв

Алт. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарах төлөв, АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах хүлээлт, АНУ-ын Иран, Турк зэрэг оронтой харилцаа сайнгүй байгаа зэргээс шалтгаалан аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт нэмэгдэж, 2019 оны 8-р сард үнэ дунджаар 1495 ам.долларт хүрч өсөв. Олон улсад геополитикийн эрсдэл буураагүйн зэрэгцээ төв банкуудын алт худалдан авалт огцом нэмэгдэж, 2019 оны эхний хагас жилийн байдлаар 374.1 тоннд хүрч, сүүлийн 19 жилийн хамгийн өндөр хувиар өсөөд байна. Цаашид АНУ-ын эдийн засгийн идэвхжил төдийлөн нэмэгдэхгүй, Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах төлөвтэй байгаагийн зэрэгцээ хөгжингүй орнуудын өсөлтийн төлөв буурсан нөлөөгөөр 2019 оны сүүлч, 2020 онд алтны үнэ өндөр түвшинд хадгалагдана гэж үзэж байна.

Зэс. АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан даамжирснаас үүсч буй тодорхой бус байдлаас өндөр хамааралтайгаар зэсийн зах зээлд оролцогчдын хандлага өөрчлөгдөж, улмаар Лондонгийн металлын бирж дээр арилжаалагдаж буй зэсийн үнэ 2019 оны 8-р сард дунджаар 5714 ам.долларт хүрч буураад байна. Тухайлбал, дэлхийн нийт цэвэршүүлсэн зэсийн хэрэглээний 45 хувийг дангаараа бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт энэ оны 2-р улиралд сүүлийн 27 жилийн хамгийн доод түвшинд хүрч саарсан төдийгүй Европын холбоо, Япон, АНУ зэрэг хөгжингүй орнуудад цэвэршүүлсэн зэсийн хэрэглээ буурч байна. Цаашдын үнийн төлөв худалдааны дайны өрнөл хэрхэн явагдахаас голлон шалтгаалах бөгөөд 2019 оны сүүлч, 2020 онд нийлүүлэлтийн бага хэмжээний хомсдол үргэлжлэх төлөвтэй байгаа нь шинжээчдийн дунд зэсийн үнийг хүчтэй бууруулахгүй байх хүлээлтийг бий болгож байна.

Коксжих нүүрс. Хятадын гангийн үйлдвэрлэл 2019 оны эхний хагаст 10 хувиар өссөн, Хятадын засгийн газраас дотоодын нүүрсний уурхайд байгаль орчны шалгалт хийж байгаа нь коксжих нүүрсний үнэ оны эхний хагаст өндөр хадгалагдах хүчин зүйлс болов. Хятадын Фенвей sxcoal.com агентлагийн судалгаагаар дотоодын томоохон үйлдвэрлэгч мужуудад нүүрсний үнэ богино хугацаанд тогтвортой байхаар хүлээгдэж байна. Хятадын Шандон муж коксжих нүүрсний уурхайнуудаа хааж, хүчин чадлаа 2019 онд 10 сая тонноор, 2020 онд 6.6 сая тонноор бууруулахаар байна. Цаашид Хятадын Засгийн газраас нүүрсний олборлолт, импортод тавих хяналтаа 2019 онд үргэлжлүүлэхийн зэрэгцээ Хятадын гангийн үйлдвэрлэлийн өсөлт саарах хандлагатай байгаа нь коксжих нүүрсний эрэлтийг бууруулж, 2019 онд коксжих нүүрсний үнийг өмнөх оноос бууруулахаар байна.

Төмрийн хүдэр. Бразилийн уурхайд 2019 оны эхэнд хаягдлын далан задарснаас үүссэн ослын улмаас төмрийн хүдрийн нийлүүлэлт огцом буурсан төдийгүй БНХАУ-ын гангийн эрэлт хүлээлтээс өндөр байснаар төмрийн хүдрийн үнэ оны эхний хагас жилийн туршид өсч, 7-р сарын сүүлч хүртэл түүхэн дээд түвшин буюу 117 ам.долларт хадгалагдлаа. Харин 8-р сар гарсаар худалдааны дайныг тойрсон эрэлт саарах хүлээлтээс үүдэлтэйгээр төмрийн хүдрийн үнэ 93 ам.долларт хүрч, буурах хандлага давамгайлж эхэллээ. Бразилийн Засгийн газраас дээрх осолтой холбогдуулан Vale компанид торгууль ногдуулж, үйлдвэрлэлийн хязгаарлалт тогтоосон төдийгүй цаашид нийлүүлэлт хэвийн хэмжээндээ хүрч, жигдрэх хүртэл хамгийн багадаа 1 жилийн хугацаа шаардагдахаар байгаа нь төмрийн хүдрийн үнэ огцом буурахгүй байх үндэслэл болж байна. Нөгөө талаас, БНХАУ-ын зүгээс Европын холбоо, Япон, Өмнөд Солонгос, Индонези зэрэг орноос импортлох зэвэрдэггүй ган хавтан болон ороомогт 5 жилийн туршид татвар ногдуулахаар болсон байна. Түүнчлэн дотоодын гангийн үйлдвэрүүд


нийлүүлэлтийн илүүдэлтэй ажиллаж, ашигт ажиллагаа нь буурч, улмаар гангийн эрэлт саарах хүлээлттэй байгаа, байгаль орчин, аюулгүй байдлын хяналт шалгалтуудыг чангатгах болсон зэрэг нь цаашид төмрийн хүдрийн үнэнд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Газрын тос. Brent маркийн газрын тосны үнэ 8-р сард дунджаар 59 ам.долларт хүрч, сүүлийн 3 сарын турш буурах хандлагатай байлаа. ОПЕК-ийн гишүүн орнуудын үйлдвэрлэлээ танах хэлэлцээрийн хүрээнд Саудын Араб, ОХУ болон Ливийн үйлдвэрлэл буурч, нөөцийн түвшин доогуур хадгалагдаж байгаа төдийгүй Иран болон Венесуэлийн эсрэг авч буй хориг арга хэмжээний хүрээнд экспорт нь саарч байна. Цаашид нийлүүлэлт талаас ОПЕК-ийн гишүүн болон гишүүн бус орнууд өдрийн үйлдвэрлэлээ 1.2 сая баррелийн танасан түвшинд барих хэлэлцээрийг 2020 оны 3-р сарыг дуустал хэрэгжүүлэх шийдвэрт хүрсэн төдийгүй үнийн тогтвортой байдлыг хангахын тулд Саудын Араб экспортоо дахин танахад бэлэн байгаагаа илэрхийлээд байна. Гэвч эрэлт талаас дэлхийн эдийн засгийн өсөлт удааширснаар газрын тосны эрэлт буурах төлөвтэй байна. ОПЕК-оос дэлхийн газрын тосны хамгийн том 2 хэрэглэгч хоорондын худалдааны маргаанаас шалтгаалан 2019 онд газрын тосны эрэлтийн төлөвийг өдрийн 1.1 сая баррель болгож бууруулсан бол 2020 онд төлөвийг одоогоор 1.14 сая баррель байхаар төсөөлж байгаа ч цаашид бууруулах эрсдэл өндөр байгааг мэдэгдээд байна.

Худалдааны нөхцөл

1. Экспортын үнэ 2016 оны 4 дүгээр улирлаас эхлэн дэлхийн зах дээр түүхий эдийн эрэлт сэргэж, зэс, нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн үнэ өссөн нөлөөгөөр өмнөх жилийн түвшнээсээ сайжирч байсан бол 2018 оны 4 дүгээр улирлаас эхлэн зэс, газрын тосны үнэ буурсан голлох нөлөөгөөр өмнөх жилийн түвшнээсээ буурч эхэллээ. Төсөөллийн хугацаанд нүүрс, зэс, төмрийн хүдрийн үнэ үргэлжлэн сулрах нь манай экспортын үнэ буурахад нөлөөлнө
2. Импортын үнийн индексийг дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ, шатахууны үнэ болон гадаад үнээр төлөөлүүлэн тооцдог. Цаашид жилийн өмнөх түвшнээсээ буурах хүлээлттэй байна.

Зураг 21. Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулахдаа ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т тусгагдсан төсвийн болон мөнгөний бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж, уул уурхайн бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу хийгдэн төсвийн зардал энэ онд УИХ-аас баталсан түвшинд хадгалагдаж, ирэх онд Төсвийн дунд хүрээний мэдэгдэлд тусгасан хэмжээнд байх нөхцөлүүдийг ашиглалаа.

Суурь төсөөллөөр 2019 онд уул уурхайн салбарын өсөлт өмнөх оны орчимд хадгалагдаж, уул уурхайн бус салбарын өсөлт саарах төлөвтэй байна. Ингэснээр эдийн засгийн өсөлт 2019 онд өмнөх оноос бага зэрэг буурах ч потенциаль түвшнээс өндөр байх, харин 2020 онд потенциаль түвшний орчимд хадгалагдахаар байна. Ирэх онд уул уурхайн бус салбар эдийн засгийн өсөлтөд голлох хувь нэмэр оруулна. Төсөөллийн хугацаанд эдийн засгийн өсөлтөд төсвийн бодлогын төлөв, дотоод эрэлт гол эерэг нөлөөтэй, харин түүхий эдийн үнэ, гадаад эрэлтийн төлөв, ГШХО нь сөрөг нөлөөтэй байна. 2020 онд Оюу толгойн гүний уурхайн хөрөнгө оруулалт энэ оны түвшнээс буурч байгаагийн зэрэгцээ бусад гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөхгүй гэж үзсэн тул ГШХО эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэхээр байна.

Төмрийн хүдэр, газрын тосны олборлолт, экспортын биет хэмжээ 2019 онд нэмэгдэж уул уурхайн салбарын өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх бол нүүрс, зэсийн баяжмалын олборлолт, экспортын биет хэмжээ өмнөх оноос

нэмэгдэхээргүй байна. Харин 2020 оныг дуустал алтнаас бусад түүхий эдийн үнэ буурах хандлагатай, алтнаас бусад түүхий эдийн экспортын биет хэмжээ нэмэгдэхээргүй, Оюу толгойн баяжмал дахь алтны агууламж 2 дахин буурах зэргээс шалтгаалан уул уурхайн салбарын өсөлт саарах хүлээлттэй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын зардал 2019 оны сүүлийн хагаст эрчимжиж барилга, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжих, цаг агаарын төлөв олон жилийн дунджийн орчимд байсан нөхцөлд ХАА-н салбарын өсөлт өмнөх оны орчимд хадгалагдах, оны эхний хагасын уул уурхайн салбар дахь эрчимтэй өсөлт, өрхийн хэрэглээг дагаад худалдаа нэмэгдэх зэрэг нь уул уурхайн бус салбарын өсөлтөд голлон нөлөөлнө. Харин, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт саатаж 2019-2020 онд хөрөнгө оруулалтаа бууруулсан тохиолдолд барилгын салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Нөгөө талаас, Таван Толгой - Зүүнбаянгийн төмөр замын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт нэмэгдвэл барилгын салбарын өсөлтийг дэмжинэ.


Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр ирэх онд хөрөнгийн болон урсгал зардлууд тэлж, уул уурхайн бус салбарыг дэмжих хэдий ч үүнийг дагаад хөрөнгө оруулалтын импорт нэмэгдэх, гадаад эрэлт саарах, уул уурхайн салбарын идэвхжил буурах дам нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт саарахаар байна. Хэдийгээр хувийн салбарт олгож буй бизнесийн зээлийн өсөлт сэргэж, дотоодын хөрөнгө оруулалт тогтворжиж байгаа ч гадаадын шууд хөрөнгө оруулалт цаашид саарах, экспортын бүтээгдэхүүний үнэ буурч, гадаад эрэлт саарах хандлагатай тул эдийн засгийн өсөлт төсөөллийн хугацаанд саарч байна.

Хүснэгт 8. ДНБ болон инфляцийн төсөөлөл

Он	ДНБ-ий өсөлт %			Инфляци %		
	Нийт	Уул уурхайн	Уул уурхайн бус	Нийт	Хүнсний	Суурь
2019	6.8-7.0	5.4-5.9	7.1-7.3	8.6-8.8	11.3-11.6	8.2-8.4
2020	5.1-6.3	0.8-3.2	5.9-7.2	7.3-9.2	8.0-10.3	8.8-10.9

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Зураг 22. Улирлын ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол


4.3. Инфляцийн төсөөлөл

Эдийн засгийн өсөлт өмнөх жилээс саарах хэдий ч, харьцангуй өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй байгаа тул түүнийг дагаад эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэх ч 2020 оноос саарах хандлагатай байна. Хэдийгээр нийлүүлэлтийн хүчин зүйлийн нөлөө хурдтай арилахааргүй байгаа боловч инфляци Төв банкны зорилтот түвшиний орчимд хадгалагдахаар байна.

Нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр үнэ нь өсч, жилийн инфляцийн талаас илүү хувийг тайлбарлаж байсан шатахуун, мах, хатуу түлшний үнийн инфляцид үзүүлэх нөлөө аажмаар саарах хүлээлттэй байгаа боловч дотоод, гадаад хүчин зүйлсээс хамааран үнэ хэлбэлзэх эрсдэл хэвээр байна. 2019 оны хавар дотоодын махны нийлүүлэлт саатаж, махны үнэ огцом өссөн бол үнийн өсөлт нь 6 болон 7 дугаар саруудад хадгалагдлаа. Махны үнийг цаашид улирлын чиг хандлагын дагуу өөрчлөгдөхөөр авч үзсэн боловч махны экспорт, дотоодын нийлүүлэлтийн хэмжээ нь махны үнэд хүчтэй нөлөөлөхөөр байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, нефтийн нөөц нэмэгдэж байгаа тул гадаад үнээс шалтгаалан дотоодын шатахууны үнэ өсөх дарамт буурах хандлагатай. Түүнчлэн сайжруулсан нүүрсний нийлүүлэлт болон үнийг 2020 оны хавар хүртэл хариуцсан байгууллагаас зохицуулах хүлээлттэй байгаа тул хатуу түлшний үнэ нэмэгдэхгүй, одоогийн түвшинд хадгалагдана гэж үзлээ.

Хэрэглээний зээлийн өсөлт саарч, оны эхнээс зээлийн үлдэгдэл буурч байгаагийн зэрэгцээ цалингийн өсөлтийн инфляцид үзүүлэх нөлөө саарч байна. Харин төсвийн төлөв 2019-2020 онд суларч дотоод эрэлтийг дэмжихээр байгаагаас инфляцид үзүүлэх эрэлтийн хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэж, хүнсний бус инфляцийг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн ирэх онд дэлхийн зах зээлд хүнсний үнэ өсч, дотоодын хүнсний барааны үнийг нэмэгдүүлж болзошгүй.

Зураг 23. Жилийн инфляцийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хүснэгт 9. Эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтүүд, (суурь төсөөлөл)

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
	Гүйцэтгэл				2019	2020
	2015	2016	2017	2018	Суурь төсөөлөл	
хувь, %						
Бодит сектор						
Бодит ДНБ	2.4	1.2	5.3	7.3	7.0	5.6
Уул уурхайн ДНБ	14.1	0.2	-5.5	5.7	5.9	3.2
Уул уурхайн бус ДНБ	-1.0	1.5	8.8	7.7	7.3	6.3
Хэрэглээний үнийн индекс (4-р улиралд)	5.2	0.1	7.7	8.6	8.0	7.2
ДНБ-ний дефлятор	1.7	2.2	10.6	8.0	7.7	4.5
тэрбум төгрөгөөр						
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд						
Ирээдүйн өв сан			358	621	1,064	944
Тогтворжуулалтын сан			326	207	64	107
Нийт орлого ба тусламжийн дүн	5,974	5,852	7,239	9,235	10,559	11,139
Татварын орлого	5,143	4,997	6,303	8,207	9,396	9,799
Татварын бус орлого	831	948	1,090	1,182	1,240	1,185
Нийт зардал ба цэвэр зээл	7,137	9,520	8,981	9,223	11,590	13,197
Урсгал зардал	5,750	6,714	6,842	7,348	8,247	8,966
Хөрөнгийн зардал ба зээл	1,387	2,806	1,975	1,875	3,343	4,231
Хөрөнгийн зардал	1,338	2,305	1,646	1,608	3,199	3,891
Эргэж төлөгдөх цэвэр зээл	49	502	329	267	144	341
Нийт тэнцэл	-868	-3,668	-1,742	12	-1,031	-2,058
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцлээс тооцсон)	-432	-2,680	-586	1,059	-149	-1,387
Шаардлагатай санхүүжилт	2,500	5,587	7,756	2,703	2,329	2,985
Дотоод	2,105	4,117	2,104	1,263	-917	-106
Гадаад	394	1,470	5,652	1,440	3,246	3,091
хувь, %						
Мөнгө ба зээлийн үзүүлэлтүүд						
M2 мөнгө	-5.5	21.0	30.5	22.8	16.2	15.0
Зээл+ИЗББ	2.9	6.3	11.0	24.3	14.3	12.5
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	2.3	2.0	1.8	1.7	1.6	1.6
(Зээл+ИЗББ)/Нэрлэсэн ДНБ харьцаа	59	61	58	62	62	63
сая ам.доллараар						
Төлбөрийн тэнцэл						
Урсгал тэнцэл	-948	-63	-1138	-2210	-1930	-2654
Худалдааны тэнцэл	566	1779	1470	676	1210	423
Экспорт Ф.О.Б.	4455	4765	5840	6557	7252	6606
Импорт Ф.О.Б.	-3888	-2987	-4370	-5871	-6041	-6183
Хөрөнгийн ба санхүүгийн тэнцэл	904	302	2706	2181	2328	2174
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	83	-4178	1414	2137	1716	1583
Санхүүгийн хөрөнгө оруулалт	250	498	452	73	354	14
Бусад хөрөнгө оруулалт	455	3883	763	-121	156	-7
Нийт тэнцэл	-268	-18	1460	-147	367	-480
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөгөөр	23150	23943	27896	32307	37241	41116

Хүснэгт 10. Эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтүүд, ДНБ-д эзлэх хувиар (суурь төсөөлөл)

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
	Гүйцэтгэл				2019	2020
	2015	2016	2017	2018	Суурь төсөөлөл	
өөрөөр заагаагүй бол ДНБ-д эзлэх хувиар, %						
Бодит сектор						
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	23,150	23,943	27,896	32,307	37,241	41,116
Бодит ДНБ (жилийн өсөлт)	2.4	1.2	5.3	7.3	7.0	5.6
Уул уурхайн ДНБ (жилийн өсөлт)	14.1	0.2	-5.5	5.7	5.9	3.2
Уул уурхайн бус ДНБ (жилийн өсөлт)	-1.0	1.5	8.8	7.7	7.3	6.3
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт (4-р улиралд)	5.2	0.1	7.7	8.6	8.0	7.2
ДНБ-ний дефлятор (жилийн өсөлт)	1.7	2.2	10.6	8.0	7.7	4.5
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд						
Ирээдүйн өв сан			1.3	1.9	2.9	2.3
Тогтворжуулалтын сан			1.2	0.6	0.2	0.3
Нийт орлого ба тусламжийн дүн	25.8	24.4	26.0	28.6	28.4	27.1
Татварын орлого	22.2	20.9	22.6	25.4	25.2	23.8
Татварын бус орлого	3.6	4.0	3.9	3.7	3.3	2.9
Нийт зардал ба цэвэр зээл	30.8	39.8	32.2	28.5	31.1	32.1
Урсгал зардал	24.8	28.0	24.5	22.7	22.1	21.8
Хөрөнгийн зардал ба зээл	6.0	11.7	7.1	5.8	9.0	10.3
Хөрөнгийн зардал	5.8	9.6	5.9	5.0	8.6	9.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0.2	2.1	1.2	0.8	0.4	0.8
Нийт тэнцэл	-3.7	-15.3	-6.2	0.0	-2.8	-5.0
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцлээс тооцсон)	-1.9	-11.2	-2.1	3.3	-0.4	-3.4
Шаардлагатай санхүүжилт	10.8	23.3	27.8	8.4	6.3	7.3
Дотоод	9.1	17.2	7.5	3.9	-2.5	-0.3
Гадаад	1.7	6.1	20.3	4.5	8.7	7.5
Мөнгө ба зээлийн үзүүлэлтүүд						
M2 мөнгө (жилийн өсөлт)	-5.5	21.0	30.5	22.8	16.2	15.0
Зээл+ИЗББ (жилийн өсөлт)	2.9	6.3	11.0	24.3	14.3	12.5
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	2.3	2.0	1.8	1.7	1.6	1.6
Төлбөрийн тэнцэл						
Урсгал тэнцэл	-8.1	-0.6	-10.0	-16.9	-13.8	-17.5
Худалдааны тэнцэл	4.8	15.9	12.9	5.2	8.6	2.8
Экспорт Ф.О.Б.	37.9	42.7	51.1	50.2	51.7	43.6
Импорт Ф.О.Б.	-33.1	-26.8	-38.2	-44.9	-43.1	-40.8
Хөрөнгийн ба санхүүгийн тэнцэл	7.7	2.7	23.7	16.7	16.6	14.4
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	0.7	-37.4	12.4	16.4	12.2	10.5
Санхүүгийн хөрөнгө оруулалт	2.1	4.5	4.0	0.6	2.5	0.1
Бусад хөрөнгө оруулалт	3.9	34.8	6.7	-0.9	1.1	0.0
Нийт тэнцэл	-2.3	-0.2	12.8	-1.1	2.6	-3.2

4.4. Төсөөллийн тодорхой бус байдал

Суурь төсөөллийг боловсруулахад ашигласан нөхцөлт таамаглалууд, макро эдийн засгийн бодлого, урьдчилан харах боломжгүй гадаад, дотоод хүчин зүйлсийн гэнэтийн өөрчлөлтөөс шалтгаалан төсөөлөл бодит гүйцэтгэлээс зөрөх боломжтой. Эдийн засгийн ирээдүйн төлөвт дотоод болон гадаад орчноос шалтгаалсан хэд хэдэн асуудал тулгарч болзошгүй байгаа тул эдгээр нь суурь төсөөллийн тодорхой бус байдлыг үүсгэж байна.

Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал

Тооцоолоогүй хүчин зүйлсийн нөлөөгөөр гадаад зах зээл дээр гадаад эрэлт, экспортын түүхий эдийн дэлхийн зах зээл дэх үнэ, гадаад хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлж, төлбөрийн тэнцлийн орох урсгал татарч, төгрөгийн ханш огцом сулрах, импортын барааны үнэ нэмэгдэж инфляцийг нэмэгдүүлэх, гадаад өрийн дарамт нэмэгдэж дахин санхүүжүүлэх зардал өсөх, гадаад хөрөнгө оруулалт татарч эдийн засгийн өсөлтийг сааруулах тодорхой бус байдал өндөр байна. Тухайлбал:

- Дэлхийн хоёр том гүрний хоорондын худалдааны зөрчилдөөн гүнзгийрч, 2020 оныг дуустал үргэлжлэх хандлагатай болсон нь манай улсын экспортын үнэ, гадаад эрэлт, хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж, дотоод гадаад тэнцвэр алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Хэрэв АНУ-БНХАУ-ын худалдааны зөрчилдөөн цаашид хүндэрвэл БНХАУ-ын өсөлт саарч, манай улсын гадаад эрэлт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, ГШХО буурч, улмаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспорт, төлбөрийн тэнцэл, төсвийн орлогоор дамжин макро эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Төлбөрийн тэнцэл муудаж, төгрөгийн ханш суларвал импортын барааны үнэ өсч инфляцийг нэмэгдүүлнэ.
- ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын хурлаар Монгол Улсыг “Саарал жагсаалт”-нд оруулбал 1) манай улсын зээлжих зэрэглэл муудаж гадаад өр төлбөрийн хүү өсөх, улмаар гадаад өр, төлбөрийн зардал нэмэгдэх, 2) Монгол Улс нь гадаад төлбөр тооцооны системийг ашиглахад хүндрэлтэй болох тул гадаад худалдааны эргэлт буурах, хөрөнгийн орох урсгал удааширч, гадаад хөрөнгө оруулалт буурах зэрэг хэд хэдэн сувгаар дамжин макро эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөр байна.
- Суурь төсөөлөлд Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт 2019-2020 онд өмнөх жилүүдээс буурч, 2022 онд дуусахаар авч үзэв. Тус төслийн бүтээн байгуулалттай холбоотойгоор 2019-2020 оны хөрөнгө оруулалтын хэмжээгээ бууруулахаар байна. Нөгөө талаас бүтээн байгуулалтын удааширлт нь 1.2-1.9 тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт шаардаж байна. Энэ нь эдийн засгийн дотоод эрэлт болон валютын урсгалд нөлөөлөхөөр байна.

- Дэд бүтцийн төслүүдэд гадаад хөрөнгө оруулалтыг татаж чадвал хөрөнгийн орох урсгал, нийт хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтөд ирэх сөрөг нөлөөг саармагжуулах чухал ач холбогдолтой. Хэрэв эдгээр төслүүдийг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлбэл нэг талаас хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг дэмжих боловч нөгөө талаас импортын зардлаар дамжин төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш, инфляцид дарамт учруулна.

Эдийн засгийн дотоод орчны тодорхой бус байдал

- Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол эсвэл илүүдэл нь төсөөллийг өөрчлөх эрсдэлтэй. Тухайлбал, цаг агаарын нөхцөл, зуншлагын байдал, махны экспорт, дотоодын нийлүүлэлтийн дэд бүтцийн үр ашигтай байдлаас шалтгаалан мах, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс давж нэмэгдвэл инфляци төсөөллөөс давах шалтгаан болно. Засгийн газраас мах, махан бүтээгдэхүүн экспортлох ААН-үүдийг магадлан итгэмжлэх, түүнтэй уялдуулан экспорттой холбогдуулан дотоодын махны нийлүүлэлтийг тогтворжуулахаар төлөвлөж байна. Мөн төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнийг урьдчилан мэдээлснээс зөрүүтэй байдлаар өөрчилбөл инфляцийн төсөөлөл зөрөх нэг шалтгаан болно.
- Ирэх онуудад газрын тос боловсруулах үйлдвэр болон шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орох зэрэг нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлнө. Зарим төслийг хэрэгжүүлэх, ашиглалтад оруулах цаг хугацаа, ТЭЗҮ зэрэг нь тодорхойгүй байна. Шинээр хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг гадаад санхүүжилтэд тулгуурлан хэрэгжүүлбэл төлбөрийн тэнцэл болон гадаад өрийн эргэн төлөлтөнд дарамт учруулахгүйгээр дотоод эдийн засгийн идэвхжилд дэмжлэг үзүүлнэ.
- ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд хийгдсэн Активын чанарын үнэлгээ дуусч, банкуудын нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгө нь шаардлагад нийцэж байгаа эсэхийг магадлан баталгаажуулах аудит (forensic auditing)-ыг хийж байна. Эдгээр арга хэмжээ нь дунд хугацааны банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх хэдий ч ирэх 1 жил орчмын хугацаанд зээлийн нийлүүлэлтэд нөлөө үзүүлэхээр байна.
- Суурь төсөөллийг боловсруулахдаа 2020 оны төсвийн зардлыг Төсвийн дунд хүрээний мэдэгдэлд тусгасан дүнгээр авч үзсэн боловч төсвийн зардал түүнээс давсан тохиолдолд эдийн засгийн идэвхжил, өрийн эргэн төлөлт, өрийн дахин санхүүжилт, инфляци, төгрөгийн ханшинд хүчтэй нөлөөлнө.

ШИГТГЭЭ 4. АНУ, БНХАУ ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ЗӨРЧИЛДӨӨН, ТҮҮНИЙ МАНАЙ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ


АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн энэ оны 5-р сард ширүүсч, хоёр тал импортын тарифаа өсгөсөн /Зураг 27/. Цаашид АНУ нэмэлт 325 тэрбум ам.долларын импортод тариф тогтоож болзошгүй бол БНХАУ ховор үнэт металлын нийлүүлэлтээ зогсоох, БНХАУ-д үйл ажиллагаа явуулж буй АНУ-ын компаниудын гэрээ, хэлцэлд хориг тавих зэрэг арга хэмжээ авахыг анхааруулж байна. Ийнхүү худалдааны зөрчилдөөн даамжирч, тодорхой бус байдал үргэлжилбэл БНХАУ-ын эрэлт болон түүхий эдийн үнээр дамжин манай эдийн засагт үзүүлэх нөлөөллийг авч үзэж байна.

Гадаад эрэлтийн суваг: АНУ болон БНХАУ харилцан импортын тариф тогтоож, тарифын хувиа нэмэгдүүлэх нь хоёр орны гадаад худалдааны эргэлт болон экспортыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй. Энэ¹¹ нь нэг талаас дэлхийн эдийн засгийн өсөлтийг удаашруулах бол нөгөө талаас дэлхийн зах дээрх түүхий эдийн эрэлт, үнийг бууруулж болзошгүй¹². БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, түүхий эдийн үнэ буурах нь нүүрс, төмрийн хүдэр, зэс, газрын тос зэрэг Монголын экспортын голлох бүтээгдэхүүнээс олох орлогод сөргөөр нөлөөлөх, уул уурхайн салбарыг дагасан тээвэр, боловсруулах болон худалдааны салбаруудын өсөлтөд шууд нөлөөлөхөөс гадна, санхүүгийн салбарт чанаргүй зээл нэмэгдэх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Экспорт болон эдийн засгийн идэвхжил саарах нь улсын төсвийн татварын орлогыг бууруулах бол гадаад худалдаан дээр ирэх сөрөг нөлөөгөөр нийт төлбөрийн тэнцэл муудна. Төлбөрийн тэнцлийн алдагдал өсч, төгрөгийн ханш сулрах дарамт нэмэгдэх нь хэрэглээний сагсан дахь импортын барааны үнээр дамжин инфляцид нөлөөлнө. Мөн эдийн засгийн идэвхжил саарснаар зээлийн эрэлт буурч, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэхтэй холбоотойгоор банкуудын зээлийн эх үүсвэр хомсдож, мөнгөний нийлүүлэлт болон зээлийн өсөлтийг хумих нөлөө үзүүлэхээр байна.


¹¹ 5-р сард импортын тарифууд нэмэгдсэн нөлөөгөөр БНХАУ-ын өсөлт суурь төсөөллөөс 2019-20 онд 0.5-1.0 хувиар буурах тооцооллыг ОУВС-гаас хийсэн бол олон улсын “Рубини” агентлаг БНХАУ-ын өсөлтийг 2019 онд 0.25 хувь, 2020 онд 0.4 хувиар буурах, АХБ БНХАУ-ын өсөлтийг 2019 онд 0.3 хувь, 2020 онд 0.5 хувиар тус тус буурахаар тооцоолж байна.

¹² Азийн Хөгжлийн Банкны судалгаа (2016)-аар БНХАУ-ын аж үйлдвэрлэл 1 хувиар буурахад эхний 3 улирлын нийлбэр нөлөөгөөр нүүрсний үнэ 11.5 хувиар, зэсийн үнэ 7 хувиар, газрын тосны үнэ 7 хувиар, төмрийн хүдрийн үнэ 4.5 хувиар тус тус буурдаг гэсэн тооцоолол хийжээ.

Зураг 24. АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөний цаг хугацааны тойм



Зураг 25. Худалдааны зөрчилдөөний БНХАУ-ын өсөлт, түүхий эдийн үнээр дамжин манай эдийн засагт үзүүлэх нөлөө, дамжих суваг



Хөрөнгийн урсгалын суваг: Худалдааны зөрчилдөөний эрсдэл, тодорхой бус байдал даамжирснаар хөгжиж буй орнуудын хөрөнгийн үнэ огцом унах, хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдэх тохиолдлууд өнгөрсөн нэг жилийн хугацаанд ажиглагдлаа¹³. Хөрөнгийн урсгал татарч, бонд, хувьцааны үнэ унах нь эдгээр орон дахь хөрөнгө оруулалт саарах, бүтээн байгуулалт удаашрах, ханш хэлбэлзэх, улмаар эдийн засгийн өсөлт удаашрах зэрэг сөрөг үр дагавруудад хүргэж болзошгүй байна. Харин манай орны хувьд Оюу толгойн ГШХО харьцангуй тогтвортой үргэлжилнэ, хөрөнгийн зах дахь гадаадын хөрөнгө оруулагчдын эзлэх хувь бусад орнуудтай харьцуулахад бага тул хөрөнгийн урсгалын суваг төдийлөн хүчтэй биш гэж таамаглаж байна.

13 Хөгжиж буй орнуудын бонд, хувьцааны үнэ унах, ханш сулрах хандлага 2018 оны 3-р сард ган, хөнгөн цагааны татвар нэмэх үеэр ажиглагдсан. Мөн 2019 оны 5-р сард худалдааны маргаан хурцадсаны дараа эрчимтэй хөгжиж буй орнуудын хувьцааны үнэ 8 гаруй хувиар буурч, нэг долоо хоногийн дотор 10 тэрбум ам.долларын хөрөнгө хөгжиж буй орнуудаас гадагшилжээ.


V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх улирлуудаас саарч, 2019 оны II улирлын байдлаар 16.6 хувьд хүрлээ. Гадаад валютын хуримтлал, банкнаас аж ахуйн нэгжид олгох бизнесийн зээл мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон бүрдүүлсэн хэвээр байна. Харин иргэдийн хэрэглээний зээл болон ЗГ-ын банкны системээс авах цэвэр зээлийн дүн буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад нөлөөлжээ. Өмнөх жилтэй харьцуулахад экспортын орлого нэмэгдэж, импортын өсөлт буурсан, уул уурхайн хөрөнгө оруулалт, дотоодын компаниудын гадаад зээл, бондын эх үүсвэрийн нөлөөгөөр гадаад валютын хуримтлал нэмэгдлээ. Эдийн засгийн өсөлттэй уялдан төсвийн орлого нэмэгдсэн боловч төсвийн зардлын гүйцэтгэл 2019 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан дүнгийн 41 хувьтай тэнцэж байгаа нь ЗГ-аас банканд байршуулсан эх үүсвэрийг нэмэгдүүлж, цэвэр зээлийн дүнг бууруулсан.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эх үүсвэр талаас төгрөгийн харилцах, хадгаламж голлон бүрдүүлж байна. Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар нэмэгдсэний 14 нэгж хувийг төгрөгийн эх үүсвэр бүрдүүллээ. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн төгрөгийн эх үүсвэр нэмэгдэж, банкны систем дэх эх үүсвэрийн долларжилт буурах нь санхүүгийн системийн эрсдэл даах чадвар, тогтвортой байдлыг дэмждэг.

Зураг 26. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /актив/



Зураг 27. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /пассив/




Эх сурвалж: Монголбанк


Иргэдийн хэрэглээний зээлийн хэт өсөлтийг сааруулах макро зохистой бодлогын нөлөөгөөр хэрэглээний зээлийн өсөлт саарч, 2019 оны II улиралд 24.9 хувьд хүрлээ. Ингэснээр хэрэглээний зээлийн үлдэгдэл оны эхнээс 200 орчим тэрбум төгрөгөөр буюу 4 хувиар буураад байна. Нийт зээл өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар нэмэгдсэний 7 нэгж хувийг хэрэглээний зээл, 8.7 нэгж хувийг бизнесийн зориулалттай зээл бүрдүүлж байна. Хэрэглээний

зээл буурч байгаа үед бизнесийн зээл олголт тогтвортой нэмэгдэж байгаа нь дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Зураг 28. Зээлийн жилийн өсөлт, салбаруудын бүрэлдэхүүнээр



Зураг 29. Бизнесийн, хэрэглээний зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 11. Мөнгөний үзүүлэлтүүд (суурь төсөөлөл)

Мөнгөний тойм	(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)						2020
	2017	2018	2019				
	Q4	Q4	Q1	Q2	Q3	Q4	
	Гүйцэтгэл			Суурь төсөөлөл			
М2 мөнгө	15861	19475	19700	20229	21118	22629	26032
М1 мөнгө	2826	4031	3667	4104	3938	4219	4875
Банкнаас гадуурх мөнгө	612	670	609	653	670	718	921
Харилцах ₮	2214	3360	3058	3452	3268	3502	3954
Бараг мөнгө	13035	15444	16033	16125	17180	18409	21157
Хадгаламж ₮	8622	10156	11148	10936	11340	12151	13965
Хадгаламж \$	2532	3020	2897	2933	3045	3263	3750
Харилцах \$	1881	2268	1988	2256	2794	2994	3441
Гадаад цэвэр актив	-1252	249	1018	1952	1469	2325	1364
Төв банкны	2283	3892	4014	5131	3867	5048	3736
Арилжааны банкны	-3536	-3643	-2997	-3180	-2397	-2723	-2371
Дотоод цэвэр актив	17114	19226	18682	18278	19649	20304	24668
Дотоодын цэвэр зээл	17203	20194	19913	19730	20153	20451	22774
ЗГ-ын цэвэр зээл	-77	-771	-1199	-1834	-2341	-3052	-3576
Төв банк	-1111	-177	-492	-982	-1400	-2244	-2367
Арилжааны банкууд	1034	-594	-708	-852	-941	-809	-1208
ЗГ-аас авах авлага	2649	1519	1501	1549	1462	1444	1184
ЗГ-ын хадгаламж	-1615	-2112	-2209	-2401	-2403	-2252	-2392
Банк бусаас авах авлага	17280	20965	21112	21564	22494	23504	26350
Зээл+ИЗББ	16173	20060	20232	20923	21922	22936	25800
Үүнээс зээл	13615	17226	17462	18220	19138	20071	22611
Хэрэглээний зээл	3597	5572	5481	5419	5555	5633	6281
Бизнесийн зээл	12576	14488	14751	15504	16367	17303	19518
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	3665	3739	3650	3344	3356	3433	3739
Бусад цэвэр зүйл	-90	-968	-1231	-1452	-1204	-1148	-1394
Төв банк							
Нөөц мөнгө	3943	4908	4200	4776	4647	4947	5287
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	906	969	898	937	928	979	1127
Арилжааны банкуудын харилцах, хадгаламж	3036	3939	3302	3839	3719	3968	4160
Гадаад цэвэр актив	2283	3892	4014	5131	3867	5060	3623
Дотоод цэвэр актив	1659	1016	185	-355	781	-101	1551
ЗГ-ын цэвэр зээл	-1111	-178	-492	-982	-1400	-2244	-2367
ЗГ-аас авах авлага	479	375	375	375	349	339	322
ЗГ-ын ТБ дахь харилцах хадгаламж	-1590	-553	-867	-1357	-1750	-2583	-2689
Хөгжлийн банкны цэвэр зээл	39	59	58	-114	55	54	54
Банкинд олгосон зээл	1270	937	660	743	767	934	745
ББ авлага (МИК, ХДК, ДАЧЭБ)	2945	3118	3054	2974	3004	3073	3347
Хасах нь: ТБҮЦ	3444	5006	4668	5217	4192	4380	2679
Бусад цэвэр зүйл	2183	1419	1545	1288	1434	1349	1337
Өөрийн хөрөнгө	2816	1871	1937	1726	1875	1791	1790
Бусад	-633	-452	-391	-437	-441	-442	-452
Меморандум үзүүлэлтүүд:							
М2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	30.5	22.8	22.6	16.6	17.8	16.2	15.0
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	28.6	24.5	44.1	29.9	24.2	0.8	6.9
М2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	4.02	3.97	4.69	4.24	4.54	4.57	4.92
(Зээл+ИЗББ) жилийн өөрчлөлт (%)	10.9	24.3	20.9	15.8	15.1	14.3	12.5
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	9.6	26.5	23.5	18.3	17.1	16.5	12.7
Хэрэглээний зээлийн жилийн өөрчлөлт (%)	51.5	54.9	37.2	24.9	14.6	1.1	11.5
Бизнесийн зээлийн жилийн өөрчлөлт (%)	-0.5	16.1	18.0	15.8	15.2	19.4	12.8
Зээл/ДНБ	0.58	0.62	0.60	0.60	0.61	0.62	0.63
Мөнгөний эргэлтийн хурд	1.76	1.66	1.70	1.71	1.71	1.65	1.58
Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	27896	32307	33479	34603	36027	37241	41116
Нэрлэсэн ДНБ-ий жилийн өсөлт (%)	16.5	15.8	16.0	14.3	15.1	15.3	10.4
Жилд шилжүүлсэн бодит ДНБ-ий өсөлт (%)	5.3	7.3	7.7	7.6	7.7	7.0	5.6
Жилийн дундаж инфляци (%)	7.7	8.6	7.8	8.8	9.7	8.0	7.2

5.2. Орон сууцны зээлийн хөтөлбөр

Монголбанк орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2013 оноос Засгийн газартай хамтран хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд нийт 4.4 их наяд төгрөгийн санхүүжилтийг зорилтот бүлгийн зээлдэгчдэд олгоод байна.

Зураг 30. Орон сууцны ипотекийн зээлийн мэдээлэл 2012-2018 он



Олон улсын валютын сан (ОУВС)-тай хамтран хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийн хөтөлбөр болон бусад төсвийн шинжтэй төсөл хөтөлбөрөөс Монголбанкийг гаргах шаардлагыг 2017 оны 5 дугаар сараас тавьсан боловч ипотекийн зээлийн хөтөлбөрийн нийгмийн ач холбогдлыг харгалзан Монголбанк 2019 оныг дуустал тус хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэхээр олон улсын байгууллагуудтай тохиролцсон болно.

Монголбанк 2018 онд ипотекийн зээлийн хөтөлбөрийг өөрийн өмчлөлийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын үндсэн төлбөрийн орлогоор сар бүр 16 тэрбум төгрөг, нийт 191.36 тэрбум төгрөгийг банкуудаар дамжуулан олгосон байна. Түүнчлэн Засгийн газартай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Улсын төсөвт тусгасан 120 тэрбум төгрөгийн Засгийн газрын эх үүсвэрийг банкуудад олгосон бөгөөд Монголбанк болон Засгийн газрын эх үүсвэрээс 2018 онд 310 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр 4,700 орчим иргэнд 8 хувийн ипотекийн зээлийг олгожээ.

УИХ-ын байнгын хорооны 35 дугаар тогтоолоор орон сууцны хөтөлбөрийг Засгийн газарт бүрэн шилжүүлэх хүртэл Монголбанк өөрийн өмчлөл дэх ИЗББ-ын үндсэн төлбөрийн орлогоор, Засгийн газар тухайн жилийн улсын төсөвт тусгасан хэмжээгээр санхүүжүүлэх, Засгийн газрын эх үүсвэрийн хүүг 1 хувь хүртэл бууруулж, банкуудын өөрийн эх үүсвэрийг хөтөлбөрийн санхүүжилтэд татан оролцуулах чиглэлийг Монголбанк, Засгийн газарт өгсөн байна. Үүний дагуу Засгийн газраас эх үүсвэрийн хүүг 1 хувь болгон

бууруулж, банкууд өөрийн эх үүсвэрээс 8 хувийн хүүтэй ипотекийн зээлийг санхүүжүүлэх, санхүүжилтийн бүтцийг богино хугацаанд бүрэн шинэчлэн, холбогдох өөрчлөлтүүдийг эрх зүйн актуудад тусган санхүүжилтийг олгоод байна.

Хөтөлбөрийн санхүүжилтийн шинэ бүтэц хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Монголбанкны эх үүсвэрээс 200 орчим тэрбум төгрөг, Засгийн газар болон банкуудын өөрийн эх үүсвэрээс нийт 230 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг ипотекийн 8 хувийн зээлд олгох боломжтой болсноор 2019 онд нийт 430 тэрбум төгрөгийн санхүүжилтийг иргэдэд олгохоор байна. Улмаар 2019 онд шинээр олгох ипотекийн зээлийн хэмжээ 2018 онтой харьцуулахад 120 тэрбум төгрөг буюу 40 орчим хувиар, зээлдэгчийн тоо 1.4 дахин нэмэгдэх юм.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны эхний 6 сарын байдлаар нийт 210 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2,937 иргэнд олгоод байна. Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 95 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,294 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 55 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 882 иргэнд, банкууд өөрийн эх үүсвэрээс 60 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 761 иргэнд олголоо. Олон улсын байгууллагуудтай тохиролцсоны дагуу хөтөлбөрийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Засгийн газарт бүрэн шилжүүлэх юм.


5.3. Мөнгөний зах, хүүний түвшин

Монголбанк нь инфляцийг онилох бодлогын хүрээнд банк хоорондын захын богино хугацаат хүүг үйл ажиллагааны зорилт болгон ашигладаг. Банкууд хадгаламж татах эсвэл зээл олгох шийдвэр нь бусад богино хугацаат хүүгээр дамжин урт хугацаат хүүнээс хамаарч байдаг тул төв банк нээлттэй захын үйл ажиллагаагаар дамжуулан банк хоорондын захын хөтөч хүү болох бодлогын хүүг тодорхойлж, мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг. Цаашлаад мөнгөний бодлого нь богино хугацаат хүүгээр дамжуулан инфляцийг тогтворжуулах, тодорхой бус байдлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэдэг байна. Иймд Монголбанкны хувьд банк хоорондын захын богино хугацаат хүүг бодлогын хүүний орчимд тогтворжуулах нь өндөр ач холбогдолтой юм. Монголбанк банк хоорондын захын идэвхжлийг нэмэгдүүлэх, богино хугацаат хүүний хэлбэлзлийг бууруулах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор сүүлийн жилүүдэд бодлогын олон арга хэмжээг хэрэгжүүллээ.


Банк хоорондын зах (БХЗ)-ын хүүний хэт хэлбэлзлээс сэргийлэх зорилгоор Монголбанк хүүний коридор системийг 2013 онд нэвтрүүлж, тэгш хэмт хүүний коридор системийг 2017 оны 6 сард буцаан ашиглаж эхлэв. Энэхүү бодлогын арга хэмжээ нь банк хоорондын захын богино хугацаат хүүг бодлогын хүү орчимд тогтворжиход чухал нөлөөтэй байлаа. Тодруулбал

2018 онд БХЗ-ын жигнэсэн дундаж хүү бодлогын хүүнээс хазайх хазайлт -0.04 нэгж хувь, 2019 оны эхний хагас жилд 0.08 нэгж хувь байсан бөгөөд БХЗ-ын хүү бодлогын хүү орчимд хэлбэлзэж байна (Зураг 31).

Зураг 31. БХЗ-ын хүү



Зураг 32. БХЗ-ын арилжааны хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

БХЗ дээрх хэлцлийн хэмжээ нэмэгдэж, идэвхжил сайжирснаар хүүний шилжих механизмын үр нөлөөг дээшлүүлдэг. Монголбанк БХЗ-ын идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 4 дүгээр сараас эхлэн Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны хугацааг уртасгаж, 28 хоног болгосны зэрэгцээ арилжааны давтамжийг бууруулав. Бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс өмнө (2017-2018.03) БХЗ-д сард дунджаар 745 тэрбум төгрөгийн хэлцэл хийгддэг байсан бол дээрх арга хэмжээний дараа 1,829 тэрбум төгрөг болж, хэлцлийн хэмжээ 2.5 дахин нэмэгджээ. Монгол улсын хувьд БХЗ дээр хийгдэж буй овернайт зээл, хадгаламж, репо хэлцэл болон үнэт цаасны хоёрдогч захын арилжааны сүүлийн 3 жилийн дунджаас дүгнэхэд нийт хэлцлийн 31.6 хувийг овернайт зээл, 40.2 хувийг төв банкны үнэт цаасны хэлцэл, 21.7 хувийг репо хэлцэл тус тус эзэлж байна (Зураг 32). Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад банк хоорондын барьцаат бус хэлцлийн нийт хэлцэлд эзлэх хэмжээ буурч, ТБҮЦ болон ТБҮЦ-аарх хэлцлийн эзлэх хэмжээ өсчээ.

ТБҮЦ-ны хугацааг уртасгаж, арилжааны давтамжийг бууруулснаар БХЗ-ын идэвхжил нэмэгдэж, хэлцлийн тоо өссөн байна (Хүснэгт 12). Бодлогыг хэрэгжүүлсний дараа БХЗ дээрх сарын дундаж хэлцлийн тоо 2018 оны 11 дүгээр сар хүртэл хугацаанд дунджаар 52.6 нэгж хувиар, 2018 оны 12 дугаар сараас 2019 оны 06 дугаар сар хүртэл хугацаанд дунджаар 48.6 нэгж хувиар тус тус өсөв. Ялангуяа БХЗ дээрх репо болон ТБҮЦ-ны хэлцлийн тоо нэмэгдэж, овернайт хэлцлийн тоо тус тус буурсан байна. Үүнээс дүгнэхэд бодлогын өөрчлөлт нь банкуудын ТБҮЦ-тай холбоотой арилжаа хийх сонирхлыг нэмэгдүүлжээ.

Хүснэгт 12. БХЗ дээрх сарын дундаж хэлцлийн тоо, 2017-2019.06


Хэлцлийн төрөл /Он	2017.01-2018.03	2018.04-2018.11	2018.12-2019.06
Репо	10.1	32.4	60.3
ТБҮЦ	21.2	41.4	56.9
Овернайт	39.6	38.8	50.0
Хадгаламж	9	9.3	13.9
Нийт	79.9	121.9	181.1

Эх сурвалж: Монголбанк

Монголбанк БХЗ-ын бүтцийн илүүдэл нөөцийг бууруулж, БХЗ-ыг идэвхжүүлэх, барьцаат хэлцлийг хөгжүүлэх зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 196 хоногтой ТБҮЦ-ыг арилжаалж эхлэв. Засгийн газрын үнэт цаасны арилжаа 2017 оны 11 дүгээр сараас эхлэн зогссон учраас урт хугацаат ТБҮЦ-ыг арилжаалах нь төгрөгийн өгөөжийн муруйг бий болгож, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн байна. Бодлогыг хэрэгжүүлснээр банк хоорондын хэлцлийн жигнэсэн дундаж хугацаа 15 хоног болж уртасжээ. ТБҮЦ-ны үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 5,252.2 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 80.1 хувийг 28 хоногтой ТБҮЦ, 19.9 хувийг 196 хоногтой ТБҮЦ тус тус эзэлж байна.

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанк банкуудыг тодорхой хэмжээний бэлэн нөөцийг Төв банкин дахь харилцах дансандаа төвлөрүүлэхийг шаарддаг. Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 3 дугаар сарын хуралдаанаар банкны төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН) 10.5 нэгж хувь, гадаад валютын ЗБН 12 нэгж хувиар тогтоосон байна. Түүнчлэн макро зохистой бодлогын хүрээнд ЗБН-ийн шинэчилсэн журмыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж эхлэв. Журмыг шинэчлэн баталснаар тус хэрэгслийг зөвхөн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, мөнгөний бодлогын зорилгоор ашиглахаас гадна макро зохистой бодлогын зорилгоор ашиглах боломж нээгдсэн юм. Энэхүү бодлого хэрэгжиж эхэлснээр банк хоорондын захын илүүдэл нөөц 167 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 33. Хадгаламж, зээлийн хүү




Эх сурвалж: Монголбанк

Хадгаламж, зээлийн хүү: Төгрөгийн зээлийн хүү буурсантай холбоотой зээл болон хадгаламжийн хүүний зөрүү багасах хандлагатай байна (Зураг 36). Өнгөрсөн 3 жил (2016-2018)-ийн дундажтай харьцуулахад дээрх зөрүү 0.6 нэгж хувиар, өмнөх оны 6 дугаар сартай харьцуулахад 0.7 нэгж хувиар буурчээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) сүүлийн 6 сард дунджаар 0.04 нэгж хувиар, хадгаламжийн ЖДХ 0.10 нэгж хувиар буурсан байна.


5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2019 он гарсаар харьцангуй тогтвортой байна. Тодруулбал, 2019 оны 1 дүгээр улиралд төгрөгийн ам.доллартой харьцах ханш өмнөх улирлаас 0.5%-иар чангарсан бол, 2 дугаар улиралд 1.0%-иар суларч 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2657.76 төгрөгт хүрч, оны эхнээс 0.5%-иар суларсан байна. Тухайлбал, 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.226%-иар чангарч, 0.280%-иар суларч, өдрийн дундаж хэлбэлзэл 0.004% байв. Мөн тайлант хугацааны 97%-д төгрөгийн ам.доллартой харьцах ханш $\pm 0.137\%$ -ийн интервалд хэлбэлзсэн байна. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.004% байгаа нь 2018 оны мөн үетэй харьцуулбал 0.008 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Зураг 34. Ханшийн өдрийн хэлбэлзэл



Зураг 35. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк



Төлбөрийн тэнцлийн бараа, үйлчилгээний худалдааны данс 2019 оны эхний хагас жилийн байдлаар 5.5 сая ам.долларын алдагдалтай байж өмнөх оны мөн үеэс 56.0 сая ам.доллароор сайжирснаас гадна макро зохистой бодлого хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор банкуудын 2019 оны 1 дүгээр улиралд олгосон зээл өмнөх улирлаас 2.9 их наяд төгрөгөөр буурсан нь валютын эрэлт, цаашлаад импортын эрэлтийг нэмэгдүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ. Түүнчлэн ГВАН 2019 оны 5 дугаар сарын байдлаар 3.7 тэрбум ам.долларт хүрсэн, Монгол Улсын хувьд энэ онд хүлээгдэж буй томоохон зээлийн эргэн төлөлт байхгүй, ХНБ бодлогын хүүгээ өсгөхгүй хэмээн мэдэгдсэн зэрэгтэй холбоотойгоор валютын захад оролцогчдын хүлээлт өмнөх оныхтой харьцуулахад сайжирсан байв.

ШИГТГЭЭ 5. ВАЛЮТЫН ХАНШИЙН ТОГТВОРЖУУЛАХ НӨЛӨӨ

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт гадаад худалдаа болон санхүүгийн сувгуудаар төлбөрийн тэнцэлд нөлөөлж, улмаар эдийн засгийн бусад үзүүлэлтэд нөлөөлнө.

Ханшийн уян байдал нь гадаад худалдааны тэнцэлд богино хугацаанд шууд мэдрэгдэхгүй ч дунд урт хугацаанд эдийн засагт шаардлагатай тохиргоог хийж, эерэг үр дүнг авчирдаг¹⁴. Ханш сулрах үед аялал жуулчлал, импортын орц багатай үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг дотоод валютаар бүтээгдэхүүн үйлчилгээгээ борлуулдаг, худалдаалагдах салбаруудын өрсөлдөх чадварт эерэг нөлөөтэй. Түүнчлэн хөрөнгө оруулалтын бараа болон түүхий эд материалын импортын орц өндөр манай улсын хувьд төгрөгийн ханш сулрахад импортын эрэлт, хөрөнгө оруулалтын өртгөөр дамжин худалдааны тэнцлийг тогтворжуулах нөлөө үзүүлнэ. Сүүлийн 10 орчим жилийн хугацаанд гадаад санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, санхүүгийн долларжилт санхүүгийн бус ААН, банк, ЗГ-ын түвшинд нэмэгдсэн тул төгрөгийн ханш сулрах нь активын дахин үнэлгээ болон дахин санхүүжилтийн өртгөөр дамжин худалдааны тэнцлийг тогтворжуулах нөлөө хүчтэй болж байна. Харин гадаад валютаар борлуултаа хийдэг экспортын компаниудын хувьд үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх замаар ашигт ажиллагаанд эергээр нөлөөлдөг¹⁵.

Зураг 36. Импортын үнийн мэдрэмж **Зураг 37. Экспортын үнийн мэдрэмж /түүвэр доторх үнэлгээ*/**



**Түүврийн хэмжээг улирал бүрээр сунган регресс үнэлэх байдлаар импорт болон экспортын үнийн мэдрэмжийн үнэлэгдсэн коэффициентууд хугацааны туршид хэр тогтвортой байгаа эсэхийг дээрх зурагт шинжлэв.*

Эх сурвалж: Б.Дуламзаяа (2018)

¹⁴ The IMF, “2019 External Sector Report: The Dynamics of External Adjustment”, July 2019.

¹⁵ Gita Gopinath (2017), “Rethinking International Macroeconomic Policy”, October 2017, Harvard and NBER.

Монгол улсын хувьд төгрөгийн ханш сулрах нь гадаад худалдааны тэнцлийг дунд, урт хугацаанд сайжруулдгийг эмпирик судалгааны ажлын үр дүнгүүд харуулдаг. Тухайлбал, Б.Дуламзаяа (2018)¹⁶ гадаад худалдаа, ДНБ, гадаад болон дотоод үнэ, экспорт, импортын үнийн 2002-2018 оны тоон мэдээлэлд үндэслэн, урт хугацааны коинтеграц бүхий ARDL загварыг ашиглаж, Монгол улсын гадаад худалдааны үнийн мэдрэмжийг тооцоолсон. Судалгааны үр дүнгээс харахад экспорт болон импортын үнийн мэдрэмжүүд харьцангуй сул бөгөөд импортын үнийн мэдрэмж -0.65, экспортын үнийн мэдрэмж -0.50 байна. Гэхдээ импорт болон экспортын үнийн мэдрэмжийн абсолют нийлбэр нэгээс их (-1.15) байгаа нь Маршал-Лернерийн нөхцөл манай оронд хангагддаг буюу төгрөгийн ханш сулрах нь гадаад худалдааны алдагдлыг засварладаг гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Энэхүү дүгнэлт нь Д.Ган-Очир (2018)¹⁷ 2000-2011 оны тоон мэдээлэлд үндэслэн бодит ханшийн гадаад худалдаанд үзүүлэх нөлөөг VECM загвараар тооцож, гадаад худалдааны тэнцлийн бодит ханшаас хамаарах урт хугацааны мэдрэмжийг -1.78 гэж тодорхойлсон судалгааны үр дүнтэй нийцтэй байна.

Ханшийн уян байдал нь ийнхүү шокийг шингээгчийн үүргийг гүйцэтгэж, гадаад худалдааны тэнцлийг сайжруулах чухал хэрэгсэл болно. Харин огцом сулралт нь худалдааны сувгаар бий болох эерэг нөлөөг давсан сөрөг нөлөөг үүсгэх эрсдэлтэй тул үүнээс сэргийлэх нь чухал юм (Does the financial channel of exchange rates offset the trade channel? (BIS Quarterly Review, Dec 2016). Хөгжиж буй орнуудын хувьд ханшийн хэт сулралт хөрөнгийн гарах цэвэр урсгалыг нэмэгдүүлэх, өрийн дарамтыг нэмэгдүүлэх зэрэг эрсдэлийг үүсгэж болзошгүй. Ийм нөхцөл байдлаас сэргийлэхэд уян хатан ханш чухал бөгөөд, худалдааны тэнцэл дээр шаардлагатай тохиргоо хийгдэх нь урсгал тэнцэлд эергээр нөлөөлж, ханшийн огцом сулралт үүсгэх эрсдэлийг бууруулна. Хөгжиж буй орнууд бүтцийн бодлого, сангийн болон мөнгөний бодлого, макро зохистой бодлогыг хавсран ханшийн зохистой бодлогыг хэрэгжүүлж байна¹⁸.

¹⁶ Б.Дуламзаяа (2018), “Монгол Улсын экспорт, импортын эрэлт: Орлого болон үнээс хамаарах мэдрэмж”, Мөнгө Санхүү Баялаг Сэтгүүл 2018№10 95-109.

¹⁷ Gan-Ochir, Doojav. (2018). “The Effect of Real Exchange Rate on Trade Balance in a Resource-Rich Economy: The Case of Mongolia.” *Foreign Trade Review* 53(4) 1–14.

¹⁸ BIS, “Monetary policy frameworks in EMEs: inflation targeting, the exchange rate and financial stability”, June 2019, *BIS Annual Economic Report*

VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ


6.1. Төлбөрийн тэнцэл

Энэ оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны ашиг 64 хувиар өсч 1,071.8 сая ам.долларт хүрсэн болон урсгал ба хөрөнгийн дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 17 хувиар буурч 683.6 сая ам.долларт хүрснээр нийт төлбөрийн тэнцэл 456¹⁹ сая ам.долларын ашигтай гарсан. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 627.9 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм.

Зураг 38. Төлбөрийн тэнцэл




Зураг 39. Урсгал ба хөрөнгийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн данс. Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал оны эхний 6 сард өмнөх оны мөн үеэс 138.7 сая ам.доллараар буурахад барааны дансны ашиг 43 хувиар буюу 256.5 сая ам.доллараар өсч, үйлчилгээний дансны алдагдал 9 хувиар буюу 83.7 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 40. Урсгал тэнцэл/Нэрлэсэн ДНБ




¹⁹ Төлбөрийн тэнцлийн алдаа болон орхигдуулгын дүн 23.5 сая ам.долларыг оруулан тооцсон.

Дотоодын эдийн засаг сэргэсэн, уул уурхайн бүтээн байгуулалтууд өрнөсөн, импорт өссөнөөс шалтгаалан манай улсын урсгал дансны алдагдал нэмэгдэж 2012 онд ДНБ-ий 44 хувьд хүрч байсан. Харин барааны гадаад худалдаа ашигтай гарч эхэлснээр урсгал тэнцлийн алдагдал буурч 2014 онд ДНБ-ий 16 хувь, 2015 онд 8 хувь, 2016 онд 6 хувь, 2017 онд 10 хувь, 2018 онд 34 хувийг эзэлсэн бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 26 хувьд хүрээд байна.


Гадаад худалдаа тэлж байна. Энэ оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 8%-иар буюу 492 сая ам.доллараар өсч 6,833 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 10%-иар буюу 358 сая ам.доллараар, импорт 5%-иар буюу 135 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 223 сая ам.доллараар өсч 1,045 сая ам.долларын ашигтай байна.

Энэ оны эхний 6 сард газрын тосны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурсан, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ өссөн, нүүрс болон зэсийн экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд байснаар гол түүхий эдийн хувьд биет хэмжээний өсөлттэй байв. Харин дэлхийн зах дээрх түүхий эдийн үнэ сэргэж нүүрс болон төмрийн хүдрийн хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс харгалзан 10 хувь, 32 хувиар тус тус өссөнөөр нүүрсний экспортын орлого 136 сая ам.доллараар, төмрийн хүдрийн экспортын орлого 96 сая ам.доллараар нэмэгдсэн нь экспортын өсөлтийн дийлэнх хувийг тайлбарлаж байна. Харин импортын хувьд уул уурхайн идэвхжилтэй холбоотой хөрөнгө оруулалтын шинж чанартай барааны импорт гол өсөлтийг бүрдүүлж байна. Тухайлбал, энэ оны эхний 6 сард машин тоног төхөөрөмж, эд ангийн импорт 108 сая ам.доллараар буюу өмнөх оны мөн үеэс 15 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 35 сая ам.доллараар буюу 7 хувиар тус тус нэмэгдсэн. Түүнчлэн, эдийн засаг идэвхжиж, дотоод эрэлт нэмэгдсэнээр хэрэглээний бүтээгдэхүүний импорт тэр дундаа суудлын машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 55 сая ам.доллараар буюу 25 хувиар өсчээ.

Зураг 41. Барааны гадаад худалдаа



Зураг 42. Үйлчилгээний гадаад худалдаа



Эх сурвалж: Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал буурав. Үйлчилгээний дансны алдагдал 2019 оны эхний 6 сард өмнөх оны мөн үеэс 83.7 сая ам.доллараар буурчээ. Үүнд экспорт, импортын тээврийн үйлчилгээний зардал болон бизнесийн үйлчилгээний дансны алдагдал буурсан нь голлон нөлөөлөв.

Анхдагч орлогын дансны алдагдал өсөв. Анхдагч орлогын дансны алдагдлын хэмжээ 2019 оны эхний 6 сард 754.8 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 30 хувиар буюу 175.4 сая ам.доллараар буурсан. Анхдагч орлогын дансны алдагдал өсөхөд гадаад зээлийн хүүгийн төлбөр 144.7 сая ам.доллараар болон орлогын дахин хөрөнгө оруулалт 108.6 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Санхүүгийн дансны ашиг өслөө. Санхүүгийн дансны ашиг 2019 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 64 хувиар өсч, 1,071.8 сая ам.долларт хүрэв. Үүнд багцын хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 189 хувиар буюу 758.5 сая ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн. Тодруулбал, Монгол Улсын Хөгжлийн банк 500 сая ам.долларын бондыг, Монголын Ипотекийн Корпорац 300 сая ам.долларын бондыг тус тус олон улсын зах зээл дээр амжилттай арилжаалснаар санхүүгийн дансны ашиг өсөв.

Зураг 43. Санхүүгийн данс



Зураг 44. Гадаад валютын нөөц



Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын албан нөөц. 2019 оны эхний 6 сард төлбөрийн нийт тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын албан нөөц нэмэгдэж 6 дугаар сарын эцэст ГВАН 4,011.4 сая ам.долларт хүрсэн нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 8.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

ШИГТГЭЭ 6. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ВАЛЮТЫН УРСГАЛЫН ТОЙМ: 2018 ОН

Энэхүү шигтгээнд валютын орох гарах урсгалыг төлбөрийн тэнцлийн өндөр дүнтэй гол дансуудаар ангилан тоймлов. Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2018 онд 141.7 сая ам.долларын алдагдалтай байсан бөгөөд нийт орох урсгал 12,746 сая ам.доллар, гарах нийт урсгал 13,176 сая ам.доллар байлаа.

Гадаад валютын орох урсгал: Манай улсын гадаад валютын орох урсгал экспортын орлого, үйлчилгээний орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), гадаад бондуудын арилжаа, болон гадаад зээл гэсэн голлох 5 сувгаар тэтгэгджээ. Тодруулбал, экспортын орлого 6,557 сая ам.доллар байсныг чулуун нүүрс, зэсийн баяжмал, газрын тос, төмрийн хүдэр, алт, ноолуур зэрэг экспортын голлох бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна. Үйлчилгээний орлого 1,112 сая ам.долларт хүрэхэд аялал жуулчлал, тээврийн болон бизнесийн үйлчилгээний орлого голлон нөлөөлжээ. Санхүүгийн дансны хувьд ГШХО-ын хэмжээ 2,147 сая ам.доллар, Монгол Улсын Хөгжлийн банкны олон улсын зах зээл дээр шинээр арилжаалсан бондын орлогын нөлөөгөөр гадаад бондын орлого 500 сая ам.доллар, гаднаас авч ашигласан зээлийн хэмжээ 2,243 сая ам.доллар байв.

Гадаад валютын гарах урсгал: Монгол Улсын гадаад валютын гарах урсгал импортын төлбөр, үйлчилгээний зардал, гадаад зээл, бондуудын үндсэн болон хүүгийн төлбөр, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулагчдадаа олгож буй ногдол ашгийн төлбөр гэсэн гол 4 хэсгээс бүрдэж байна. Тодруулбал, импорт өмнөх оноос 35 хувиар өсч 2018 онд 5,881 сая ам.долларт хүрсэн нь эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарын идэвхжилтэй уялдаатай байлаа. Үйлчилгээний гадаад төлбөрийн хэмжээ 3,090 сая ам.долларт хүрсэн нь түүхэн өндөр түвшин байлаа. Үүнд аялал, тээврийн үйлчилгээний төлбөр 915 сая ам.доллар, жуулчлалын үйлчилгээний төлбөр 860 сая ам.доллар²⁰, бизнесийн үйлчилгээний төлбөр 794 сая ам.долларт хүрч өссөн нь голлон нөлөөлөв. Түүнчлэн гадаад валютын гарах урсгалын томоохон хэсэг нь гадаад өрийн үйлчилгээнд зарцуулагдаж байна. Гадаад зээл, бондын хүүгийн төлбөрт 926 сая ам.доллар төлсөн бол гадаад бондын үндсэн төлбөрт 267 сая ам.доллар (500 сая ам.долларын Чингис бондын 25%, Дим сам бондын 90%), гадаад зээлийн үндсэн төлбөрт 2,386 сая ам.долларыг тус тус төлжээ. 2018 онд Оюу толгой компани алдагдалтай ажилласан хэдий ч банкууд болон аж ахуйн бусад нэгж ашигтай ажилласнаар хувь нийлүүлсэн хөрөнгө буюу гадаадын хөрөнгө оруулагчдын ногдол ашгийн төлбөр 264 сая ам.доллар байв.

Орох, гарах урсгалын зөрүү ба валютын нөөц

Монгол Улсын гадаад валютын орох гарах урсгалын зөрүүнд хөрөнгийн данс, урсгал шилжүүлэг, худалдааны зээл, бэлэн мөнгө, харилцах, санхүүгийн үүсмэл хэрэгслүүд болон алдаа, орхигдуулгын дансуудын цэвэр урсгалын мэдээг хамруулан авч үзвэл цэвэр урсгалын хэмжээ 135 сая ам.долларын алдагдалтай байгаа нь төлбөрийн тэнцлийн нийт дүнтэй тохирч байна.

Төлбөрийн тэнцлийн алдагдал 2018 онд 141.7 сая ам.доллар байсан хэдий ч тус онд Монголбанкнаас худалдан авч, мөнгөжүүлэн хуримтлуулсан алтны

²⁰ Үүнд гадаадад суралцах боловсролын зардал багтсан.

хэмжээ 592 сая ам.доллараар өссөнөөр гадаад валютын нийт албан нөөц 3,549 сая ам.долларт хүрч өмнөх оноос 541 сая ам.доллараар нэмэгдлээ.

Хүснэгт 13. 2018 оны гадаад валютын урсгалын тойм /сая ам.доллар/

	2018 он			2018 он	
ОРОХ УРСГАЛ	сая \$	%, ДНБ	ГАРАХ УРСГАЛ	сая \$	%, ДНБ
Экспорт	6,557	50%	Импорт	-5,881	-45%
Чулуун нүүрс	2,786	21%	Хөрөнгө оруулалтын бүт.	-2396	-18%
Зэсийн баяжмал	2,012	15%	Хэрэглээний бүтээгдэхүүн	-1643	-13%
Газрын тос	392	3%	Үйлчилгээ	-3,090	-24%
Төмрийн хүдэр	342	3%	Тээврийн	- 915	-7%
Ноолуур	333	3%	Аялал, жуулчлал	- 860	-7%
Үйлчилгээ	1,112	9%	Бизнесийн (техник, худалдаа, зөвлөх)	- 794	-6%
Тээврийн	354	3%	Гадаад зээл, бондын хүүгийн төлбөр	- 926	-7%
Аялал, жуулчлал	445	3%	Хөрөнгө оруулагчийн зээлийн төлбөр	- 224	-2%
Ажилчдын цалин	185	1%	Гадаад бондуудын үндсэн төлбөр	- 267	-2%
ГШХО	2,147	16%	ЗГҮЦ-ны төлбөр	- 138	-1%
Гадаад бондууд	503	4%	Ногдол ашгийн төлбөр	- 264	-2%
Гадаад зээлийн ашиглалт	2,243	17%	Гадаад зээлийн төлбөр	- 2,386	-18%
Засгийн газар	594	5%	Засгийн газар	- 107	-1%
Банкууд	812	6%	Банкууд	- 898	-7%
ААН-үүд, МУХБ	838	6%	ААН-үүд, МУХБ	- 1,381	-11%
НИЙТ	12,746	98%	НИЙТ	- 13,176	-101%

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

6.2. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц


Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2019 оны 1 дүгээр улирлын эцэст -34,356.2 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаадаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадаадад хийсэн хөрөнгө оруулалтаас 34.4 тэрбум ам.доллараар их байна.

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат бусад хөрөнгө оруулалтын дүн 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 6.5 тэрбум ам.доллар байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэхүү үзүүлэлт нь 16 хувиар буюу 901 сая ам.доллараар өссөн бөгөөд үүнд нөөц болон бусад хөрөнгө оруулалтын дансны активын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ. Нийт гадаад активын 56 хувийг гадаад валютын албан нөөц, 31 хувийг бусад хөрөнгө оруулалт, 8 хувийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 4 хувийг багцын хөрөнгө оруулалтын активууд тус тус бүрдүүлж байна.


Хүснэгт 14. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2019 оны 1-р улирлын байдлаар (тэрбум ам.доллар)

А. ГАДААД АКТИВ		6.5	Б. ГАДААД ПАССИВ		40.9
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)		0.5	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)		20.7
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт		0.5	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт		11.3
1.2 Бусад хөрөнгө		0.1	6.2 Бусад хөрөнгө		9.4
2. Багцын хөрөнгө оруулалт		0.3	7. Багцын хөрөнгө оруулалт		5.2
2.1 Хөрөнгийн хувьцаа		0.3	7.1 Хөрөнгийн хувьцаа		0.1
2.2 Өрийн бичиг		0.0	7.2 Өрийн бичиг		5.2
3. Санхүүгийн дериватив		0.0	8. Санхүүгийн дериватив		0.0
4. Бусад хөрөнгө оруулалт		2.0	9. Бусад хөрөнгө оруулалт		15.0
4.1 Худалдааны зээл		0.4	9.1 Худалдааны зээл		0.4
4.2 Зээл		0.2	9.2 Зээл		12.4
4.2.1 Төв банк		0.0	9.2.1 Төв банк		0.3
4.2.2 Засгийн газар		0.2	9.2.2 Засгийн газар		1.4
4.2.3 Банк санхүүгийн байгууллага		0.0	9.2.3 Банк санхүүгийн байгууллага		4.3
4.2.4 Аж ахуйн нэгж		0.0	9.2.4 Аж ахуйн нэгж		6.5
4.3 Бэлэн мөнгө ба харилцах		1.5	9.3 Бэлэн мөнгө ба харилцах		2.2
4.4 Бусад актив		0.0	9.4 Бусад пассив		0.0
5. Нөөц актив		3.7	В. ПОЗИЦ		(34.4)
5.1 Мөнгөжсөн алт		0.7	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)		(20.2)
5.2 Зээлжих тусгай эрх		0.1	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)		(5.0)
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)		0.0	12. Санхүүгийн дериватив (цэвэр)		0.0
5.4 Бэлэн валют ба харилцах		2.4	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)		(12.9)
5.5 Үнэт цаас		0.6	14. Нөөц актив		3.7
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)		0.0			
5.7 Бусад нөөц актив		0.0			

Зураг 45. Гадаад актив



Зураг 46. Гадаад пассив



Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн 40.9 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн мөн үеэс 7 хувиар буюу 2,571 сая ам.доллараар өссөн үзүүлэлт ба үүнд шууд болон багцын хөрөнгө оруулалтын өсөлт голлох нөлөөг үзүүлсэн байна. Нийт гадаад пассивын 51 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 37 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13 хувийг багцын хөрөнгө оруулалтын пассив эзэлж байна. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 55 хувь буюу 11.3 тэрбум ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 45 хувийг буюу 9.4 тэрбум ам.долларыг толгой компаниас авсан зээл эзэлж байна.

6.3. Монгол Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2019 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 29.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,616 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд бусад салбарын гадаад өрийн өсөлт болон шууд хөрөнгө оруулалтын гадаад зээлийн өсөлт голчлон нөлөөлж байна.


Улсын салбар. Засгийн газрын гадаад өр 20 сая ам.доллараар нэмэгдэж 7.3 тэрбум ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 64 сая ам.доллараар буурч 2.07 тэрбум ам.долларт хүрчээ. Энэхүү бууралт нь харилцах хадгаламжийн дансны ханшийн өөрчлөлтөөс бий болсон байна.

Хувийн хэвшил. Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1,661 сая ам.доллараар нэмэгдэж 20.2 тэрбум ам.доллар болсон байна.

Хүснэгт 15. Гадаад өрийн үлдэгдэл /тэрбум \$/ Зураг 47. Гадаад өрийн үлдэгдэл

Үзүүлэлт	3/31/2018	3/31/2019	YoY, %	%2*
Нийт гадаад өр	27.9	29.5	6%	100%
I. Засгийн газар	7.2	7.3	0%	25%
II. Төв банк	2.1	2.1	-3%	7%
III. Банк	2.3	2.4	2%	8%
Богино хугацаат	0.8	0.8	1%	
Урт хугацаат	1.6	1.6	2%	
IV. Бусад сектор	7.9	8.4	6%	28%
Богино хугацаат	0.7	0.6	-5%	
Урт хугацаат	7.3	7.8	7%	
V. Хөрөнгө оруулагч зээл	8.2	9.4	14%	32%

*Нийтэд эзлэх %



Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2019 оны 1 дүгээр улиралд 2,393 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3%-иар буюу 47 сая ам.доллараар буурчээ. Уг салбарын гадаад өрийн 41 хувийг урт хугацаат зээл, 27 хувийг бонд, өрийн бичиг, 16 хувийг богино хугацаат зээл, үлдсэн 16 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.


Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр 2019 оны 1 дүгээр улирлын эцэст 17,794 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,614 сая ам.доллараар өссөн дүнтэй байна. Салбарын нийт зээлийн 53 хувь буюу 9.4 тэрбум ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл (компани хоорондын зээллэг) байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

МУ-ын нийт гадаад өр/ДНБ-ий харьцаа (**224%**) нь тухайн улсын өрийн эргэн төлөх чадварыг эдийн засгийн үйл ажиллагааных нь хүрээнд хэмждэг үзүүлэлт юм.

МУ-ын нийт гадаад өр/Экспорт (**369%**) нь гадаад өрийн хэмжээг бараа, үйлчилгээний экспортын хэмжээний хувьд хэмжиж, өрийн дарамтыг тухайн улсын гадаад орлогын үндсэн эх үүсвэрт нь харьцуулдаг.

МУ-ын нийт гадаад өр/Төсвийн орлогын харьцаа (**809%**) нь тухайн Засгийн газрын (ялангуяа төсөвт гадаад өрийн дарамт өндөр байгаа үед) дотоодоосоо орлого бий болгох чадамжийг харуулдаг.

Зураг 48. Гадаад өрийн үлдэгдэл




ШИГТГЭЭ 7. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР

Улс орнууд дэд бүтцийн болон урт хугацааны өгөөжтэй төслүүдэд хөрөнгө оруулж эдийн засгийн дунд, урт хугацааны өсөлтийг дэмжих зорилгоор гадаад зах зээлээс зээлээр буюу өр хэлбэрээр санхүүжилт татах нь гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлдэг. Харин гадаад өрийг төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зарцуулбал эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж эхэлдэг байна. Учир нь гадаад өр тогтмол нэмэгдэж, цаашид өрийн тогтвортой байдлыг хадгалах боломжгүй үед экспортын орлогын нэлээдгүй хувийг гадаад өрийн үйлчилгээнд зарцуулах тул экспортын орлогоор дотоод хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдаж эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлдэг байна (З.Оюунцацрал, et al., 2015). Тухайлбал, хөгжиж буй орнуудын туршлагаас²¹ харахад гадаад өрийн хэмжээ нийт экспортын 160-170 хувь, ДНБ-ий 35-40 хувиас хэтэрвэл эдийн засагт үзүүлэх дундаж нөлөө нь сөрөг болж эхэлдэг байна. Мөн гадаад өрийн хэмжээ 2 дахин нэмэгдэхэд нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт ойролцоогоор 0.5-1.0 нэгж хувиар буурдаг байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ дунд, урт хугацаанд тогтворжуулж бууруулахад бодлогын түвшинд анхаарах асуудал болоод байна. Гадаад өрийн хэмжээ 2019 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 29.5 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 224 хувь, нийт экспортын 430 хувьтай тэнцэж байна. Эдгээр харьцаа үзүүлэлтүүд нь С. Pattilo (2002) нарын судалгаанд дурдсан гадаад өрийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж эхлэх босго утгуудаас 3-5 дахин өндөр байна.

Зураг 49. Гадаад өрийн үлдэгдэл



²¹ Хөгжиж буй 93 орны 1969-1998 оны тоон мэдээнд үндэслэсэн судалгааны үр дүн (Pattillo, et al., 2002)

	2010	2012	2016	2018	2018Q1	2019Q1
Нийт гадаад өр	7,128	17,211	24,625	28,715	27,905	29,522
Нийт гадаад өр/ДНБ	98%	140%	221%	221%	239%	224%
Нийт гадаад өр/Экспорт	245%	393%	513%	438%	465%	430%
Засгийн газар	1,882	3,599	4,867	7,184	7,242	7,262
<i>Өрийн бичиг</i>	114	1,587	2,064	2,946	3,340	2,970
<i>Зээл</i>	1,767	2,012	2,805	4,238	3,902	4,293
Төв банк	274	572	1,791	2,030	2,137	2,072
Хадгаламжийн байгууллага	512	1,176	2,417	2,230	2,347	2,393
Бусад салбарууд	1,474	2,836	8,122	8,042	7,944	8,385
Шууд хөрөнгө оруулалт	2,986	9,028	7,426	9,228	8,235	9,409

Нийт гадаад өр 2010 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлын түвшнээс хоёр дахин нэмэгдэж, түүнээс хойш тасралтгүй өссөн нь голлон уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой²². Харин 2012 оны эцэст Монгол Улсын Засгийн газар 500 сая ам.долларын *Чингис 500* бонд, 1 тэрбум ам.долларын *Чингис 1000* бондыг гадаад зах зээлд гаргаснаар Засгийн газрын гадаад өр нэмэгдэж, нийт гадаад өрийг огцом нэмэгдүүлжээ.

Төсвийн алдагдал өндөр байсан 2015-2016 онд Засгийн газар гадаад өрийг дахин санхүүжүүлэхээр өндөр хүүтэй *Мазаалай*, *Дим Сам* бондуудыг гаргасан²³ нь Монгол Улсын өрийн дарамтыг нэмэгдүүлж, улмаар олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд манай улсын зээлжих зэрэглэлийг дараалан бууруулж байв²⁴. Түүнчлэн энэ үед уул уурхайн салбарын экспортын орлого саарч гадаадын шууд хөрөнгө оруулалт хумигдах болсон бөгөөд Оюу толгой компани шууд хөрөнгө оруулалтаар бүртгэгдэж байсан хөрөнгө оруулагчийн зээлээ энгийн нөхцөлтэй гадаад зээл болгож хөрвүүлсэн нь 2016 оны 2 дугаар улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалт тус хэмжээгээр буурч, бусад салбарын гадаад өр нэмэгдэхэд хүргэжээ (Зураг 49).

Засгийн газар 2017 онд Хуралдай, Гэрэгэ бондуудыг гаргасан нь гадаад өрийг дахин нэмэгдүүлсэн хэдий ч 2018 онд Дим Сам бондын өрийг төлснөөр Засгийн газрын гадаад өрийн жилийн өсөлтийн хурд сүүлийн улирлуудад саарч, нийт гадаад өрийн өсөлтөд үзүүлэх нөлөө нь буурч байна. Харин Төв банкны гадаад өр 2011 оноос хойш аажмаар өсч ирсэн нь Хятадын Ардын Банк (ХАБ)-тай хийсэн “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своц хэлцэл”-ийн хүрээнд

²² 2010 онд уул уурхайн салбарт орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн өмнөх оноосоо 463 хувиар өсч байв. (Монгол Улсын Гадаад Секторын Тойм, Монголбанк, 2010 он)

²³ Сангийн яамны мэдээлснээр МУ-ын Засгийн газар 2012 онд *Чингис* бондыг 4.1-5.1 хувийн хүүтэйгээр гадаад зах зээлд гаргаж байсан бол 2015 онд *Дим Сам* бондыг 7.5 хувийн хүүтэйгээр, 2016 онд *Мазаалай* бондыг 10.9 хувийн хүүтэй гаргасан.

²⁴ Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдиз агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийг 2016 оны 8 ба 11 дүгээр саруудад дараалан бууруулж “Саал” хэмээн үнэлж байсан бол Фитч агентлаг 2016 оны 11 сард зээлжих зэрэглэлийг бууруулж, “В-” үнэлгээг өгч байв.

авсан зээлтэй холбоотой байна²⁵. Арилжааны банкуудын гадаад өрийн өсөлтийн хурд 2012 оноос хойш саарах хандлагатай байгаа бөгөөд 2017 онд нийт гадаад өрийг бууруулах нөлөөг үзүүлж байв. Харин 2018 оноос манай улсын зээлжих зэрэглэл эргэн сайжирч, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж эхэлсэн нь нийт гадаад өрийн өсөлтийг тайлбарлаж байна.

Монгол Улс 2020-2024 онд 13.5 тэрбум ам.долларын гадаад өрийг эргэн төлөх үүрэгтэй бөгөөд энэ нь гадаад валютын албан нөөцөөс²⁶ 3.6 дахин өндөр үзүүлэлт юм. Иймд гадаад өрийн эргэн төлөлтийг өндөр хүүтэй бондоор дахин санхүүжүүлэх эрсдэл өндөр байгаа нь эдийн засаг дахь гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

²⁵ 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Төв банкны гадаад өрийн 85 орчим хувийг ХАБ-тай хийсэн своп хэлцлийн дүн эзэлж байна (Монголбанк).


²⁶ Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2019 оны 5 дугаар сарын байдлаар 3.7 тэрбум ам.доллар байна (Монголбанк).

VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


7.1. Санхүүгийн салбар

Манай улсын санхүүгийн салбар нь банкны сектор давамгайлсан бүтэцтэй бөгөөд 2019 оны 6 дугаар сарын байдлаар санхүүгийн салбарт нийт 13 банк, 538 банк бус санхүүгийн байгууллага, 275 хадгаламж зээлийн хоршоо, 18 даатгалын компани, 52 даатгалын зуучлагч, Даатгалын хохирол үнэлэгч 26 компани үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж буй боловч санхүүгийн зах зээлд банкны салбартай харьцуулахад бага хувь (нийт санхүүгийн салбарын активын 6 орчим хувь)-ийг эзэлсэн хэвээр байгаа юм.

Зураг 50. ДНБ-д эзлэх салбаруудын хувь хэмжээ



Зураг 51. Санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ /2019 оны 2 дугаар улирал, активын хэмжээгээр/



ББСБ-ын нийт хөрөнгө 2019 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өсч 1.5 их наяд төгрөгт хүрчээ. Түүнчлэн ББСБ-ын зээлийн багц өмнөх оны мөн үеэс 42.7 хувиар буюу 328.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгийн өсөлтийн 84.3 хувийг тайлбарлаж байна. ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдлийн 87.2 хувь нь хэвийн, 3.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл ба 8.9 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.6 болон 1.6 нэгж хувиар тус тус буурсан дүнтэй байна.

2019 оны 2 дугаар улирлын байдлаар Хадгаламж, зээлийн хоршоодын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.5 хувиар өсч 210.5 тэрбум төгрөгт, ХЗХ-дын нийт зээлийн үлдэгдэл 16.6 хувиар өсч 156.4 тэрбум төгрөгт тус тус хүрсэн. ХЗХ-дын нийт зээлийн багцын 92.8 хувийг хэвийн, 3.1 хувийг хугацаа хэтэрсэн, 4.1 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна.

Даатгалын салбарт 2019 оны 2 дугаар улиралд ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, давхар даатгалын 2 компани нийт 18 даатгагч үйл


ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 354.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар өссөн байна. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ олон улстай харьцуулахад доогуур байна. 2019 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.64 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.08 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 104 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс ердийн даатгалын компаниуд 102.9 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 0.7 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 0.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлэв. Даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 24.8 хувьтай тэнцүү буюу 25.7 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт олгосон байна.

2019 оны 2 дугаар улиралд хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 376.9 сая ширхэг хувьцааг 82.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 79.8 мянган ширхэг үнэт цаасыг 7.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 90.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2,604.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 119.9 тэрбум төгрөгөөр буюу 4.8 хувиар өсчээ.

Хүснэгт 16. Банкнаас бусад санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2019 оны 2 дугаар улирлын байдлаар, тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	ББСБ	ХЗХ	Даатгал
Актив	1533.1	210.5	354.7
Өр төлбөр	377.9	174.2	180.6
Эзэмшигчдийн өмч	1155.2	36.3	174.1
Зээлийн өрийн үлдэгдэл	1096.7	156.4	-
Чанаргүй зээл	97.4	6.4	-
Тайлант үеийн ашиг	64.3	2.9	12.6
Даатгалын хураамжийн орлого	-	-	104.0
Даатгалын нөхөн төлбөр	-	-	25.7

Зураг 52. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ



7.2. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв


Банкны салбарт 2019 оны 6 дугаар сарын байдлаар нийт 13 банк, 1,405 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн тоо 2.7 саяд, зээлдэгчдийн тоо 1.02 саяд хүрлээ. Капитал банкныг

татан буулгасан нь банкны салбар, нэгж болон хадгаламж эзэмшигчийн тоо буурахад нөлөөллөө.

Активын бүтэц, өөрчлөлт

Банкны салбарын нийт активын хэмжээ 2019 оны эхний хагаст 34.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 14.5 хувиар буюу 4.4 их наяд төгрөгөөр өслөө. Үүнд зээл 2.7 их наяд төгрөг, мөнгөн хөрөнгө 1.9 их наяд төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн бол сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байсан Төв банкны үнэт цаасанд (ТБҮЦ) оруулсан хөрөнгө оруулалт анх удаа саармагжлаа. Монгол Улсын Засгийн газар улсын секторын дотоод өрийг бууруулах бодлогын нөлөөгөөр банкуудын тэнцэлд байгаа Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) үргэлжлэн буурлаа.

Зураг 53. Активын бүтэц, өсөлт (их наяд төгрөгөөр)




Нийт активыг бүтцээр нь авч үзвэл 48.5 хувь нь зээл, 21.3 хувь нь мөнгөн хөрөнгө, 13.7 хувь нь Төв банкны үнэт цаас, 4.3 хувь нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 12.2 хувь нь бусад төрлийн хөрөнгө байна. Активын бүтцэд гарсан өөрчлөлтөөс харахад зээлийн нийт активт эзлэх хувь 2018 оноос эхлэн өсөх хандлагатай байгаа бол Засгийн газрын үнэт цаасны эзлэх хувь үргэлжлэн буурч байна.

Зээл, түүний өсөлт

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны эхний хагас жилд 18.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар өслөө. Энэхүү өсөлтийг зээлдэгчийн төрлөөр нь салгаж үзвэл иргэдийн зээл 24.8 хувь буюу 1.8 их наяд төгрөгөөр, байгууллагын зээл 10.9 хувь буюу 949.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Иргэдийн зээлийн өр-орлогын харьцааг хязгаарлах макро зохистой бодлогын арга хэмжээг 2019 оны эхнээс авах болсонтой холбоотойгоор 2018 оны төгсгөлд хэрэглээний зээл олголт огцом нэмэгдсэн бөгөөд иргэдийн зээлийн өсөлт энэ онд хурдтай саарч байна.

Харин байгууллагын зээлийн өсөлтийг аж ахуйн нэгжийн хэмжээгээр задлахад жилийн 1 тэрбум төгрөгөөс их борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн зээл өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар буюу 966.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол түүнээс жижиг бизнесийн зээл 0.9 хувиар буурчээ.


Зураг 54. Зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), өсөлт



Өнгөрсөн нэг жилийн хугацааны зээлийн өсөлт нь иргэдийн хэрэглээг дэмжих, үндсэн хөрөнгө худалдан авах болон томоохон бизнесийг санхүүжүүлэх зээл нэмэгдсэн бол эсрэгээрээ жижиг, дунд бизнесийн зээл олголт хязгаарлагдмал байжээ.

Харин зээл олголтыг эдийн засгийн сектороор авч үзэхэд иргэдийн хэрэглээ болон худалдааны салбарын зээл ойролцоогоор 30 хувиар нэмэгдэж, боловсруулах үйлдвэрлэлийн зээл 10 хувиар буурчээ. Өөрөөр хэлбэл, манай улсын эдийн засагт зээлээр хэрэглээ, худалдан авалтыг санхүүжүүлэх хандлагатай байна.


Зураг 55. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), нийт зээлд эзлэх хувь, жилийн өсөлт



Зээлийн чанар


Тайлант сарын эцэст нийт зээлийн 84.5 хувь буюу 15.4 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 5.8 хувь буюу 1.1 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 8.7 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагджээ.

Зураг 56. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр), тэдгээрийн нийт зээлд эзлэх хувь



Эдийн засаг сэргэж, өсөлт тогтворжиж байгаа боловч эргэн төлөлтийн доголдолтой зээлийн хэмжээ буурахгүй байна. Тухайлбал, банкны салбарын анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл өмнөх жилийн мөн үеэс 26.0 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 41.2 хувиар тус тус өслөө. Чанаргүй зээл өсөхөд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээлийн чанар үргэлжлэн муудаж байгаа нь томоохон нөлөө үзүүлсэн байна. Харин орон сууцны борлуулалттай холбоотойгоор барилгын салбарын зээлийн чанар өнгөрсөн хугацаанд тасралтгүй муудаж байсан бол 2019 оны 6 дугаар сард энэ хандлага анх удаа өөрчлөгдлөө.

Зураг 57. Тухайн салбар дахь чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн хувь




Эх үүсвэрийн бүтэц, өөрчлөлт

